

**НИЙГМИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**  
*2024 оны 05 дугаар сарын 15-ны өдөр, Лхагва гараг*

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	0
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	1-34
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	35-88
<hr/>	
<b>1. Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Монгол Улсын Ерөнхийлөгч 2024.04.15-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</b>	35-36
<b>2. Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд нарын 13 гишүүн 2024.05.02-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</b>	36-56
<b>3. Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Засгийн газар 2024.05.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</b>	56-83
<b>4. Байнгын хорооны тогтоолын төсөл /Монгол Улсын Их Хурлын хаврын ээлжит чуулганы 2024 оны 05 дугаар сард Нийгмийн бодлогын байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай/</b>	83-84
<b>5. Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамишуулах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Монгол Улсын Ерөнхийлөгч 2024.05.13-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/</b>	84-88

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы  
Нийгмийн бодлогын байнгын хорооны  
05 дугаар сарын 15-ны өдөр /Лхагва гараг/-ийн  
хуралдааны товч тэмдэглэл**

Нийгмийн бодлогын байнгын хорооны дарга П.Анужин ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 17 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 58.8 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 46 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Б.Бейсен, С.Ганбаатар, Ц.Туваан;  
Чөлөөтэй: Б.Баярсайхан, Д.Батлут, Ц.Мөнх-Оргил.

**Нэг.Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Монгол Улсын Ерөнхийлөгч 2024.04.15-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхийлөгчийн Аюулгүй байдал, батлан хамгаалах бодлогын зөвлөх Д.Баасандамба, Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга С.Ганбямба, Хил хамгаалах ерөнхий газрын дарга Х.Лхагвасүрэн, Онцгой байдлын ерөнхий газрын дарга Г.Ариунбуян, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын Хуулийн бодлогын газрын ахлах референт Г.Сувдаа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх М.Отгон, мөн газрын референт Г.Нямсүрэн, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Нийгмийн бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Цогзолбаяр нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

Төслийн 1, 2, 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Сарангэрэлийн тавьсан асуултад Монгол Улсын Ерөнхийлөгчийн Аюулгүй байдал, батлан хамгаалах бодлогын зөвлөх Д.Баасандамба хариулж, тайлбар хийв.

**П.Анужин:** Улсын Их Хурлын гишүүн П.Анужингийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4 дүгээр зүйл.Энэ хуулийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 4  
Бүгд: 11  
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалмаа Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 10 цаг 54 минутад хэлэлцэж дуусав.*

***Хоёр.Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд нарын 13 гишүүн 2024.05.02-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяа, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн халамжийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Ундрал, мөн яамны Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын шинжээч Ю.Отгонбилэг, Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Ахмад настны хөгжлийн бодлогын хэрэгжилт хариуцсан мэргэжилтэн Ө.Гэрэлт-Од, Сангийн яамны Төсвийн зарлагын хэлтсийн дарга П.Бат-Эрдэнэ, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын ахлах мэргэжилтэн Д.Баясгалан, Эрүүл мэндийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын шинжээч С.Жаргалсайхан, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын Тусламж, үйлчилгээний багц, зохицуулалтын хэлтсийн дарга Б.Баярболд, Хүний эрхийн Үндэсний Комиссын Тамгын газрын Судалгаа, дүн шинжилгээний хэлтсийн дарга С.Тунгалагтамир, Төрийн албаны зөвлөлийн ажлын албаны референт Д.Наран-Отгон, “Юзисан партнерс” хуулийн фирмийн зөвлөх хуульч Н.Энхбат нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Д.Нямбаяр, мөн газрын референт Г.Нямсүрэн, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Нийгмийн бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Цогзолбаяр нар байлцав.

Хуулийн төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн санал, дүгнэлтийг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Д.Сарангэрэл танилцуулав.

Ажлын хэсгийн санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэгийн тавьсан асуултад Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн халамжийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Ундрал, мөн яамны Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын шинжээч Ю.Отгонбилэг нар хариулж, тайлбар хийв.

*Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг зүйл бүрээр хэлэлцэв.*

**1.Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Чинзориг, М.Оюунчимэг, Б.Жаргалмаа нарын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Д.Сарангэрэл, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн халамжийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Ундрал, мөн яамны

Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын шинжээч Ю.Отгонбилэг нар хариулж, тайлбар хийв.

Төслийн 2, 3, 4, 5, 6, 7 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

*Ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.*

**П.Анужин:** 1.Улсын Их Хурлын гишүүн Д.Сарангэрэл, Б.Жаргалмаа, Ц.Сандаг-Очир /цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтын 7.1.11 дэх заалтын “дасгал хөдөлгөөн,” гэсний өмнө “зөв хооллолт,” гэж нэмж, тус заалтын “эрүүл мэнд, нийгмийн оролцоог” гэснийг “эрүүл мэндийг” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 5  
Бүгд: 11  
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалтын 7.2.9<sup>1</sup>, 7.2.11 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 7.2.9<sup>1</sup> дэх заалтын дугаарыг 7.2.13 дахь заалт болгох:

“7.2.13.ахмад настныг нийгмийн харилцаанд идэвхтэй оролцуулах, соёл, урлаг, спорт, орчин үеийн техник хэрэгсэл ашиглах, сурч хөгжихөд чиглэсэн үйл ажиллагааг дэмжих, зохион байгуулах;

7.2.11.аймаг, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага, сум, хорооны нийгмийн ажилтан, өрх, сум, тосгоны эмч, эмнэлгийн мэргэжилтэн байнгын асаргаа шаардлагатай ахмад настныг асарч байгаа иргэний эрүүл мэнд, ачааллыг үнэлэн ахмад настныг энэ хуулийн 4.1.9-д заасан үйлчилгээнд хамруулах, эсхүл гэр бүлийн бусад гишүүдийн асрамжид шилжүүлэх талаар санал гаргах;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 5  
Бүгд: 11  
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалтын 7.2.12, 7.2.13 дахь заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 4  
Бүгд: 11  
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалтын 7.8 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“7.8.Төрийн болон орон нутгийн өмчит барилга байгууламжид энэ хуулийн 7.6-д заасан “Ахмадын өргөө” болон бусад төв байрлан үйл ажиллагаагаа явуулж байгаа бол барилга байгууламж, хөдлөх хөрөнгийн ашиглалт, засварын зардлыг гэрээний үндсэн дээр орон нутгийн төсвөөс хэсэгчлэн, эсхүл бүрэн санхүүжүүлж болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 4  
Бүгд: 11  
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 5 дахь заалтын 9.1.4, 9.1.5, 9.1.6 дахь заалтыг нэгтгэн доор дурдсанаар өөрчлөн найруулж, 9.13 дахь хэсэг болгох:

“9.13.Хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн холбогдох Засгийн газрын гишүүнтэй хамтран дараах чиглэлээр арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлнэ:

9.13.1.хөдөлмөрийн болон боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран ахмад настныг боловсролын байгууллагад ажиллуулах;

9.13.2.хөдөлмөрийн болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран ахмад настныг эрүүл мэндийн байгууллагад ажиллуулах;

9.13.3.хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн холбогдох Засгийн газрын гишүүнтэй хамтран эрхлэх асуудлын хүрээнд ахмад настныг ажиллуулах.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8  
Татгалзсан: 3  
Бүгд: 11  
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 5 дахь заалтын 9.1.7 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 9.1.4 дэх заалт болгох:

“9.1.4.хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээний хүрээнд ажилласан ахмад настны цалин хөлсийг Хөдөлмөрийн тухай хуулийн 104 дүгээр зүйлд заасны дагуу тооцон гэрээний дагуу олгох.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 4  
Бүгд: 11  
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 6 дахь заалтын 9.9 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах

“9.9.Ахмад настан хөдөлмөрийн гэрээ, ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах болон тэдгээртэй адилтгах гэрээний дагуу ажиллаж байгаа бол Нийгмийн даатгалын ерөнхий

хуулийн 7 дугаар зүйлийн 7.6-д заасны дагуу тэтгэврийн даатгалын төрөлд даатгуулахгүй байж болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Чинзориг үг хэлэв.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 5  
Бүгд: 11  
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 6 дахь заалтын 9.11 дэх хэсгийн “өөрөө хүсэлт гаргаагүй” гэсний өмнө “65 насанд хүрээгүй бөгөөд” гэж нэмж, 9.12 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 9.11, 9.12 дахь хэсгийн дугаарыг 9.10, 9.11 дэх хэсэг болгох:

“9.12.Аж ахуйн нэгж, байгууллага Хөдөлмөрийн тухай хуулийн 145 дугаар зүйлийн 145.4-т заасны дагуу ахмад настныг ажлын байраар хангана.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 5  
Бүгд: 11  
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 6 дахь заалтын 9.10 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 5  
Татгалзсан: 6  
Бүгд: 11  
45.5 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяагийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**П.Анужин:** Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяагийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 5  
Бүгд: 11  
54.5 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

**П.Анужин:** Горимын санал дэмжигдсэн тул дээрх дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 5  
Бүгд: 11  
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 7 дахь заалтын 11.1.4 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“11.1.4.ахмад настнаа хүндлэх, ёс заншил, уламжлалаа өвлүүлэх, мэдлэг, туршлагыг залуу үед хүргэх зэрэг арга хэмжээг ахмадын өдрийн хүрээнд бүх шатны Засаг дарга, аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагууд 10 дугаар сарын 01-нээс 07-ны өдрүүдэд зохион байгуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 4  
Бүгд: 10  
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

11.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 8 дахь заалтын 13.6, 13.7, 13.9, 13.11 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 13.5, 13.6, 13.8, 13.9 дэх хэсэг болгох:

“13.5.Нийгмийн халамжийн сан, орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх энэ хуулийн 7.1.1-7.1.5, 7.1.7-7.1.11-д заасан үйлчилгээний жишиг үнэ болон иргэний хариуцах төлбөрийн хэмжээг нийгмийн хамгааллын болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран баталж, хэрэгжүүлнэ.”

13.6.Энэ хуулийн 7.1.1-7.1.5, 7.1.7-7.1.11-д заасан үйлчилгээнд зарцуулах хөрөнгө нийгмийн халамжийн сангаас ахмад настанд зориулан зарцуулах нийт хөрөнгийн 10 хувиас багагүй байна.

13.8.Энэ хуулийн 9.13-д заасан арга хэмжээний зардлыг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан, боловсрол, эрүүл мэндийн болон холбогдох асуудал эрхэлсэн төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад тусган санхүүжүүлнэ.

13.9.Энэ хуулийн 7.1, 8.1.1, 8.1.2, 10.1.2, 10.2-т заасан үйлчилгээг цахимжуулах, давхардлыг арилгах, гэрээт байгууллагын санхүүжилтийг гүйцэтгэлд үндэслэн бодитоор олгох зорилгоор ахмад настны Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д заасан мэдээллийг ашиглаж болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 4  
Бүгд: 10  
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

12.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 8 дахь заалтын 13.5, 13.10 дахь хэсгийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 4  
Бүгд: 10  
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

13.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 9 дэх заалтын 14.9 дэх хэсгийн “ахмадын сангийн үйл ажиллагааг хэрэгжүүлсэн байдал” гэснийг “Ахмадын сан”-

ийн үйл ажиллагааны тайлан” гэж, “харьяалагдах дээд байгууллагадаа тайлагнаж, хамт олондоо мэдээлнэ.” гэснийг “байгууллагын нийт ажилтны хуралд танилцуулж, хэлэлцүүлнэ.” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 3  
Бүгд: 10  
70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

14.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 9 дэх заалтын 14.10, 14.11 дэх хэсгийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 4  
Бүгд: 10  
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

15.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 10 дахь заалтын 15.9 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 15.5 дахь хэсгийн “үзүүлэх” гэснийг “үзүүлж” гэж, “ахмадын мэдээллийн санг бүрдүүлэн, баяжуулж, дүгнэлт гаргана” гэснийг “хяналт тавина” гэж өөрчилж, мөн хэсгийн “дэмжлэг үзүүлэх, оролцох, хяналт тавих, хөдөлмөр эрхлэлтэд” гэснийг хасаж, 15.5, 15.9 дэх хэсгийн дугаарыг 15.4, 15.7 дахь хэсэг болгох:

“15.7.Аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллага 50 ба түүнээс дээш ахмад настантай бол ахмадуудтайгаа харилцах үндсэн чиг үүрэгт зөвлөх болон туслах үүрэгтэйгээр ахмад настныг төлөөлсөн нэг хүнийг гэрээгээр ажиллуулж болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 4  
Бүгд: 10  
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

16.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 10 дахь заалтын 15.4, 15.7 дахь хэсгийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8  
Татгалзсан: 2  
Бүгд: 10  
80.0 хувийн саналаар дэмжигдлээ.

17.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 11 дэх заалтын 16.3 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 5  
Татгалзсан: 5  
Бүгд: 10  
50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.



Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэнгийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**П.Анужин:** Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэнгийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 3  
Бүгд: 10  
70.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

**П.Анужин:** Горимын санал дэмжигдсэн тул дээрх дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулья.

Зөвшөөрсөн: 8  
Татгалзсан: 2  
Бүгд: 10  
80.0 хувийн саналаар дэмжигдлээ.

18.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “болон ахмад настны өмчлөлийн байр, орон сууц, газар, бусад эд хөрөнгө, тэтгэвэр, мөнгөн хөрөнгийг нь түүний зөвшөөрөлгүйгээр болон айлган сүрдүүлэх, дарамт, шахалт үзүүлэн хүч хэрэглэн авч ашиглах зэргээр” гэснийг “ахмад настны тэтгэвэр, тэтгэмж, Иргэний хуулийн 84 дүгээр зүйлд заасан хөрөнгийн эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд халдсан,” гэж өөрчилж, “7 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 7.2.5 заалтын “үйл ажиллагааг” гэсний өмнө “болон ахмад настны сайн дурын” гэж” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 4  
Бүгд: 10  
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

19.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 2 дахь заалтын 7.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“7.3.Энэ хуулийн 4.1.7-4.1.9, 4.1.11, 7.1-д заасан үйл ажиллагааны журмыг дараах байдлаар баталж, иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлнэ:

7.3.1.энэ хуулийн 4.1.7-4.1.9, 4.1.11-д заасан үнэлгээ хийх, үйлчилгээ үзүүлэх, мэргэжлийн удирдлагаар хангах, энэ хуулийн 7.1-д заасан үйлчилгээ үзүүлэх, иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагыг сонгон шалгаруулах журмыг нийгмийн хамгааллын болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран баталж, хэрэгжүүлэх;

7.3.2.энэ хуулийн 7.1.6, 7.1.12-г заасан үйлчилгээг тусгай зөвшөөрөлтэй, магадлан итгэмжлэгдсэн, эрүүл мэндийн даатгалын байгууллагатай гэрээ байгуулсан эрүүл мэндийн байгууллагаар гүйцэтгүүлэх;

7.3.3.Энэ хуулийн 7.1.1-7.1.5, 7.1.7-7.1.11-д заасан үйлчилгээг аймаг, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага 7.3.1-д заасан сонгон шалгаруулах журмын дагуу гэрээний үндсэн дээр иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8  
Татгалзсан: 2  
Бүгд: 10  
80.0 хувийн саналаар дэмжигдлээ.

20.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 2 дахь заалтын 7.6 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“7.6.Энэ хуулийн 7.1-д заасан үйлчилгээг үзүүлэх зорилгоор нутгийн захиргааны байгууллага, иргэн, аж ахуйн нэгж, байгууллага аймаг, дүүрэг, сум, тосгон, хороонд “Ахмадын өргөө”, сэргээн засах, идэвхтэй насжилтыг дэмжих чиглэлээр үйл ажиллагаа явуулах төвийг байгуулан ажиллуулж болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 3  
Бүгд: 10  
70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

21.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 3 дахь заалтын 8.1.1 дэх заалтын “эрүүл мэндийн даатгалын сангаас олгох” гэснийг “нийгмийн халамжийн сангаас олгох” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 4  
Бүгд: 10  
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

22.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 4 дэх заалтын 15.1, 15.2 дахь хэсгийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 3  
Бүгд: 10  
70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

23.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн “үйлчилгээ, дэмжлэг хүндэтгэлийн хэмжээ” гэснийг “Хоёрдугаар бүлэгт заасан ахмад настанд үзүүлэх үйлчилгээ, дэмжлэг, хүндэтгэлийн хэмжээ” гэж, “дэмжлэгийн хэмжээ” гэснийг “8, 10-12 дугаар зүйлд заасан ахмад настанд үзүүлэх дэмжлэгийн хэмжээ” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8  
Татгалзсан: 2  
Бүгд: 10  
80.0 хувийн саналаар дэмжигдлээ.

24.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 5 дугаар зүйлээс “13 дугаар зүйлийн 13.3 дахь хэсгийн “7.1-д заасан үйлчилгээ”” гэснийг хасаж, төслийн 4 дүгээр зүйлийн “тус тус” гэсний өмнө “, 13 дугаар зүйлийн 13.3 дахь хэсгийн “7.1-д заасан үйлчилгээ” гэснийг “7.1.1-7.1.5, 7.1.7-7.1.11-д заасан үйлчилгээг нийгмийн халамжийн сан болон орон нутгийн төсвөөс” гэж” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 3  
Бүгд: 10  
70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

### **Найруулгын санал:**

**П.Анужин:** 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 4.1.9 дэх заалтын “иргэн” гэсний өмнө “төрийн байгууллага” гэж нэмэх.

2.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 4.1.8 дахь заалтын “цогцоор” гэснийг “цогц үйлчилгээ” гэж, 4.1.9 дэх заалтын “өдрөөр, түр, урт хугацаанд байрлуулан асрах, байнга асрах төрөлжсөн асрамжийн, асралт гэр бүлээр асруулах, гэрээр асрах зэрэг бусад шаардлагатай үйлчилгээг” гэснийг “ахмад настныг төрөлжсөн асрамжийн, гэрээр, асралт гэр бүлээр, өдрөөр, түр, урт хугацаагаар, байнга асрах үйлчилгээг” гэж, 4.1.11 дэх заалтын “онол, арга зүй, мэргэшлийн хувьд удирдан чиглүүлэх, дэмжих, зөвлөн туслах, хөгжүүлэх” гэснийг “мэргэшүүлэх, үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, удирдлагаар хангах” гэж, 1 дүгээр зүйлийн 3 дахь заалтын 7.2.14 дэх заалтын “зарим” гэснийг “шаардлагатай” гэж, 1 дүгээр зүйлийн 8 дахь заалтын 13.8 дахь хэсгийн “зээлийн зардлыг оруулахгүйгээр” гэснийг “зээлийн хэмжээг тооцохгүйгээр” гэж, 1 дүгээр зүйлийн 10 дахь заалтын 15.3 дахь хэсгийн “хэсэгчлэн болон бүрэн” гэснийг “хэсэгчлэн, эсхүл бүрэн” гэж, 2 дугаар зүйлийн “төсвийн байгууллага, тухайн жилийн төсвийн зардалдаа тусган” гэснийг “төсвийн байгууллага, тухайн жилийн төсөвт тусган” гэж, 3 дугаар зүйлийн 3 дахь заалтын 8.1.6 дахь заалтын “үнэ төлбөргүй зорчих” гэснийг “ахмад настны нийтийн тээврээр зорчсон” гэж тус тус өөрчлөх.

3.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 4.1.9 дэх заалтын “төрийн бус” гэсний өмнөх “төрийн болон” гэснийг, 1 дүгээр зүйлийн 3 дахь заалтын “орох бөгөөд үнэлгээг хийхдээ ахмад настанд чирэгдэлгүй байхыг анхааран” гэснийг, 2 дугаар зүйлийн “хөнгөлөлтийн” гэснийг тус тус хасах.

4.Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн бүтэц, нэр томъёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл, заалтын дугаар, эшлэлийг нийцүүлж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 3  
Бүгд: 10  
70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

### **2.Хөдөлмөрийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

Төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

**3.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

Төслийн 1, 2, 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

**4.Нийгмийн халамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

Төслийн 1, 2, 3, 4, 5 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**П.Анужин:** 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 19.12 дахь хэсгийн “хэмжээ,” гэсний өмнө “хэлбэр,” гэж нэмж, 19.14 дэх хэсгийн “19.11-д заасны дагуу ахмад настныг төрөлжсөн асрамжийн үйлчилгээнд хамруулж байгаа” гэснийг “9.1.1-д заасан үйлчилгээг ахмад настанд үзүүлж байгаа” гэж, “хувийн хэвшил, төрийн бус байгууллагад” гэснийг “аж ахуйн нэгж, байгууллагад” гэж, “заасан нормативын дагуу” гэснийг “заасны дагуу” гэж, “гооцох бөгөөд” гэснийг “гооцох” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 4  
Бүгд: 10  
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 19.15 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 3  
Бүгд: 10  
70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

**Найруулгын санал:**

**П.Анужин:** 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 19.11. дэх хэсгийг “хувийн хэвшил, төрийн бус байгууллагад” гэснийг “аж ахуйн нэгж, байгууллагад” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 5  
Татгалзсан: 5  
Бүгд: 10  
50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Байнгын хорооны дарга П.Анужингийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**П.Анужин:** Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 3  
Бүгд: 10  
70.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

**П.Анужин:** Горимын санал дэмжигдсэн тул дээрх дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулья.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 4  
Бүгд: 10  
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

**5.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

Төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**П.Анужин:** 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 15.1.16 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“15.1.16.нийгмийн халамжийн байгууллагатай байгуулсан гэрээний дагуу гүйцэтгэсэн нийгмийн халамж, асрамжийн үйлчилгээний үйл ажиллагааны зардал;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 3  
Бүгд: 10  
70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтын 15.1.17 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“15.1.17.асрамж, халамжийн байгууллага үйл ажиллагаагаа явуулах байрыг шинээр барих, тохижуулах, хүчин чадлыг нэмэгдүүлэх, өргөтгөх зорилгоор үзүүлсэн санхүүгийн дэмжлэг, хандив.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 3  
Бүгд: 10  
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

**6.Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

Төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**П.Анужин:** 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийг хууль санаачлагчид буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8  
Татгалзсан: 2  
Бүгд: 10  
80.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

**7.Компанийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

Төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**П.Анужин:** 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 16.2.8 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“16.2.8."Ахмадын сан" байгуулах, мөнгөн хөрөнгийн хэмжээг тогтоох;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 3  
Бүгд: 10  
70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтын 76.1.19 дэх заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 3  
Бүгд: 10  
70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

**8.Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

Төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**П.Анужин.** Ажлын хэсгийн гаргасан, Төслийг хууль санаачлагчид буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 3  
Бүгд: 10  
70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

## **9. Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

Төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**П.Анужин:** 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 16.1<sup>1</sup> дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 16.21 дэх хэсэг болгох:

“16.21.Энэ хуулийн 15.1.7, 15.1.11, 15.1.13-д заасан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлдэг байгууллагын дэргэд ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд байнгын асаргаа шаардлагатай эсэхийг тодорхойлох, дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий Эмнэлэг хяналтын комисс ажиллуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 3  
Бүгд: 10  
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтын 16.1<sup>2</sup> хэсгийн “дүрэм” гэснийг, “ажиллах журам” гэж, “16.1<sup>2</sup>” дугаарыг, “16.22.” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8  
Татгалзсан: 2  
Бүгд: 10  
80.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

## **10. Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

Төслийн 1, 2, 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**П.Анужин:** 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 11.7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “1.2<sup>1</sup>” дахь заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8  
Татгалзсан: 2  
Бүгд: 10  
80.0 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 11.7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.3. дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1.3.тэтгэвэр, тэтгэмж, хуваарьт болон дундын эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд халдсан бол зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8  
Татгалзсан: 2  
Бүгд: 10  
80.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

### **11.Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

Төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**П.Анужин:** 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 5.4 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн 4.3<sup>1</sup> дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 4.4 дахь заалт болгох:

“4.4.Ахмад настны тэтгэвэр, тэтгэмжээ ашиглах, захиран зарцуулах эрхэд халдсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол албадан сургалтад хамруулж долоогоос гуч хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл оногдуулна;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 3  
Бүгд: 10  
70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

### **12.Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

Төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**П.Анужин:** 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн 35.2.6 дахь заалтын “түр байрлуулах, түр хоноглох зэрэг газар байрлаж байсан” гэснийг, “түр байрлуулах газарт байсан,” гэж, “бөгөөд” гэснийг “тохиолдолд” гэж, “садан” гэснийг, “садангийн хүн” гэж тус тус өөрчилж, тус заалтын “тэнэмэл амьдралтай” гэснийг, “иргэн нас барсан” гэснийг өмнөх “ганц бие” гэснийг, “түүний” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8  
Татгалзсан: 2  
Бүгд: 10  
80.0 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн 35.2.7 дахь заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8  
Татгалзсан: 2



Бүгд: 10  
80.0 хувийн саналаар дэмжигдлээ.

### **Найруулгын санал:**

**П.Анужин:** Ажлын хэсгийн гаргасан, Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн бүтэц, нэр томъёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл, заалтын дугаар, эшлэлийг нийцүүлж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд үг хэлэв.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 1  
Бүгд: 10  
90.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Сарангэрэл Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 12 цаг 15 минутад хэлэлцэж дуусав.*

***Гурав.Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Засгийн газар 2024.05.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Эрүүл мэндийн сайд С.Чинзориг, Эрүүл мэндийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга П.Оюунцэцэг, мөн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын ахлах шинжээч Н.Гэрэлт-Од, мөн газрын Салбарын хууль, эрх зүйн шинэчлэлийн судалгаа, төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн Г.Түвшинбаяр, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ш.Энхтуяа, мөн газрын Лиценз, зөвшөөрлийн зохицуулалтын газрын дарга Л.Зэндмаа, Эм хангамжийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Оюун-Эрдэнэ, Эмнэлгийн тоног төхөөрөмжийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Р.Энхсайхан, Эмийн бүртгэлийн хэлтсийн дарга Т.Мөнхтуул, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын ахлах мэргэжилтэн Д.Баясгалан, Төрийн худалдан авах ажиллагааны газрын дарга Ц.Батзул, Гаалийн ерөнхий газрын Хорио цээрийн хэлтсийн Эм, биобэлдмэлийн хяналт хариуцсан гаалийн улсын байцаагч М.Пүрэвсүрэн, “Эрүүл мэнд реформ” Төрийн бус байгууллагын гишүүн М.Халиунаа, Монголын эм зүйн байгууллагын нэгдсэн “Эм” холбооны гүйцэтгэх захирал И.Балжинням, Монголын эмнэлгийн инженерчлэлийн нийгэмлэгийн тэргүүн М.Бат-Эрдэнэ нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх М.Отгон, мөн газрын референт Г.Нямсүрэн, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Нийгмийн бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Цогзолбаяр нар байлцав.

Хуулийн төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн санал, дүгнэлтийг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн П.Анужин танилцуулав.

Ажлын хэсгийн санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэгийн тавьсан асуултад Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн халамжийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Ундрал, мөн яамны Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын шинжээч Ю.Отгонбилэг нар хариулж, тайлбар хийв.

*Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг зүйл бүрээр хэлэлцэв.*

### **1.Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн талаар:**

Төслийн 20, 41, 47 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Сарангэрэл, Ж.Чинбүрэн, М.Оюунчимэг, С.Чинзориг, Х.Булгантуяа нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн, Эрүүл мэндийн сайд С.Чинзориг, Эрүүл мэндийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга П.Оюунцэцэг нар хариулж тайлбар хийв.

Төслийн бусад зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

*Ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.*

**П.Анужин:** 1.Улсын Их Хурлын гишүүн П.Анужин, Б.Жаргалмаа, М.Оюунчимэг, Д.Сарангэрэл, Ж.Чинбүрэн /цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.10.г дэд заалтыг, мөн зүйлийн 4.1.18 дахь заалтын “, эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүн” гэснийг хасаж, 4.1.27 дахь заалтын “иргэн,” гэсний дараа “гадаад, дотоодын” гэж нэмж, мөн зүйлийн 4.1.14 дэх заалтын “зах зээлд гаргах зөвшөөрөл” гэснийг “эм, эмнэлгийн хэрэгсэл, эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүний бүртгэл” гэж, 4.1.17 дахь заалтын “зах зээлд гаргах зөвшөөрөлтэй” гэснийг “эм, эмнэлгийн хэрэгсэл, эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүний бүртгэлтэй” гэж, 4.1.32 дахь заалтын “, бэлтгэх арга, зааврыг тодорхойлон” гэснийг “хэрэглэх аргыг заан” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	6
Татгалзсан:	3
Бүгд:	9

66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.1.2 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 6.2 дахь хэсгийг хасах:

“6.1.1.эм, уламжлалт эм, биобэлдмэл, тэдгээрийн түүхий эд, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт эм, эмнэлгийн тоног төхөөрөмж, лабораторийн оношилгооны хэрэгсэл, эмнэлгийн хэрэглэгдэхүүн үйлдвэрлэх-экспортлох тусгай зөвшөөрөл;

6.1.2.эм, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт эм, эмнэлгийн тоног төхөөрөмж, лабораторийн оношилгооны хэрэгсэл, эмнэлгийн хэрэглэгдэхүүн импортлох-ханган нийлүүлэх тусгай зөвшөөрөл;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 2  
Бүгд: 9  
77.8 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсгийн “хамт тухайн” гэснийг “хуулийн этгээд” гэж, мөн хэсгийн “нийлүүлэх тусгай зөвшөөрөл олгоно” гэснийг “нийлүүлж болно” гэж, 7.2.1, 7.2.2 дахь заалтын “сан бүхий энэ хуулийн 6.1.3-т заасан худалдах” гэснийг “сангийн” гэж, мөн заалтын “дүүргийн эмийн сангүй” гэснийг “сангийн хүрэлцээгүй” гэж, 7.5.1, 7.5.2, 7.5.3, 7.5.4 дэх заалтын “олгох, сунгахад” гэснийг “олгоход” гэж тус тус өөрчилж, мөн зүйлийн 7.5 дахь хэсгийн “Зөвшөөрлийн тухай хуулийн 5.1 дүгээр зүйлийн 3.1-д,” гэснийг, 7.13 дахь хэсгийн “хууль эрх зүйн хүрээнд” гэснийг тус тус хасаж, 7.1 дэх хэсгийн “бүтээгдэхүүнээ” гэсний дараа “түүхий эдээ” гэж, 7.11 дэх хэсгийн “саналаар” гэсний дараа “хуралдааны шийдвэр” гэж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 7.16 дахь хэсэг нэмэх:

“7.16.Энэ хуулийн 7.5.1, 7.5.3, 7.5.4, 19.1, 29.2.4-т заасан зохистой дадлын стандартыг стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага батална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 2  
Бүгд: 9  
77.8 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 8 дугаар зүйлийн 8.1.5 дахь заалтын “зах зээлд гаргах зөвшөөрөл авсан” гэснийг “бүртгүүлсэн” гэж, 8.2.4 дэх заалтын “үнээр” гэснийг “хувь хэмжээгээр нэмэгдүүлж” гэж, мөн заалтын “худалдах” гэснийг “ханган нийлүүлэх” гэж тус тус өөрчилж, 8.1.6 дахь заалтын “улсын бүртгэл” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 2  
Бүгд: 9  
77.8 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 9 дүгээр зүйлийн 9.4.1 дэх заалтын “зах зээлд гаргах зөвшөөрөлгүй” гэснийг “бүртгэлгүй” гэж, 9.4.6 дахь заалтын “үнээр” гэснийг “хувь хэмжээгээр нэмэгдүүлж” гэж, мөн заалтын “худалдах” гэснийг “ханган нийлүүлэх” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 3  
Бүгд: 9  
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсгийн “эмнэлгийн” гэснийг “эрүүл мэндийн байгууллагын” гэж, 10.4 дэх хэсгийн “жоргүй олгох эмийг цахимаар болон утсаар авсан” гэснийг “мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт эмээс бусад эмийг цахим жор болон” гэж, 10.8.1 дэх заалтын “зах зээлд гаргах зөвшөөрөлгүй” гэснийг “бүртгэлгүй” гэж, 10.8.10 дахь заалтын “үнээр” гэснийг “хувь хэмжээгээр

нэмэгдүүлж” гэж тус тус өөрчилж, мөн зүйлийн 10.2 дахь хэсгийн “болон сумын эрүүл мэндийн төв” гэснийг, 10.8.1 дэх заалтын “улсын бүртгэлд бүртгэгдээгүй” гэснийг, 10.8.4 дэх заалтын “, үйлчлэх” гэснийг, 10.8.9 дэх заалтын “хаяг,” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 2

Бүгд: 9

77.8 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 11 дүгээр зүйлийн 11.1.3 дахь заалтын “байгуулах,” гэсний дараа “эм, эмнэлгийн хэрэгслийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад” гэж нэмж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 11.1.7 дахь заалт нэмэх:

“11.1.7.эм, эмнэлгийн хэрэгслийн цувралын дугаар, стандарт код, тоо хэмжээг тухай бүр цахим санд оруулсан байна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 2

Бүгд: 9

77.8 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсгийг хасаж, мөн зүйлийн 12.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“12.1.Тусгай зөвшөөрлийн хугацааг сунгахад энэ хуулийн 8-11 дүгээр зүйлд заасан үүрэг, шаардлага, Эрүүл мэндийн тухай хуулийн 19.17-д заасан нөхцөлийг хангасан эсэх талаарх дүгнэлтийг үндэслэнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 2

Бүгд: 9

77.8 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 15 дугаар зүйлийн гарчгийн “Зах зээлд гаргах зөвшөөрөл” гэснийг “Эм, эмийн үйлчлэгч бодисыг бүртгэх” гэж, 15.1 дэх хэсгийн “зах зээлд гаргах зөвшөөрөлтэй” гэснийг “бүртгэлтэй” гэж, 15.2 дахь хэсгийн “зах зээлд гаргах зөвшөөрлийг” гэснийг “бүртгэлийг” гэж, мөн зүйлийн 15.2.2 дахь заалтын “зөвшөөрөл олгох” гэснийг “бүртгэл” гэж, 15.3 дахь хэсгийн “Зах зээлд гаргах зөвшөөрөл олгоход” гэснийг “Эм, эмийн үйлчлэгч бодисыг бүртгэхэд” гэж, 15.3.2 дахь заалтын “шаардлага” гэснийг “стандарт” гэж, 15.5 дахь хэсгийн, 15.5.4 дэх заалтын “зах зээлд гаргах зөвшөөрлийг” гэснийг “эм, эмийн үйлчлэгч бодисын бүртгэлийг” гэж тус тус өөрчилж, 15.4 дэх хэсгийн “зах зээлд гаргах зөвшөөрөл олгох, сунгах, өөрчлөх, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 2

Бүгд: 9

77.8 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 16 дугаар зүйлийн 16.4 дэх хэсгийн “эрүүл мэндийн асуудал эрхэлсэн” гэснийг “эм, эмнэлгийн хэрэгслийн асуудал хариуцсан” гэж, 16.9 дэх хэсгийн “үйлдвэрлэсэн” гэснийг “үйлдвэрлэж бүртгэсэн” гэж, 16.10 дахь хэсгийн “энэ хуулийн 16.9-д зааснаар” гэснийг “түргэвчилсэн байдлаар” гэж, 16.11, 16.12 дахь хэсгийн “зах-зээлд гаргах зөвшөөрөлтэй” гэснийг “бүртгэлтэй” гэж тус тус өөрчилж, 16.11 дэх хэсгийн “импортын” гэсний өмнө “Энэ хуулийн 16.10-д зааснаас бусад” гэж нэмж, мөн зүйлийн 16.15 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 2  
Бүгд: 9  
77.8 хувийн саналаар дэмжигдлээ.

11.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 17 дугаар зүйлийн 17.1.2 дахь заалтын “зах зээлд гаргах зөвшөөрөл авахад шаардагдах бүтээгдэхүүний” гэснийг “бүртгэлийн” гэж, 17.1.6 дахь заалтын “онцгой” гэснийг “нийгмийн эрүүл мэндийн ноцтой” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 2  
Бүгд: 9  
77.8 хувийн саналаар дэмжигдлээ.

12.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 18 дугаар зүйлийн гарчгийн, 18.1, 18.2 дахь хэсгийн “зөвшөөрөл” гэснийг “бүртгэл” гэж, 18.1 дэх хэсгийн “Шинэ эм” гэснийг “Эм” гэж, 18.3 дахь хэсгийн “зөвшөөрлийг” гэснийг “бүртгэлийг” гэж, мөн хэсгийн “эрүүл мэндийн асуудал эрхэлсэн” гэснийг “эм, эмнэлгийн хэрэгслийн асуудал хариуцсан” гэж, 18.4 дэх хэсгийн “зөвшөөрөлд” гэснийг “бүртгэлд” гэж тус тус өөрчилж, мөн зүйлийн 18.1 дэх хэсгийн “эрүүл мэндийн” гэсний дараа “байгууллага, эсхүл гадаад улсын эрх бүхий” гэж, 18.3 дахь хэсгийн “баримт бичиг,” гэсний дараа “Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, эсхүл гадаад улсын эрх бүхий байгууллагаас олгосон зөвшөөрөл,” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 2  
Бүгд: 9  
77.8 хувийн саналаар дэмжигдлээ.

13.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсгийн “байгууллага” гэсний дараа “лабораторийн зохистой дадлын стандарт хангасан” гэж, 19.2 дахь хэсгийн “лаборатори” гэсний дараа “итгэмжлэгдсэн байх бөгөөд” гэж, 19.4 дэх хэсгийн “Ерөнхий” гэсний өмнө “Дотоод болон гадаадын” гэж тус тус нэмж, 19.5 дахь хэсгийн “шинэ эм, уламжлалт” гэснийг “анхдагч” гэж өөрчилж, мөн зүйлийн 19.10 дахь хэсгийн “ эсхүл иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн гомдлын дагуу яаралтай шинжлэх дээж,” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн үг хэлэв.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 3  
Бүгд: 9

66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

14.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 20 дугаар зүйлийн 20.6 дахь хэсгийн “зах зээлд гаргах зөвшөөрлийг” гэснийг “бүртгэлийг” гэж, 20.12 дахь хэсгийн “зөвшөөрөл” гэснийг “бүртгэл” гэж тус тус өөрчилж, мөн зүйлийн 20.9 дэх хэсгийн “вакцин,” гэсний дараа “биобэлдмэл” гэж, 20.12 дахь хэсгийн “тандалт” гэсний дараа “судалгаа” гэж тус тус нэмж, 20.11 дэх хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 2

Бүгд: 9

77.8 хувийн саналаар дэмжигдлээ.

15.Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэнгийн гаргасан, Төслийн 20.3 дахь хэсгийг эм, эмнэлгийн хэрэгслийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, эмийн эмчилгээний идэвх тодорхойлох судалгааг Эрүүл мэндийн тухай хуулийн 15.1.7, 15.1.11, 15.1.13-т заасан байгууллагатай хамтран зохион байгуулна. Тандалт судалгааны зардлыг улсын төсвөөс гаргах бөгөөд гэж өөрчлөн нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 2

Бүгд: 9

77.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн, С.Чинзориг нар үг хэлэв.

16.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсгийн “дархлаажуулалтын дараах” гэснийг хасаж, 21.3 дахь хэсгийн “Энэ хуулийн 30.1-д заасан” гэснийг “Эрүүл мэндийн байгууллага, эмнэлгийн мэргэжилтэн,” гэж, 21.4 дэх хэсгийн “нөлөөг нягтлан дүгнэлт гаргаж, эмийн гаж нөлөөний талаар” гэснийг “нөлөөний үнэлгээг холбогдох зөвлөлийн шийдвэрээр баталгаажуулан,” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6

Татгалзсан: 3

Бүгд: 9

66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

17.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 22 дугаар зүйлийн гарчгийн, 22.2, 22.8 дахь хэсгийн “Шинэ” гэснийг “Анхдагч” гэж, мөн зүйлийн 22.4.5 дахь заалтын “биошингэц” гэснийг “биохүрэхүй” гэж, 22.6 дахь хэсгийн “биошингэцийг” гэснийг “биохүрэхүйг” гэж, 22.7.4 дэх заалтын “үйлчлэлийг” гэснийг “үйлдлийн” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 5

Татгалзсан: 4

Бүгд: 9

55.6 хувийн саналаар дэмжигдлээ.

18.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсгийн “зах зээлд гаргах зөвшөөрөлд” гэснийг “бүртгэлд” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 2  
Бүгд: 9

77.8 хувийн саналаар дэмжигдлээ.

19.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 26 дугаар зүйлийн 26.3 дахь хэсгийн “хэвлэлээр” гэснийг “хэвлэл, албаны ёсны цахим хуудсаар” гэж өөрчилж, 26.5.5 дахь заалтын “чухал, цорын ганц, маш өндөр идэвхтэй,” гэснийг, мөн заалтын “хамгийн сайн,” гэснийг тус тус хасаж, 26.5.10 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“26.5.10.эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүнийг өвчнийг оношлох, эмчлэх үйлдэлтэй гэж олон нийтийг төөрөгдөлд оруулсан байдлаар сурталчлах;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 2  
Бүгд: 9

77.8 хувийн саналаар дэмжигдлээ.

20.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 27 дугаар зүйлийн 27.4.1 дэх заалтын “зах зээлд гаргах зөвшөөрөлгүй” гэснийг “бүртгэлгүй” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 3  
Бүгд: 9

66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

21.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 29 дүгээр зүйлийн 29.4.4 дэх заалтыг хасаж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 29.4.6 дахь заалт нэмэх:

“29.4.6.эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид бага насны хүүхдийн эмийг олгохдоо онцгойлон анхаарч эмийн зохистой хэрэглээний талаарх мэдээлэл өгөх.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 3  
Бүгд: 9

66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

22.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 33 дугаар зүйлийн гарчгийн “хэрэгсэл зах зээлд гаргах зөвшөөрөл” гэснийг “хэрэгслийн бүртгэл” гэж, 33.1 дэх хэсгийн “зах зээлд гаргах зөвшөөрөлтэй” гэснийг “бүртгэлтэй” гэж, 33.2 дахь хэсгийн “зах зээлд гаргах зөвшөөрлийг” гэснийг “бүртгэлийг энэ хуулийн 15.3.1, 15.3.7 дахь заалт болон үйлдвэрлэгч улсдаа зах зээлд гаргасныг харгалзан үзэж,” гэж, 33.6 дахь хэсгийн “лабораторийн” гэснийг “лаборатори, эсхүл төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төвийн үндэсний итгэмжлэгдсэн лавлагаа лабораторийн” гэж, 33.7 дахь

хэсгийн “зах зээлд гаргах зөвшөөрлийн” гэснийг “улсын бүртгэлийн” гэж, 33.9 дэх хэсгийн “зах зээлд гаргах зөвшөөрөл” гэснийг “бүртгэл” гэж, 33.9.4 дэх заалтын “маш бага” гэснийг “Эрүүл мэндийн тухай хуулийн 15.1.12, 15.1.13-д заасан байгууллагад хэрэглэгдэх” гэж, 33.9.6 дахь заалтын “зах зээлд гаргах зөвшөөрөл авахад шаардагдах бүтээгдэхүүний” гэснийг “бүртгэлийн” гэж, 33.9.9 дэх заалтын “хэрэглэгдэхүүн, лабораторийн оношилгооны хэрэгсэл, эмнэлгийн тоног төхөөрөмж” гэснийг “хэрэгсэл” гэж тус тус өөрчилж, 33.4 дэх хэсгийг, 33.9.5 дахь заалтын “эмнэлзүйн” гэснийг тус тус хасаж, 33.5 дахь хэсгийн “байгууллага” гэсний дараа “өндөр, дунд эрсдэлтэй” гэж, 33.9.4 дэх заалтын “оношилгооны” гэсний дараа “өвөрмөц” гэж тус тус нэмж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 33.9 дэх хэсэг нэмэх:

“33.9.Өндөр, дунд эрсдэлтэй эмнэлгийн тоног төхөөрөмж, эмнэлгийн хэрэглэгдэхүүнийг үйлдвэрлэсэн улс, үйлдвэрлэгч, загвар, эсхүл бүтээгдэхүүний дугаар тус бүрээр нь жагсаалтад оруулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 2  
Бүгд: 9  
77.8 хувийн саналаар дэмжигдлээ.

23.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 35 дугаар зүйлийн 35.4 дэх хэсгийн “сөрөг нөлөө,” гэсний дараа “аюулгүй байдал,” гэж нэмж, 35.5 дахь хэсгийн “зах зээлд гаргах зөвшөөрлийг” гэснийг “бүртгэлийг” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 2  
Бүгд: 9  
77.8 хувийн саналаар дэмжигдлээ.

24.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 36 дугаар зүйлийн 36.2 дахь хэсгийн “байгууллага” гэсний дараа “, эсхүл Эрүүл мэндийн тухай хуулийн 15.1.12, 15.1.13-д заасан байгууллага” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 2  
Бүгд: 9  
77.8 хувийн саналаар дэмжигдлээ.

25.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 38 дугаар зүйлийн 38.2.4 дэх заалтын “серийн” гэснийг “цуврал, эсхүл бүтээгдэхүүний” гэж, 38.4 дэх хэсгийн “сав, баглаа боодол дээрх” гэснийг “гадна талд байрлах” гэж, 38.5.3 дахь заалтын “техникийн үзүүлэлт” гэснийг “загварын нэр” гэж, 38.8 дахь хэсгийн “зах зээлд гаргах зөвшөөрөлд” гэснийг “бүртгэлд” гэж тус тус өөрчилж, мөн зүйлийн 38.4.5 дахь заалтын “, сар, өдөр” гэснийг, 38.5.4, 38.5.7, 38.5.8, 38.5.9, 38.5.10 дахь заалтыг тус тус хасаж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 38.6 дахь хэсэг нэмэх:

“38.6.Эмнэлгийн тоног төхөөрөмжийн хэрэглэгчийн гарын авлага монгол, эсхүл англи хэлээр байх бөгөөд дараах мэдээллийг агуулна:

38.5.1.бүтээгдэхүүний нэр;



- 38.5.2.үйлдвэрлэгчийн нэр;
- 38.5.3.загварын нэр;
- 38.5.4.техникийн үзүүлэлт;
- 38.5.5.ашиглалтын заавар;
- 38.5.6.хадгалах болон тээвэрлэх нөхцөл;
- 38.5.7.ашиглалтын нөхцөл;
- 38.5.8.аюулгүй ажиллагаа;
- 38.5.9.суурилуулалт хийх зааварчилгаа;
- 38.5.10.завсар үйлчилгээ хийх зааварчилгаа;
- 38.5.11.холбоо барих үйлдвэр, ханган нийлүүлэх байгууллага;
- 38.5.12.ариутгал, халдваргүйжүүлэлтийн нөхцөл;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 2

Бүгд: 9

77.8 хувийн саналаар дэмжигдлээ.

26.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 39 дүгээр зүйлийн 39.2 дахь хэсгийн “хэвлэлээр” гэснийг “хэвлэл, албан ёсны цахим хуудсаар” гэж, 39.5.4 дэх заалтын “чухал, цорын ганц, маш өндөр үйлчилгээтэй,” мөн заалтын “хамгийн” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 2

Бүгд: 9

77.8 хувийн саналаар дэмжигдлээ.

27.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 40 дүгээр зүйлийн 40.1 дэх хэсгийн “бусад байгууллага” гэсний дараа “үндсэн, эсхүл гэрээт” гэж, 40.1.4 дэх заалтын “төхөөрөмжийн” гэсний дараа “хэрэглэгчийн гарын авлагад үндэслэн” гэж тус тус нэмж, 40.7 дахь хэсгийн “хэсгээс” гэснийг “хэсэгт заасан баталгаат хугацаанаас” гэж өөрчилж, 40.1.4 дэх заалтын “эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер” гэснийг, 40.2 дахь хэсгийн “болон лабораторийн” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 2

Бүгд: 9

77.8 хувийн саналаар дэмжигдлээ.

28.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 41 дүгээр зүйлийн 41.1 дэх хэсгийн “, бүртгэлд өөрчлөлт оруулах, хугацааг сунгах, түдгэлзүүлэх, бүртгэлээс хасах” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 2

Бүгд: 9

77.8 хувийн саналаар дэмжигдлээ.

29.Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуягийн гаргасан, Төслийн 41.1 дэх хэсгийн “Эм эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн төслийн 41 дүгээр зүйлийн 41.1 дэх хэсгийн

холбогдох баримт бичиг түүнд хийсэн шинжээчийн дүгнэлт” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 4  
Татгалзсан: 5  
Бүгд: 9  
44.4 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

30.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 43 дугаар зүйлийн 43.3.1 дэх заалтын “зах зээлд гаргах зөвшөөрөлгүй эм,” гэснийг “бүртгэлгүй эм, өндөр, дунд эрсдэлтэй” гэж өөрчилж, мөн зүйлийн 43.3.5 дахь заалтын “зах зээлд гаргах зөвшөөрөл,” гэснийг хасаж, 43.8 дахь хэсгийн “байгууллагын” гэсний дараа “эмийн асуудал хариуцсан улсын байцаагч” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 3  
Бүгд: 9  
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

31.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 44 дүгээр зүйлийн 44.1.1, 44.1.2, 44.1.3 дахь заалтын “зах зээлд гаргах зөвшөөрөлтэй” гэснийг “бүртгэлтэй” гэж, 44.4.2 дахь заалтын “зах зээлд гаргах зөвшөөрлийн гэрчилгээ” гэснийг “бүртгэлийн дугаар” гэж тус тус өөрчилж, мөн зүйлийн 44.7 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“44.7.Дараах нөхцөл байдал үүссэн тохиолдолд бүртгэлгүй эм, эмнэлгийн хэрэгслийг импортлоход Эмийн зөвлөл, Эмнэлгийн хэрэгслийн зөвлөлийн шийдвэрийг үндэслэн эм, эмнэлгийн хэрэгслийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага импортын мэдүүлэг олгоно:

44.7.1.гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал үүссэн;

44.7.2.эм, эмнэлгийн хэрэгслийн тасалдал үүсэж орлуулан хэрэглэх эм, эмнэлгийн хэрэгсэл байхгүйгээс эмнэлгийн тусламж, үйлчилгээнд доголдол үүссэн.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 2  
Бүгд: 9  
77.8 хувийн саналаар дэмжигдлээ.

32.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 46 дугаар зүйлийн 46.2, 46.2.3, 46.9, 46.10 дахь хэсгийн “тусламж, төсөл, хөтөлбөрөөр” гэснийг “тусламжаар” гэж, 46.10.1 дэх заалтын “шаардлага” гэснийг “стандарт” гэж, 46.10.6 дахь заалтын “эм, эмнэлгийн хэрэглэгдэхүүнийг” гэснийг “эмийг” гэж, 46.14.2 дахь заалтын “зах зээлд гаргах зөвшөөрөлгүй” гэснийг “бүртгэлгүй” гэж тус тус өөрчилж, 46.11 дэх хэсгийн “Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага” гэснийг хасаж, мөн хэсгийн “40.10.6” гэсний дараа “46.10.7” гэж нэмж, 46.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“46.1.Гадаад улсын Засгийн газар, олон улсын байгууллагаас хүн амын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд зориулан эм, эмнэлгийн хэрэгслийг хандив, тусламж хүлээн авахдаа эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад,

төрийн болон төрийн бус байгууллага, иргэн, гадаад, дотоодын хуулийн этгээдээс хандив, тусламж хүлээн авахдаа эм, эмнэлгийн хэрэгслийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад урьдчилан мэдэгдэж, зөвшөөрөл авна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 2  
Бүгд: 9  
77.8 хувийн саналаар дэмжигдлээ.

33.Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэнгийн гаргасан, 47 дугаар зүйлийн 47.1 дэх хэсгийг өөрчлөн найруулах:

“47.1.Нэг эх үүсвэрээс худалдан авах эм, эмнэлгийн хэрэгслийн нэр төрлийг сонгохдоо дараах зарчмыг баримтална.

47.1.1.эрүүл мэндийн байгууллагуудын тусламж үйлчилгээнд түгээмэл хэрэглэгддэг эсхүл эмийн зардалд өндөр хувь эзэлж байгаа эм, эмнэлгийн хэрэгсэл;

47.1.2.тусламж, үйлчилгээнд нэн шаардлагатай тасалдал үүсэх өндөр эрсдэлтэй эм, эмнэлгийн хэрэгсэл;

47.1.3.төрөөс төлбөрийг нь хариуцах удаан хугацааны нөхөх эмчилгээ шаардагдах эмгэгийн болон хөнгөвчлөх эмчилгээний эм.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 4  
Татгалзсан: 5  
Бүгд: 9  
44.4 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

34.Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэнгийн гаргасан, Төслийн 47.5 дахь хэсгийн “сонгон шалгаруулж” гэснийг хасж, “байгууллагыг” гэснийг “байгууллагатай” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн, С.Чинзориг нар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 4  
Татгалзсан: 5  
Бүгд: 9  
44.4 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

35.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 50 дугаар зүйлийн 50.1.5 дахь заалтын “зах зээлд гаргах зөвшөөрөл олгох,” гэснийг “бүртгэх” гэж, 50.1.7 дахь заалтын “өөрчлөх” гэснийг “нэмэлт оруулах” гэж, 50.1.10 дахь заалтын “зах зээлд гаргах зөвшөөрөл” гэснийг “бүртгэл, үйлдвэрлэлийн зохистой дадал” гэж, 50.1.12 дахь заалтын “эм, зах зээлд гаргах зөвшөөрөлгүй” гэснийг “бүртгэлгүй” гэж, 50.1.17 дахь заалтын “жигжиг хэрэгслийн” гэснийг “хэрэглэгдэхүүний” гэж, 50.2 дахь хэсгийн “Зах зээлд гарах зөвшөөрөлгүй” гэснийг “Бүртгэлгүй” гэж тус тус өөрчилж, 50.1.4, 50.1.6 дахь заалтын “өөрчлөх” гэснийг хасаж, 50.1.22 дахь заалтын “үйлдвэрлэхээс” гэсний дараа “хэрэглэх” гэж, 50.1.24 дэх

заалтын “байгууллагаар” гэсний дараа “гэрээний үндсэн дээр” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 2  
Бүгд: 9  
77.8 хувийн саналаар дэмжигдлээ.

36.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 51 дүгээр зүйлийн 51.3 дахь хэсгийн “дүрэм, гишүүдийн ашиг сонирхлын зөрчлийн мэдүүлэг гаргах” гэснийг, 51.4 дэх хэсгийн “иргэний төлөөлөл, эрүүл мэндийн салбарын тэргүүлэх мэргэжилтнээс” гэснийг, 51.5 дахь хэсгийн “, магистраас дээш зэрэгтэй” гэснийг, 51.13 дахь хэсгийн “үндэсний” гэснийг, 51.14.4 дэх заалтын “үйлдвэрлэх” гэснийг, мөн зүйлийн 51.14.5 дахь заалтыг, 51.15.3 дахь заалтын “, эмнэлгийн хэрэгслийн нөхцөлт зөвшөөрөл олгох” гэснийг, 51.15.4 дэх заалтын “эмнэлзүйн” гэснийг, 51.16.3 дахь заалтыг, 51.18.1 дэх заалтын “, үүргээ гүйцэтгэх чадваргүй болсон” гэснийг, 51.18.3 дахь заалтын “бүрэн эрхийн хугацаа нь дуусахаас өмнө” гэснийг тус тус хасаж, 51.4 дэх хэсгийн “захиргааны байгууллага,” гэсний дараа “эрүүл мэндийн байгууллага,” гэж, мөн хэсгийн “сургуулийн” гэсний дараа “төлөөллөөс” гэж, 51.9 дэх хэсгийн “дарга,” гэсний дараа “нарийн бичгийн даргыг шууд,” гэж, 51.18 дахь хэсгийн “хэрэгслийн зөвлөл,” гэсний дараа “түүний салбар зөвлөлийн” гэж тус тус нэмж, мөн зүйлийн 51.14.3 дахь заалтын “зах зээлд гаргах зөвшөөрөл олгох” гэснийг “бүртгэх” гэж, 51.15.5 дахь заалтын “хөрөнгө оруулалтын асуудлаар шийдвэр” гэснийг “асуудлаар төлөвлөлтийн санал” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8  
Татгалзсан: 2  
Бүгд: 10  
80.0 хувийн саналаар дэмжигдлээ.

37.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 57 дугаар зүйлийн 57.1.3 дахь заалтын “зах зээлд гарах зөвшөөрөлгүй” гэснийг “бүртгэлгүй,” гэж, 57.1.5 дахь заалтын “итгэмжлэгдсэн лабораторийн дүгнэлтэд” гэснийг “үр дүнд” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 3  
Бүгд: 9  
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

38.Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай 60 дугаар зүйл нэмэх:

#### **“60 дугаар зүйл.Шилжилтийн үеийн зохицуулалт**

60.1.Энэ хуулийн 8.1.2, 15.3.2-г заасан стандартыг дотоодын уламжлалт эмийн үйлдвэр 2029 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

60.2.Энэ хуулийн 16.14 дэх хэсэгт заасныг үйлдвэрлэх-экспортлох тусгай зөвшөөрөл эзэмшигч дотоодын үйлдвэрлэгч 2027 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжүүлнэ.

60.3.Энэ хуулийн 16.10 дахь хэсэгт заасан өнчин эмийн бүртгэлийг 2027 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хийнэ.

60.4.Энэ хуулийн 43 дугаар зүйлийн 43.3.1 дэх заалтыг 2027 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 3  
Бүгд: 9  
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

39.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 60 дугаар зүйлийн 60.2 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 5  
Татгалзсан: 4  
Бүгд: 9  
55.6 хувийн саналаар дэмжигдлээ.

### **Найруулгын санал:**

**П.Анужин:** 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.40 дэх заалтын “бусад” гэсний дараа “хэлбэрийн” гэж, 54 дүгээр зүйлийн 54.1.2 дахь заалтын “хүний нөөц,” гэсний дараа “иргэдийн” гэж, 55 дугаар зүйлийн 55.4 дэх хэсгийн “байгууллагад” гэсний дараа “улирал” гэж тус тус нэмэх.

2.Төслийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсгийн “гурван” гэснийг “хоёр” гэж, 33 дугаар зүйлийн 33.2.1 дэх заалтын “бүртгэлд бүртгэх” гэснийг “бүртгэл” гэж, 33.2.2 дахь заалтын “жагсаалтад оруулах” гэснийг “жагсаалт” гэж, 43 дугаар зүйлийн 43.3.8 дахь заалтын, 46 дугаар зүйлийн 46.14.4 дэх заалтын “хадгалсан, ашигласан,” гэснийг “жилийн хугацаа өнгөрсөн” гэж, 45 дугаар зүйлийн 45.1.1 дэх заалтын “зах зээлд гаргах зөвшөөрөлтэй” гэснийг “бүртгэлтэй” гэж, 46 дугаар зүйлийн 46.10.11 дэх заалтын “өндөргүй, бодит” гэснийг “доогуур” гэж, 47 дугаар зүйлийн 47.1.1, 47.1.4 дэх заалтын, 47.4, 47.5, 47.6 дахь хэсгийн “жижиг хэрэгсэл” гэснийг “хэрэглэгдэхүүн” гэж, 51 дүгээр зүйлийн 51.6 дахь хэсгийн “эрхэлсэн” гэснийг “хариуцсан” гэж тус тус өөрчлөх.

3.Төслийн 34 дүгээр зүйлийн 34.6 дахь хэсгийн “, 34.4-г” гэснийг, 40 дүгээр зүйлийн 40.1.4 дэх заалтын “байгууллагын” гэснийг, 40.1.6 дахь заалтын “байгууллагад” гэснийг, 54 дүгээр зүйлийн гарчгийн “нийгэмлэг,” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 2  
Бүгд: 9  
77.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

**2.Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн талаар:**

Төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

### **3.Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

Төслийн 1, 2, 3, 4, 5 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**П.Анужин:** 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн 2 дахь заалтын 19.3.5 дахь заалтыг хасаж, мөн зүйлийн 2 дахь заалтын 19.3.2-19.3.4 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“19.3.2.эм, уламжлалт эм, биобэлдмэл, тэдгээрийн түүхий эд, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт эм, эмнэлгийн тоног төхөөрөмж, лабораторийн оношилгооны хэрэгсэл, эмнэлгийн хэрэглэгдэхүүн үйлдвэрлэх-экспортлох;

19.3.3.эм, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт эм, эмнэлгийн тоног төхөөрөмж, лабораторийн оношилгооны хэрэгсэл, эмнэлгийн хэрэглэгдэхүүн-импортлох-ханган нийлүүлэх;

19.3.4.эм болон эмнэлгийн хэрэгсэл, мансууруулах эм худалдах;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 3  
Бүгд: 9  
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн “19 дүгээр зүйлийн” гэсний дараа “19.3.5,” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 2  
Бүгд: 9  
77.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

### **4.Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

Төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

### **5.Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

Төслийн 1, 2, 3, 4 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

**6.Байгалийн ургамлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

Төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

**7.Зар сурталчилгааны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

Төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**П.Анужин:** 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 13.9 дэх хэсгийн “Эмийн” гэснийг “Эм, эмнэлгийн хэрэгслийн” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 5  
Татгалзсан: 4  
Бүгд: 9  
55.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

**8.Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

Төслийн 1, 2, 3, 4 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**П.Анужин:** 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 3  
Бүгд: 9  
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтын “Тусгай зөвшөөрөл” гэсэн баганын 13.17, 13.18, 13.19 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“13.17.эм, уламжлалт эм, биобэлдмэл, тэдгээрийн түүхий эд, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт эм, эмнэлгийн тоног төхөөрөмж, лабораторийн оношилгооны хэрэгсэл, эмнэлгийн хэрэглэгдэхүүн үйлдвэрлэх-экспортлох;

13.18. эм, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт эм, эмнэлгийн тоног төхөөрөмж, лабораторийн оношилгооны хэрэгсэл, эмнэлгийн хэрэглэгдэхүүн импортлох-ханган нийлүүлэх;

13.19.эм болон эмнэлгийн хэрэгсэл, мансууруулах эм худалдах;" гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 3  
Бүгд: 9  
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “12.1 дэх заалтын” гэсний дараа ““Эмийн” гэснийг “Эм, эмнэлгийн хэрэгслийн” гэж, мөн заалтын” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 3  
Бүгд: 9  
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн “13.6” гэсний дараа “, 13.7” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 3  
Бүгд: 9  
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

**9.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

Төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**П.Анужин:** 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “эмнэлгийн жижиг хэрэгсэл” гэснийг “хэрэглэгдэхүүн” гэж, “эмнэлгийн жижиг хэрэгслийн” гэснийг “хэрэглэгдэхүүн” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 3  
Бүгд: 9  
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

**10.Гаалийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

Төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.



Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

### **11. Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

Төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

### **10. Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

Төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**П.Анужин:** 1. Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 6.6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “нөлөөт эм,” гэсний дараа “эмнэлгийн тоног төхөөрөмж, лабораторийн оношилгооны хэрэгсэл, эмнэлгийн хэрэглэгдэхүүн” гэж, 3 дахь хэсгийн “борлуулсан бол” гэсний дараа “зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хэрэгсэл, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж” гэж тус тус нэмж, мөн зүйлийн 2 дахь хэсгийн “биобэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл” гэснийг “эмнэлгийн тоног төхөөрөмж, лабораторийн оношилгооны хэрэгсэл, эмнэлгийн хэрэглэгдэхүүн” гэж, 4 дэх хэсгийн “Зах зээлд гаргах зөвшөөрөлгүй” гэснийг “Бүртгэлгүй” гэж, 17 дахь хэсгийн “тусламжаар төсөл, хөтөлбөрөөр” гэснийг “тусламжаар” гэж, 24 дэх хэсгийн “зах зээлд гаргах зөвшөөрөлгүй эм,” гэснийг “эм, эмийн үйлчлэгч бодис,” гэж тус тус өөрчилж, мөн зүйлийн 1 дэх хэсгийн “эмнэлгийн хэрэгсэл,” гэснийг, 4 дэх хэсгийн тайлбарын “зах зээлд гаргах зөвшөөрөлгүй,” “зах зээлд гаргах зөвшөөрөл,” “мансууруулах эм, уламжлалт эм, биобэлдмэл,” гэснийг, 10 дахь хэсгийн “лабораторийн оношилгооны хэрэгслийг Монгол Улсын эм,” гэснийг, 24 дэх хэсгийн “зохих” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	6
Татгалзсан:	3
Бүгд:	9

66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн П.Анужин Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 14 цаг 05 минутад хэлэлцэж дуусав.*

***Дөрөв. Байнгын хорооны тогтоолын төсөл /Монгол Улсын Их Хурлын хаврын ээлжит чуулганы 2024 оны 05 дугаар сард Нийгмийн бодлогын байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай/***

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын референт Г.Нямсүрэн, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Нийгмийн бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Цогзолбаяр нар байлцав.

Тогтоолын төслийн танилцуулгыг Байнгын хорооны дарга П.Анужин танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**П.Анужин:** “Монгол Улсын Их Хурлын хаврын ээлжит чуулганы 2024 оны 05 дугаар сард Нийгмийн бодлогын байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 5  
Татгалзсан: 4  
Бүгд: 9  
55.6 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

*Уг асуудлыг 14 цаг 06 минутад хэлэлцэж дуусав.*

**Тав.Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Монгол Улсын Ерөнхийлөгч 2024.05.13-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Я.Содбаатар, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Хууль зүйн бодлогын зөвлөх Р.Батрагчаа, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын дэд сайд С.Зулпхар, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн халамжийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Ундрал нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх А.Болортуяа, мөн газрын газрын референт Г.Нямсүрэн, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Нийгмийн бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Цогзолбаяр нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Я.Содбаатар танилцуулав.

Илтгэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг, Д.Сарангэрэл, Б.Жаргалмаа нарын тавьсан асуултад Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Я.Содбаатар, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын дэд сайд С.Зулпхар нар хариулж, тайлбар хийв.

**П.Анужин:** Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 2  
Бүгд: 9  
77.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 14 цаг 21 минутад хэлэлцэж дуусав.*

Байнгын хорооны хуралдаанаар 5 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 3 цаг 36 минут үргэлжилж, 17 гишүүнээс 11 гишүүн хүрэлцэн ирж 64.7 хувийн ирцтэйгээр 14 цаг 22 минутад өндөрлөв.*

**Тэмдэглэлтэй танилцсан:**  
НИЙГМИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА

П.АНУЖИН

**Тэмдэглэл хөтөлсөн:**  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ  
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ**  
2024 оны 05 дугаар сарын 15-ны өдөр,  
Лхагва гараг  
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар”  
танхим 10 цаг 46 минут

**НИЙГМИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН  
ХОРООНЫ  
ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ  
ТЭМДЭГЛЭЛ**

**П.Анужин:** Байнгын хорооны гишүүдийнхээ гишүүддээ өглөөний мэнд хүргэе. Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж, Байнгын хорооны ирц 58,8-тай бүрдсэн тул Нийгмийн бодлогын байнгын хорооны 2024 оны 5 дугаар сарын 15-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн дагуу хуралдаанд хүрэлцэн ирсэн болон ирээгүй гишүүдийг та бүхэндээ танилцуулъя. Жаргалмаа гишүүн хүрэлцэн ирсэн байна. Оюунчимэг гишүүн ирсэн байна. Сандаг-Очир гишүүн ирсэн. Сарангэрэл гишүүн, Саранчимэг гишүүн, Одонтуяа нарын гишүүд хүрэлцэн ирсэн байна. Чинбүрэн гишүүн, Чинзориг гишүүн, Идэрбат нарын гишүүд хуралдаа хүрэлцэн ирсэн байна.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

1 дүгээрт нь Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Монгол Улсын Ерөнхийлөгч 2024 оны 4 дүгээр сарын 15-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

2-т Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Энхболд нарын 14 гишүүн 2024

оны 5 дугаар сарын 2-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлгийг хийнэ./

3.Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газраас 2024 оны 5 дугаар сарын 1-ний өдөр өргөн мэдүүлсэн, хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хийнэ./

4-д нь Байнгын хорооны цаглавар батлах тухай.

Өнөөдрийн Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудалтай холбоотойгоор санал хэлэх гишүүн байна уу. Байхгүй байна. Хэлэлцэх асуудалдаа оръё.

**Монгол Улсын Ерөнхийлөгчөөс  
2024 оны 4 дүгээр сарын 5-ны өдөр өргөн  
мэдүүлсэн Цэргийн алба хаагчийн  
тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд  
нэмэлт, өөрчлөлт оруулах тухай  
хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг  
хийнэ.**

Ажлын хэсгийн гишүүдийг танхимд урьж байна. Дашицдэнгийн Баасандамба Монгол Улсын Ерөнхийлөгчийн Аюулгүй байдал, батлан хамгаалах бодлогын зөвлөх, бригадын генерал, Жаргалсайханы Мөнхболд Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын Хуулийн бодлогын бодлогын газрын дарга, Сүнрэвийн Ганбямба Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга, хошууч генерал, Хожгорын Лхагвасүрэн Хил хамгаалах ерөнхий газрын дарга, Хилийн цэргийн командлагч, хошууч генерал, Гомбожавын Ариунбуян Онцгой байдлын ерөнхий газрын дарга, хошууч генерал, Даваасүрэнгийн Отгонжаргал Сангийн яамны Төсвийн бодлого төлөвлөлтийн газрын ахлах шинжээч, Гончигдашийн Сувдаа Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын Хуулийн бодлогын газрын ахлах референт. Ажлын хэсгийг та бүхэндээ танилцууллаа.

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулж асуулт асуух гишүүд байна уу. Хууль санаачлагчаас нэрс авъя. Байхгүй байна.

Төслийн 2 дугаар зүйлтэй холбоотой асуулт асуух гишүүн байна уу. Байхгүй байна.

Төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулттай гишүүн байна уу. Байхгүй байна.

Төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу. Энэ чинь 4 дүгээр зүйл тийм үү. 4 дүгээр зүйлтэй холбоотойгоор Байнгын хороодын гишүүдээс санал авах хэлэлцүүлэх 1 асуудал байгаа.

Төсвийн тухай хуультай холбогдож байгаа юм. Төсвийн тухай та нар хуулийн төслүүд гишүүдэд байгаа тийм үү. Төсвийн зарчмыг хэрэгжүүлэх 6.2.5 төсвийн жилийн дундуур орлого бууруулах, зарлага нэмэгдүүлэх үр дагавартай бодлогын аливаа ишигдвэр гаргасан бол түүнийг дараагийн төсвийн жилээс хэрэгжүүлдэг байх гэж хууль маань орж ирэхдээ бол шууд хэрэгжээд явахаар байгаа юм. Тэгэхээр өөрөө төсөвтэй холбоотой учраас хэрвээ бид нар Төсвийн тухай хуулиа дагавал ирэх жилээс хэрэгжих ёстой юм. Энэ дээр бүгдээрээ Байнгын хорооны гишүүд саналаа хэлээд санал авчихъя гэсэн ийм саналтай байгаа юм. Даваажанцангийн Сарангэрэл гишүүн санал хэлнэ.

**Д.Сарангэрэл:** Баярлалаа. Энэ хуулийн төслийг бид нар эхнээс нь дэмжээд ингээд явж байгаа. Тэгээд хэрвээ Төсвийн тухай хуультай уялдуулах юм бол яг батлагдсан өдрөөсөө хэрэгжих энэ нөхцөл боломж нь бол хязгаарлагдах юм байна. Тийм болохоор зэрэг бид нар бол зарчмын зөрүүтэй саналын томъёолол гаргаад, төсвийн хуульдаа өөрчлөлт оруулаад энэ хуулиа батлагдсан өдрөөс нь мөрдөх ийм

цаглавартай бол нийцүүлэх нь зүйтэй гэсэн ийм саналтай байна.

**П.Анужин:** Ажлын хэсгээс хариулт өгье. 4 номерын микрофонд хариулт өгөх үү. 4 номерын микрофоныг нээж өгье. Өөрийгөө танилцуулаад асуултад хариулаарай.

**Д.Баасандамба:** Ажлын хэсгийг ахалж байгаа Монгол Улсын Ерөнхийлөгчийн Цэргийн бодлогын зөвлөх бригадын генерал Баасандамба байна. Ажлын хэсэг одоо зарчмын зөрүүтэй санал дээр хариулт өгье. Ердийн журмаар буюу батлагдсан өдрөөсөө мөрдөхөөр саналын томъёолол анх орж ирсэн. Ингээд хэрвээ Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт орох процесс нэмэгдэх учраас 2025 онд бас мөрдөөд явах ийм боломж байгаа. Яагаад гэвэл бид нар эрсдэлийг үнэлээд, урьдчилан тооцоолол хийх боломжгүй алхам учраас.

**П.Анужин:** Хариулт авлаа. Байнгын хорооноос миний бие санал гаргаж байна. 4 дүгээр зүйлтэй холбоотойгоор. Саналын томъёоллыг уншиж танилцуулъя. Энэ хуулийг 2025 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө. Санал хураалт. 63.6 хувиар уг санал дэмжигдлээ.

Монгол Улсын Ерөнхийлөгчөөс өргөн мэдүүлсэн Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хийж дууслаа.

Чуулганы нэгдсэн хуралдаанд анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх Байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Бадарчийн Жаргалмаа танилцуулна.

10.54 цаг.

**Хэлэлцэх асуудлынхаа дараагийн асуудалд оръё. Улсын Их Хурлын**

**гишүүн Нямаагийн Энхболд нарын 14 гишүүнээс 2024 оны 5 дугаар сарын 2-ны өдөр өргөн мэдүүлсэн Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг хийнэ.**

Анхны хэлэлцүүлгийг бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч Даваажанцангийн Сарангэрэл танилцуулна. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танхимд урьж байна. Орж ирж байх хооронд ажлын хэсгийн гишүүдээ танилцуулъя. Болдын Ундрал Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн Халамжийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга, Сандагийн Тунгалагтамир ирсэн байна уу. Сандагийн Тунгалагтамир ирсэн байна. Хүний эрхийн Үндэсний Комиссын Тамгын газрын Судалгаа, шинжилгээний хэлтсийн дарга, Дамбаагийн Наран-Отгон Төрийн албаны зөвлөлийн ажлын албаны референт, Пүрэвдоржийн Бат-Эрдэнэ Сангийн яамны Төсвийн зарлагын хэлтсийн дарга, Юрагийн Отгонбилэг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын шинжээч, Өлзийхутагийн Гэрэлт-Од Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Ахмад настны хөгжлийн бодлогын хэрэгжилт хариуцсан мэргэжилтэн, Дугарсүрэнгийн Баясгалан Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын ахлах мэргэжилтэн, Сэмбэдоржийн Жаргалсайхан Эрүүл мэндийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын шинжээч, Бүдрагчаагийн Баярболд Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын Тусламж, үйлчилгээний багц зохицуулалтын хэлтсийн дарга, Нэргүй Энхбат “Юзисан Партнерс” хуулийн фирмийн ахлах хуульч гэсэн бүрэлдэхүүнтэйгээр ажлын хэсэг хүрэлцэн ирсэн байна.

Хуулийн төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх санал,

дүгнэлтийг хуулийн төслийн ахлах Сарангэрэл гишүүн танилцуулна.

**Д.Сарангэрэл:** Улсын Их Хурлын гишүүн Нямаагийн Энхболд нарын 14 гишүүнээс Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг санаачлан боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлснийг 2024 оны 5 дугаар сарын 3-ны өдөр Улсын Их Хурлын нэгдсэн чуулганаар хуулийн төслийг хэлэлцэх эсэхийг дэмжин, ажлын хэсгийг байгуулсан бөгөөд миний бие ажлын хэсгийн ахлагчаар ажиллаж, Улсын Их Хурлын гишүүн Жаргалмаа, Сандаг-Очир нарын хамт дэд ажлын хэсэгтэй ажиллаж хуулийн төслийг анхны хэлэлцүүлэгт бэлдэх ажлыг хийж гүйцэтгэлээ.

Одоо мөрдөж байгаа Ахмад настны тухай хууль нь нийт 4 бүлэг, 17 зүйл, 111 хэсэг заалттай хууль байгаа бол Улсын Их Хурлаар хэлэлцүүлж байгаа Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд шинээр 40 хэсэг, заалт нэмэхээр тусгажээ.

Мөн одоо мөрдөж байгаа хуулийн нийт 18 хэсэг, заалтад өөрчлөлт оруулах, 1 хэсгийг хүчингүй болгох нийт олон хэсэг заалтыг нэмж өөрчилсөн. Хуулийн төслийн хувьд том хэмжээний нэмэлт, өөрчлөлт орсон байна.

Мөн энэ хуулийн төсөлтэй хамт 11 хуулийн төсөлд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулан Улсын Их Хурлаар хэлэлцүүлж байна. Байнгын хороогоор хэлэлцүүлж байна. Сүүлийн жилүүдэд хүн ам зүйн өөрчлөлтийн улмаас нийт хүн амын дунд ахмад настнуудын эзлэх хувь хурдацтай өсөж байна. Дэлхийн хэмжээнд 2022 онд 65 ба түүнээс дээш насны 771 сая хүн байгаа нь 1980 оныхоос 3 дахин их байна. 2020 оны байдлаар Монгол Улсад нийт хүн амын 10,1 хувь буюу 364,6 мянган ахмад настан байна. Үндэсний статистикийн хорооноос хийсэн

тооцоогоор хөдөлмөрийн насны 1 хүнд ноогдох ахмад настны тооны харьцаа 2010 онд 10 ажилтан тутамд нэг ахмад настан байсан бол, 2040 он гэхэд 4 ажилтан тутамд 1 ахмад настан болохоор байна гэжээ.

Иймд нийт хүн амын дунд ахмад настнууд эзлэх хувь хурдацтай өсөж байгаатай уялдуулан эрүүл идэвхтэй насжилтад бэлтгэх, ахмад настанд үзүүлэх урт хугацааны цогц тусламж үйлчилгээг сайжруулах, ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ахмад настны эсрэг үйлдэгдэж байгаа эдийн засгийн хүчирхийллийг багасгах, ахмад настны хөгжил, нийгмийн оролцоог нэмэгдүүлэх, ахмад настны хөгжил, оролцоог нэмэгдүүлэх үйлчилгээ, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, санхүүжилтийн хэмжээг нэмэгдүүлэх, тодорхой болгох, ахмад настны асаргааны олон төрлийн үйлчилгээг бий болгон хөгжүүлэх, ахмад настны хөнгөлөлттэй үнээр сувилж байгаа сувиллын газруудын тоо, хамрах хүрээг нэмэгдүүлэх, ахмад настанд протез, ортенид хийлгэх давтамжийг 5 жил байгааг 3 жил болгох, аж ахуйн нэгж байгууллага, ахмадын сан ажиллуулахыг дэмжих, сангийн төсөв санхүүжилтийг тодорхой болгох, ахмад настанд үйлчилгээ үзүүлэх байгууллагуудыг дэмжих зэргийг Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн ерөнхий үзэл баримтлалыг ажлын хэсэг дэмжин ажилласан.

Дэд ажлын хэсэгт Хууль зүй, дотоод хэргийн яам, Сангийн яам, Төрийн албаны зөвлөл, Эрүүл мэндийн яам, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны төлөөллийг оролцуулан хуулийн төсөл Засгийн газраас өгсөн санал, дүгнэлтийг нэг бүрчлэн хэлэлцэн Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон дагалдан гарах 11 хуулийн төслийн зүйл, хэсэг, заалт бүрийг нэг бүрчлэн хэлэлцсэний үндсэн дээр зарим тодорхой

саналыг нэмэх, холбогдох хуулиудын нийцлийг хангах, зарим заалтуудын үг, найруулгыг сайжруулан өөрчлөх, хуулийн төслийн бичвэрийг сайжруулах, зарим заалтыг тодорхой болгох зэргээр ажиллаж анхны хэлэлцүүлэгт бэлдсэн зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг бэлтгэлээ. Анхаарал тавьсанд баярлалаа.

**П.Анужин:** Ажлын хэсгийн ахлагч Даваажанцангийн Сарангэрэл гишүүнд баярлалаа.

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбоотойгоор асуулт асууж, үг хэлэх гишүүн байна уу. Байхгүй бол ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй 17 саналаар санал хураалт явуулна.

Ахмад настны тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтын 7.1.11 дэх заалтын “дасгал хөдөлгөөн” гэсний өмнө “зөв хооллолт” гэж нэмж, тус заалтын “эрүүл мэнд, нийгмийн оролцоо” гэснийг “эрүүл мэндийг” гэж өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Сарангэрэл, Жаргалмаа, Сандаг-Очир /цаашид “ажлын хэсэг” гэх/ Санал хураалт. Уучлаарай энэ санал хураалтыг цуцалъя. Техникийн алдаа гарлаа.

Сая ажлын хэсгийн ахлагч хэлэлцүүлгийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай санал дүгнэлт танилцуулсан. Ажлын хэсгийн ахлагчийн санал, дүгнэлттэй холбоотойгоор асуулт асуух гишүүд байна уу. Үг хэлэх гишүүд байна уу. Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн үг хэлж, асуулт асууна. Үг, асуулт хамт явна.

**М.Оюунчимэг:** Бид нар сая тойрогтоо ахмадуудтай уулзаж байхад нөгөө ахмадын сангийн тухай асуудал дээр нэлээд ач холбогдол өгч, анхаарч байсан. Яагаад гэвэл одоо энэ дээр маш

олон арга хэмжээнүүдийг зохион байгуулах, дэмжих гээд тэгж байна. Тэгэхээр санхүүжилтгүйгээр юу ч явдаггүй. Одоогийн байдлаас харахад өөрсдөө босох юм уу эсвэл дүүргээ харсан байдалтай. Дүүрэг нь хороондоо амсуулсан байдалтай ч юм уу, тийм байдаг л даа. Тэгэхээр ахмадын сангийн санхүүжилтийг тухайн жилийн улсын төсөвт нь тусгаж өгнө гэж байгаа. Ингэж тусгахдаа тооцооллыг яаж тусгаж өгөх вэ. Улсын төсөвт тусгахаас гадна өөр санхүүжилтүүд олох механизмыг нь бас нээлттэй болгох тал дээр яаж анхаарсан байна вэ. Би эндээс уншихад яг тэр нь бол тодорхойгүй байна л даа. Ахмадын сангийн үйл ажиллагааг тайлагнахтай холбоотой заалт бол байна. Тэгэхээр энийг тодорхой мэдээллийг товчхон авмаар байна.

2 дахь зүйл нь энэ ахмадын сан нь дүүрэг дээрээ байх юм уу. Эсвэл Хөдөлмөр, нийгмийн хамгааллын харьяа байгууллагууд дээр нь байх юм уу. Ахмадуудын саналыг сонсож байхад тухайн хороо дээрээ байгаад, хорооны Засаг даргын доор нь эсвэл тэр санг нь бий болгоод өгчих бүтэц үүсгээд бий болгоод өгөөд явчихвал илүү их ойрхон үйл ажиллагаа явуулахад ч амар гэсэн байр суурь илэрхийлж байсан л даа. Тэгэхээр энэ санг хаана яг байршуулах, сангийн үйл ажиллагаа дээр санхүүжилтийг нь зөвхөн улсын төсвөөс байх уу эсвэл бусад эх үүсвэрүүдээс ингэж ингэж гаргах бололцоотой гэдгийг нь нээгээд өгөх үү гэдэг дээр хариулт авахыг хүсэж байна. 1 дүгээрт.

2-т нь түрүүн Сараа даргын тэр тайлбарлаж байснаас харахад ахмадууд бас ингээд байна лээ л дээ. Бид нар нөгөө Нийгмийн даатгалын багц хууль батлан гаргахдаа нөгөө тэтгэвэр өвлөгдөх дээр 20 жил амьдарсан бол гээд байгаа шүү дээ. Тэгээд энэ 20 жил гэдэг бол нэг, нэгэндээ итгэхгүй байгаа юм шиг 20 гэдэг дэндүү урт байна. Энийг та нар маань 5, 10 дээр юм уу буцаж энэ

ахмадын хуультай уяад, энэ 20 жил гэдгийг наашлуулах бололцоо байна уу гэсэн асуултуудыг ахмадууд тавьж байна лээ л дээ. Тэгээд бид нар бас энэ дагалдах хуулиар нь юм уу эсвэл энэ хуультай уялдаад энийг зохицуулах бололцоо байгаа юу гэдэг асуулт байна. Баярлалаа.

**П.Анужин:** Нийгмийн даатгалын багц хуулийг хэлэлцэх үед бас Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн өөрөө ажлын хэсэгт байсан. Бид нар энэ талаар маш нухацтай ярилцаж, бас санал хурааж, дэмжигдэж явсан санал гэдгийг би юун түрүүнд хэлье. Сая асуусан асуулттай холбогдуулж 3 номерын микрофонд Ундрал дарга, тэгээд гүйцээгээд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам хариулт өгье. 2 номерын микрофонд хариулт өгье.

**Ю.Отгонбилэг:** Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам Отгонбилэг. Оюунчимэг гишүүний асуултад хариулъя. Ахмадын сангийн асуудлыг одоо мөрдөж байгаа хуулиар 14.7-д нь заасан байгаа аж ахуйн нэгж, байгууллага өөрийн төсөв, үйл ажиллагааны орлогоосоо, төсөвт байгууллага энэ хуулийн төслөөр нэмээд төсөвт байгууллага бол тухайн жилийн төсвийн зардалдаа тусгана гээд заагаад өгсөн юм. Тэгэхээр энэ маань юу гэсэн үг вэ гэхээр аж ахуйн нэгж болгон өөрсдөө бол ахмадын сантай байх нь бол хуулиараа байгаа. Тэгэхдээ энэ нь бол үйл ажиллагааны орлогоосоо гэсэн, төсөвт байгууллагын хувьд үйл ажиллагааны орлого гэж байдаггүй, энэ заалт нь хэрэгжихгүй байгаад байгаа учраас төсөвт байгууллага нь тухайн жилийн төсвийн зардалдаа цалингийн нийт сангийнхаа 3 хүртэл хувиар Ахмадын сан байгуулна гэдгийг ингээд тодорхой болгож өгч байгаа.

Мөн Компанийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах заалт тусгасан. Цалингийн сангийнхаа 3 хүртэл хувь. Хэдэн ч хувь байж болно. Максимум нь 3 хүртэл хувь гэж байгаа.



**П.Анужин:** Нийгмийн даатгалын багц хуультай холбоотой тэтгэврийн асууда. Тэтгэврийн зохицуулалт 20 жил хүртэлх гэдгийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам хариулъя. Ундрал дарга хариулт өгье 3 номерын микрофонд.

**Б.Ундрал:** Гишүүний асуултад хариулъя. Нийгмийн даатгалын багц хууль дээр болохоор 20 жилийг бид нар энэ ахмадын хууль дээр нэмэлт, өөрчлөлт гэдгээр нь тусгаагүй. Тооцоо судалгааг нь хийгээд явж байгаа. Би танд эргүүлээд тодорхой өгье. Энэ дээр зохицуулалт ороогүй байгаа.

**П.Анужин:** Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн тодруулж асууя.

**М.Оюунчимэг:** Ахмадын сангийн тухай асуудал дээр аж ахуйн нэгж бол тэгнэ. Төсөвт байгууллагууд бол 3 хүртэл хувиар гэж байна. Гэтэл бүх ахмадууд мэдээж нэг байгууллагад харьяалагдаж байсан. Гэхдээ тухайн байгууллагаас одоо жишээлбэл дийлэнх ахмадууд өөрсдөө л цуглаж арга хэмжээнүүд зохион байгуулахаас биш, тухайн байгууллага зөвхөн ахмадын өдрөөр л ахмадууддаа цуглуулж арга хэмжээ хийдэг шүү дээ. Тэгэхээр ахмадын сан гэхээр энэ төсөвт байгууллага гэхэд алийг нь хэлж байгаа юм. Дүүргийг хэлж байгаа юм уу, эсвэл тэр хүний ажиллаж байсан хуу хуучин байгууллагыг нь хэлж байгаа юм уу. Энийг тодорхой болгоод, тэгээд ахмадын сан нь өөрөө тэнд байршина гэдгийг бас тодорхой болгож өгөхгүй бол энэ бас асуудал дагуулж мэдэх юм байна лээ шүү гэдэг ахмадуудаас өөрсдөөс нь гарсан, хорооноос гарсан санал шүү. Тэгээд энийг сайн анхаараад аваарай гэж хэлмээр байна.

**П.Анужин:** Оюунчимэг гишүүн санал хэллээ. Санал хураалт. Түрүүн нэр авчихсан тийм ээ. Санал хураалт явуулъя гишүүд ээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39.10-д заасны дагуу Байнгын хороо хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэнэ.

Гишүүд хуулийн төслийн тухайн зүйлтэй холбогдуулан хууль санаачлагчаас зарчмын зөрүүтэй саналын талаар мөн ажлын хэсгээс асууж болно.

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулж асуулт асуух гишүүн байна уу. Байхгүй бол ажлын хэсгээс зарчмын зөрүүтэй 17 санал гаргасан байгаа. Уншиж танилцуулъя.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтын 7.1.11 дэх заалтын “дасгал хөдөлгөөн,” гэсний өмнө “зөв хооллолт,” гэж нэмж, тус заалтын “эрүүл мэнд, нийгмийн оролцоог” гэснийг “эрүүл мэндийг” гэж өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Сарангэрэл, Жаргалмаа, Сандаг-Очир цаашид “ажлын хэсэг” гэнэ. Санал хураалт. 54,5 хувиар санал дэмжигдлээ.

2.Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалтын 7.2,9 7.2.11 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж 7.2.9 дэх заалтын дугаарыг 7.2.13 дахь заалт болгох. Санал хураалт. Санал хураалт 72,7 хувиар дэмжигдлээ. Энэ чинь дутуу 7.2.13-аа сая уншиж танилцуулаагүй байна шүү дээ. Уучлаарай гишүүд ээ. Техникийн алдаа гарлаа. Дахиж уншиж танилцуулъя. Санал хураалтыг цуцалъя.

Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалтын 7.2.9<sup>1</sup>, 7.2.11 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 7.2.9<sup>1</sup> дэх заалтын дугаарыг 7.2.13 дахь заалт болгох:

“7.2.13.ахмад настныг нийгмийн харилцаанд идэвхтэй оролцуулах, соёл, урлаг, спорт, орчин үеийн техник хэрэгсэл ашиглах, сурч

хөгжихөд чиглэсэн үйл ажиллагааг дэмжих, зохион байгуулах;

7.2.11.аймаг, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага, сум, хорооны нийгмийн ажилтан, өрх, сум, тосгоны эмч, эмнэлгийн мэргэжилтэн байнгын асаргаа шаардлагатай ахмад настныг асарч байгаа иргэний эрүүл мэнд, ачааллыг үнэлэн ахмад настныг энэ хуулийн 4.1.9-д заасан үйлчилгээнд хамруулах, эсхүл гэр бүлийн бусад гишүүдийн асрамжид шилжүүлэх талаар санал гаргах;" санал гаргасан. Ажлын хэсэг санал хураалт. 54,5 хувиар санал дэмжигдлээ.

3.Төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалтын 7.8 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“7.8.Төрийн болон орон нутгийн өмчит барилга байгууламжид энэ хуулийн 7.6-д заасан “Ахмадын өргөө” болон бусад төвд байрлан үйл ажиллагаагаа явуулж байгаа бол барилга байгууламж, хөдлөх хөрөнгийн ашиглалт, засварын зардлыг гэрээний үндсэн дээр орон нутгийн төсвөөс хэсэгчлэн, эсхүл бүрэн санхүүжүүлж болно.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 63,6 хувиар санал дэмжигдлээ.

5.Төслийн 1 дүгээр зүйлийн 5 дахь заалтын 9.1.4, 9.1.5, 9.1.6 дахь заалтыг нэгтгэн доор дурдсанаар өөрчлөн найруулж, 9.13 дахь хэсэг болгох:

“9.13.Хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн холбогдох Засгийн газрын гишүүнтэй хамтран дараах чиглэлээр арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлнэ:

9.13.1.хөдөлмөрийн болон боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран ахмад настныг боловсролын байгууллагад ажиллуулах;

9.13.2.хөдөлмөрийн болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран ахмад настныг эрүүл мэндийн байгууллагад ажиллуулах;

9.13.3.хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн холбогдох Засгийн газрын гишүүнтэй хамтран эрхлэх асуудлын хүрээнд ахмад настныг ажиллуулах.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Асуулт байна. Содномын Чинзориг сайд асуулт асууна. Санал хураалтыг түр цуцалъя. Уг зүйлийн хуулийн заалттай холбогдуулж Чинзориг сайд асуулт асууна. Чинзориг сайдын микрофоныг нээж өгье.

**С.Чинзориг:** Энэ 2 асуулт байх юм Сарангэрэл гишүүн ээ. Хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн холбогдох Засгийн газрын гишүүдтэй хамтран эрхлэх асуудлын хүрээнд ахмад настныг ажиллуулах талаар төлөвлөгөө баталж, хэрэгжүүлнэ гээд нэг л ингээд томилоод аваад явчихгүй, боловсрол, эрүүл мэнд 2-ыг яагаад ингээд онцолсон юм. Адилхан л Засгийн газрын гишүүн шүү дээ. Энийг яагаад заавал онцлоод байгаа юм. Ялгаад. 1 л нэг л өгүүлбэр болгоод л авчихгүй.

2 дахь асуудал нь ингээд ажиллуулж болно. Одоо ажиллуулаад байгаа юм. Тэгэхээр одоо энэ нэг юм лав байгаа шүү дээ. Нөгөө үндсэн цалинг нь өгдөг, үндсэн цалин өгдөг. Тухайлбал эрүүл мэндийн салбарт ажиллаж байгаа нөгөө өндөр настнууд чинь нөгөө 3 жил тутам олгодог нөгөө 6 сарын тэтгэмж олгодоггүй гээд ингээд бөөн үг, хэл байдаг юм байна лээ. Тэгэхээр хэрвээ ажиллуулж байгаа бол үндсэн цалинг нь олгоод байх юм уу, цалин хөлсийг нь олгох юм уу, тэр урамшуулал элдэв бусын нэмэгдлийг нь яах юм бэ гэдгийг уг нь бас нэг тодорхой хариулт хэлчихмээр л байгаа юм даа. Одоо зүгээр гэрээгээрээ ажил гүйцэтгэх гэрээ гээд ингээд л үндсэн цалин өгөөд л, тэгээд л бас хүний хөдөлмөрийг бол бас л мөлжиж л байгаа шүү дээ. Нөгөө элдэв янзын урамшуулал,

нэмэгдлийг нь өгөхгүй байгаад байгаа энийг яах юм. Энэ дээр бас нэг тодорхой хариулт уг нь хэлчихмээр л байгаа юм даа. Энд нэг мөсөн томъёолоод.

**П.Анужин:** Ажлын хэсгийн ахлагч Сарангэрэл асуултад хариулъя.

**Д.Сарангэрэл:** Тэгээд энэ хуулийн төсөлд бас одоо хуульд байхгүй, ахмадуудын нэлээн хүсэн хүлээж байгаа асуудлууд орчихсон явж байгаа юм. Тухайлбал тэтгэврийн насанд хүрээгүй байхад нь хүчээр тэтгэвэрт гаргахыг энэ хуулиар бүүр хориглож байгаа. Энэ бол одоо шинэ заалт. Түүнээс гадна ахмад настан тэтгэвэрт гарчхаад буцаад бас ажил хөдөлмөр эрхэлж болох. Өөрөөр хэлэх юм бол ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих ийм заалт бас орсон байгаа. Энэ хүрээнд яагаад эрүүл мэнд, боловсролыг ингээд онцолсон бэ гэвэл энэ хууль санаачлагчид ингэж оруулж ирсэн юм байна лээ. Ажлын дэд хэсэг дээр ингэж яригдсан яригдсан. Бусад нь чухал биш юм уу гээд. Тэгээд энэ дээр бол ямар үндэслэл хэлж байгаа вэ гэвэл эрүүл мэнд, боловсролын салбарт хүний нөөцийн хүн хүчний дутагдал бол нэлээд ер нь түгээмэл байдаг 1 дүгээрт, 2 дугаарт эрүүл мэнд, боловсрол бол Монгол төрийн тэргүүлэх бодлогын асуудал учраас энийг тодотгож өгөөд бусад салбаруудад бас мөн ижил тэгш үйлчлэхээр ингэж оруулж байгаа.

Одоо тухайлбал өндөр настан ажил хийлээ, хөдөлмөр эрхэллээ гэхэд бол нэгэнтээ тэтгэвэрт гарчихсан байгаа учраас цалингаа аваад явна. Цалингаас нь элдэв шимтгэл суутгахгүй байхаар ингэж зааж өгсөн байгаа. Отгонбилэг нэмж хариулах уу.

**П.Анужин:** 2 номерын микрофонд Отгонбилэг хариулт өгье.

**Ю.Отгонбилэг:** Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам Отгонбилэг. Чинзориг гишүүний асуултад хариулъя. Энэ хуулийн 9.13-д заасан энэ арга

хэмжээний төлөвлөгөөг бол тухайн сайд нь холбогдох Хөдөлмөрийн сайд, нөгөө холбогдох сайдтай хамтарч батлахдаа арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлнэ гэж байгаа. Тэгэхээр энд бол зөвхөн төрийн байгууллагад ажиллуулахаас гадна бусад чиглэлүүдээр ахмад настныг сайн дурын юм уу, эсвэл ямар байдлаар бас ажиллуулах вэ гэдгийг нь ерөнхий байгаа учраас одоо яг тийм цалинг нь өгнө гэхэд хэцүү. Тэгэхдээ энэ харилцаа бол угаасаа Хөдөлмөрийн хуулиар зохицуулагдаж явах ёстой. Нэгэнт тэтгэвэрт гарсан болохоор Хөдөлмөрийн хуулийн харилцаагаараа, хөдөлмөрийн гэрээгээрээ л зохицуулагдах юм байгаа юм. Тэгээд энэ арга хэмжээний төлөвлөгөө бол яг одоо төрийн байгууллагад ажиллуулна гэсэн бол үндсэн цалин ч гэдэг юм уу тэгж нарийсах ёстой. Тэгэхээр энд ерөнхий заасан байгаа учраас энэ ерөнхийгөөрөө яваад, харин яг зохицуулалт нь бол Хөдөлмөрийн хуулиараа зохицуулагдаж явахаар байгаа юм. Нэгэнт нөгөө тэтгэвэрт гарсан ахмад настан учраас.../минут дуусав/

**П.Анужин:** Асуулт асууж хариулт авлаа. Санал хураалт гишүүд ээ. Санал хураалт 72,7 хувиар дэмжигдлээ.

6.Төслийн 1 дүгээр зүйлийн 5 дахь заалтын 9.1.7 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 9.1.4 дэх заалт болгох:

“9.1.4.хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээний хүрээнд ажилласан ахмад настны цалин хөлсийг Хөдөлмөрийн тухай хуулийн 104 дүгээр зүйлд заасны дагуу тооцон гэрээний дагуу олгох.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 63,6 хувиар санал дэмжигдлээ.

7.Төслийн 1 дүгээр зүйлийн 6 дахь заалтын 9.9 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах

“9.9.Ахмад настныг хөдөлмөрийн гэрээ, ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах болон тэдгээртэй адилтгах гэрээний дагуу ажиллуулж байгаа ажил олгогч Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 7 дугаар зүйлийн 7.6-д заасны дагуу тэтгэврийн даатгалын төрөлд даатгуулахгүй байж болно. Санал гаргасан ажлын хэсэг. Асуулт асууя. Содномын Чинзориг сайд асуулт асууя.

**С.Чинзориг:** Энэ уг нь санаа нь бол зөв. Гэхдээ ажиллуулж байгаа ажил олгогч шийдэх гээд байна шүү дээ. Би ажил олгогч биш, харин ахмад өөрөө хүсвэл НДШ-ээ ч төлж болно. Төлөөд тэтгэврээ шинэчлэн тогтоолгох эрх нь нээлттэй, эсвэл өөрөө хүсвэл шимтгэл төлөхгүйгээр гэрээгээ байгуулаад явах эрхийг нь тэр ахмад настанд өөрт нь өгөх хэрэгтэй. Тэгэхгүй бол ажил олгогч хүнийг ингээд шууд даатгал төлөхгүй гэж ажил олгогчид давуу эрх олгож болохгүй. Харин шимтгэлээ төлөх юм бол давуу эрхтэй шүү дээ. Тэгээд дараагаар нь хэдэн жилийн дараа шимтгэл төлсөн жил нь нэмэгдээд, тэтгэврээ шинэчлэн тогтоолгох эрх нь нээгдэнэ. Эсвэл өөрөө хүсвэл шимтгэлээ төлж болно. Хүсвэл шимтгэл төлөхгүйгээр байж болно гээд тэр ажил олгогчид биш ахмадууд өөрсдөд нь л үлдээх хэрэгтэй дээ манайхан. Уг нь тийм шүү дээ. Тэгэхгүй л бол ажил олгогчид давуу байдал олгоод хүнийг ерөөсөө шимтгэл төлөхгүй байж болно гээд ажил олгогчид эрх өгчхөөд байна. Энэ бол буруу. Энийг эргэж томъёолмоор л юм байна даа.

**П.Анужсин:** Чинзориг сайдын хэлж байгаа санал бол бас авууштай, зөв санал байна. Байнгын хороо энэ хэлсэн саналтай уялдуулж томъёоллоо. Шинэ томъёоллыг уншиж танилцуулъя.

“9.9.Ахмад настан хөдөлмөрийн гэрээ, ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах болон тэдгээртэй адилтгах гэрээний дагуу ажиллаж байгаа бол Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 7 дугаар

зүйлийн 7.6-д заасны дагуу тэтгэврийн даатгалын төрөлд даатгуулахгүй байж болно.” гэсэн ингэж томъёолж оруулж ирлээ. Сая шинэ томъёоллыг танилцууллаа. Болж байна уу. Байж болно гэхээж байгаа шүү дээ. Даатгуулахгүй байж болно. Нээлттэй орхичхож байгаа юм. Санал хураалт. Нээлттэй орхисон шүү. Сая солиод томъёоллоо шүү дээ. Нээлттэй, тэгэхдээ ажил олгогч нь өөрөө гэдэг томъёоллоор томъёоллоо. Ажилтан өөрөө гэдгээр. Санал хураалт гишүүд ээ. Санал хураалт явуулъя. 54,5 хувиар санал дэмжигдлээ.

Төслийн 1 дүгээр зүйлийн 6 дахь заалтын 9.11 дэх хэсгийн “өөрөө хүсэлт гаргаагүй” гэсний өмнө “65 насанд хүрээгүй бөгөөд” гэж нэмж, 9.12 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 9.11, 9.12 дахь хэсгийн дугаарыг 9.10, 9.11 дэх хэсэг болгох:

“9.12.Аж ахуйн нэгж, байгууллага Хөдөлмөрийн тухай хуулийн 145 дугаар зүйлийн 145.4-д заасны дагуу ахмад настныг ажлын байраар хангана.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 54,5 хувиар уг санал дэмжигдлээ.

Төслийн 1 дүгээр зүйлийн 6 дахь заалтын 9.10 дахь хэсгийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал уначихлаа. Одонтуяа гишүүн санал гаргая. Санал хураалтыг цуцалъя. Одонтуяа гишүүн санал гаргая.

**С.Одонтуяа:** Би уг нь дэмжихээр дараад байхаар сүүлийн 3 санал хураалт дандаа эсрэг гараад байна. Байнгын хороон дарга аа.

**П.Анужсин:** Одонтуяа гишүүн түрүүнээс хойш хэлээд байна. Энэ техник ажиллахгүй байна гээд, сүүлийн 3 санал эсрэг гарчихлаа гэж байна. Одонтуяа гишүүний хэлсэн санал дээр үндэслэж саяын явуулсан санал хураалтыг хүчингүй болгох саналын

томъёоллоор санал хураалт явуулъя гишүүд ээ. Одонтуйа гишүүний төхөөрөмжийг шалгахыг ажлын хэсгээс хүсэж байна. 54,5 хувиар санал дэмжигдлээ. Дахин уншиж танилцуулъя гишүүд ээ, анхааралтай байгаарай.

Төслийн 1 дүгээр зүйлийн 6 дахь заалтын 9.10 дахь хэсгийг хасах. Санал хураалт. 54,5 хувиар санал дэмжигдлээ.

10.Төслийн 1 дүгээр зүйлийн 7 дахь заалтын 11.1.4 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“11.1.4.ахмад настнаа хүндлэх, ёс заншил, уламжлалаа өвлүүлэх, мэдлэг, туршлагыг залуу үед хүргэх зэрэг арга хэмжээг ахмадын өдрийн хүрээнд бүх шатны Засаг дарга, аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагууд 10 дугаар сарын 01-нээс 07-ны өдрүүдэд зохион байгуулна.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Уг саналтай холбоотой Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн үг хэлье.

**М.Оюунчимэг:** Ахмадуудтай уулзаж байхдаа хамгийн чухал ярьж байсан зүйл нь нөгөө одоо залуу үедээ ахмад үеэ хүндэтгэх, соён гэгээрүүлэх ажлыг маш сайн явуулахгүй бол одоо ахмадуудыг хүндлэх энэ тэр бол автобусанд суугаад явж байхаас өгсүүлээд л ер нь маш зөрчигдөж байна. Эрх их зөрчигдөж байна гэдэг асуудлууд их ярьж байна лээ л дээ. Тэгэхээр бүгдээрээ энэ дээр зөвхөн нэг ахмадын өдрийг 7 хоног л зохион байгуулна гэдэг үг өөрөө бас арай хязгаарлагдмал болж байна. Угаасаа л ахмадын баяраа хийнэ. Тэгэхээр энийг зүгээр бараг он, сар тавихгүйгээр энийг зохион байгуулж хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийтэд энийг ямар байгууллага нь хариуцдаг юм, тэгж ийм юм зохион байгуулна гэдгийг тодорхой зааж оруулж өгөөд хийвэл зүгээр байх аа. Тэгэхгүй бол энэ зөвхөн 7 хоногийн хугацаанд л ийм юм явуулах юм

шиг ийм ойлголттой энэ хуульд заагаад өгчихвөл энэ өөрөө утгагүй байна шүү дээ. Угаасаа л ахмадын баяраар ахмадуудаа хүлээж авдаг арга хэмжээ хийдэг. Харин энэ соён гэгээрүүлэх хүндэтгэх ёс уламжлалаа хүүхэд багачуудыг ер нь багаас нь сургах энэ тэрийг бол үзэжлэг, ясли дээр нь буюу боловсролын хуультай уяад энийг хэвшүүлэх гэдэг сургалт маягаар зааж өгөөд оруулаад өгөх хэрэгтэй байна. Энэ чинь өөрөө маш чухал асуудал шүү дээ. Японд бол үзэжлэгийн наснаас нь хүүхдийг ахмадаа хүндэтгэх зааж өгдөг шиг бид нар яг энийг боловсролын хуультай уяад ийм юм явуулна гээд бүр заагаад өгчихвөл зүгээр байх. Ганц 7 хоног гэдгийг бол хасах саналтай байна.

**П.Анужин:** Ажлын хэсгийн гишүүн Бадарчийн Жаргалмаа хариулт өгье.

**Б.Жаргалмаа:** Ер нь бол Ахмад настны тухай хуулийн хэрэгжилтийг хянах ажлын хэсгийн хүрээнд ер нь ахмадууд маань ахмадууд руу чиглэсэн үйл ажиллагаа бас дутмаг байна гэдэг зүй зүйлийг маш ихээр ярьж байсан. Өөрөөр хэлэх юм бол 2021 оны Нийгмийн бодлогын байнгын хорооны 1 дүгээр тогтоолоор батлагдсан ажлын хэсэг бас орон нутагт ч гэсэн явж ажиллаж байсан. Орон нутагт явахад ер нь ахмад настнаа хүндлэх, дээдлэх энэ ёс уламжлал ер нь гээгдэж байна гэдэг ийм зүйлийг бас ихээр ярьж байсан. Тэгэхлээр Ахмад настны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл дээр ажлын хэсэг ажиллахдаа ер нь юуг анхаарсан бэ гэвэл бүхий л талаар нь ахмадуудаа хөгжүүлэе, хөдөлмөр эрхлүүлэе, чанартай насжилтыг бий болгоё, ёс уламжлалаа өвлүүлэх тал дээр анхааръя гэдэг олон зүйлийг бас ярьж байсан. Ер нь жилд бүрийн 10 дугаар сарын 1-ний өдөр бол дэлхийн ахмад настны өдөр. Монгол Улсын Засгийн газар ч гэсэн ахмад настнаа хүндлэн дээдлэх энэ өдрийг уламжлал ёсоор тэмдэглэгдсээр ирсэн. Зөвхөн 10 сарын 1-ний өдрийг ахмадуудаа баярлуулаад өнгөрдөг биш,

хариуцах эзэнтэй байлгах, өөрөөр хэлэх юм бол харьяалалгүй иргэдээ харьяалалтай болгох тал дээр онцгой анхаарах гэдэг зүйл заалт бол энэ хуулийн бас нэг мөн чанар нь мөнөөсөө мөн. Гэхдээ бид нар зөвхөн 10 сарын 1-ний өдрийг ахмад настны өдөр болгоод тэмдэглэх үү, уламжлал болгосон энэ ажлыг өргөн дэлгэр болгох уу, хүрээллийг өргөжүүлэх үү гэдэг тал дээр бас онцгойлон анхаарч, сая хууль санаачлагчийн хэлсэнчлэн зөвхөн 10 сарын 1-ний өдөр ахмадын өдөр байна гэхээсээ илүүтэйгээр өргөн хүрээнд болгоё. Хэн нэгнийг орхигдуулахгүй ахмадаа асран дээдэлж хүндлэх ёс уламжлалыг өргөжүүлэе гэдэг үүднээсээ ийнхүү өдрийг нь нэмж өгсөн юм байгаа юм. Ер нь боловсролын хуульд ч тэр зүйл заалтууд байдаг. Одоо бид нар бас хүмүүнлэг боловсролын хууль бас хэлэлцэж байгаа энэ цаг мөчид энэ заалт хүмүүнлэг боловсролын уг нь хуульдаа орчихсон явж байгаа юм. Тэгэхээр уг нь хүмүүнлэг боловсролын хуулиа бид нар баталчих юм бол яг ахмад настнаа хүндэлнэ. Дээдлэх ёс уламжлалаа дээдлэх гэдэг ийм зүйл заалт хүмүүнлэг боловсролын хуульдаа ороод явж байгаа. Тэгэхээр ер нь бол ахмадын хуульдаа яг энэ зүйл, заалтыг нарийн тооцож, өдрөө зааж өгч байгаа нь ийм учиртай юм шүү гэдгийг хэлье.

**П.Анужин:** Сарангэрэл гишүүний хэлж байгаа зарчмын саналыг дэмжиж байна. Салбарын маш чухал том хууль явж байхад салбарын сайд ирцдээ орчхоод, тэгээд одоо байхгүй байна. Хэлэлцэгдэх явцад гэдэг саналыг хэллээ. Энэ саналыг дэмжиж байна. Санай ажлын хэсэг, Байнгын хороо энэ хуралдааны ирцийг ялангуяа энэ салбарын том хууль хэлэлцэж байхад салбарын сайд нь байх асуудал бол зарчмын хувьд маш зөв санал шүү. Энийг бол анхаарч цаашаа. Өнөөдөр чинь нээрээ 3 дахь өдөр Засгийн газрын хуралдаан давхцаж байна гэж байна. Хуулийн санаачлагч нь бол бас орж ирээд хуралдаанд оролцож байна. Асуулт

асууж, хариулт авлаа. Санал хураалт явуулья гишүүд ээ. Санал хураалт.

Ер нь манай Эрүүл мэндийн сайд Чинзориг сайд бол ер нь ямар нэгэн шалтгаан хэлдэггүй, салбарын хуулиудтай холбоотой, асуудалтай холбоотой зүйл дээр үргэлж бас биечлэн оролцож, хариуцлагатай хариулт өгдөг байдлыг бас энд дурдах нь зүйтэй. Салбарын сайдаа дуудаарай. 60 хувиар санал дэмжигдлээ.

Ер нь манай эрүүл мэндийн сайдын, Чинзориг сайдын үед бол бас бодлогын том хуулиуд гарч Байнгын хороотой маш сайн хамтарч ажилласан гэдгийг бас хэлэх нь ч зүйтэй.

11.Төслийн 1 дүгээр зүйлийн 8 дахь заалтын 13.6, 13.7, 13.9, 13.11 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 13.5, 13.6, 13.8, 13.9 дэх хэсэг болгох:

“13.5.Нийгмийн халамжийн сан, орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх энэ хуулийн 7.1.1-7.1.5, 7.1.7-7.1.11-д заасан үйлчилгээний жишиг үнэ болон иргэний хариуцах төлбөрийн хэмжээг нийгмийн хамгааллын болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран баталж, хэрэгжүүлнэ.”

13.6.Энэ хуулийн 7.1.1-7.1.5, 7.1.7-7.1.11-д заасан үйлчилгээнд зарцуулах хөрөнгө нийгмийн халамжийн сангаас ахмад настанд зориулан зарцуулах нийт хөрөнгийн 10 хувиас багагүй байна.

13.8.Энэ хуулийн 9.13-д заасан арга хэмжээний зардлыг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан, боловсрол, эрүүл мэндийн болон холбогдох асуудал эрхэлсэн төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад тусган санхүүжүүлнэ.

13.9.Энэ хуулийн 7.1, 8.1.1, 8.1.2, 10.1.2, 10.2-т заасан үйлчилгээг цахимжуулах, давхардлыг арилгах, гэрээт байгууллагын санхүүжилтийг

гүйцэтгэлд үндэслэн бодитоор олгох зорилгоор ахмад настны Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д заасан мэдээллийг ашиглаж болно.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 60 хувиар санал дэмжигдлээ.

Төслийн 1 дүгээр зүйлийн 8 дахь заалтын 13.5, 13.10 дахь хэсгийг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 60 хувиар дэмжигдлээ.

13.Төслийн 1 дүгээр зүйлийн 9 дэх заалтын 14.9 дэх хэсгийн “ахмадын сангийн үйл ажиллагааг хэрэгжүүлсэн байдал” гэснийг “Ахмадын сан”-ийн үйл ажиллагааны тайлан” гэж, “харьяалагдах дээд байгууллагадаа тайлагнаж, хамт олондоо мэдээлнэ.” гэснийг “байгууллагын нийт ажилтны хуралд танилцуулж, хэлэлцүүлнэ.” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 70 хувиар санал дэмжигдлээ.

14.Төслийн 1 дүгээр зүйлийн 9 дэх заалтын 14.10, 14.11 дэх хэсгийг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 60 хувиар дэмжигдлээ.

15.Төслийн 1 дүгээр зүйлийн 10 дахь заалтын 15.9 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 15.5 дахь хэсгийн “үзүүлэх” гэснийг “үзүүлж” гэж, “ахмадын мэдээллийн санг бүрдүүлэн, баяжуулж, дүгнэлт гаргана” гэснийг “хяналт тавина” гэж өөрчилж, мөн хэсгийн “дэмжлэг үзүүлэх, оролцох, хяналт тавих, хөдөлмөр эрхлэлтэд” гэснийг хасаж, 15.5, 15.9 дэх хэсгийн дугаарыг 15.4, 15.7 дахь хэсэг болгох:

“15.7.Аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллага 50 ба түүнээс дээш ахмад настантай бол ахмадуудтайгаа харилцах үндсэн чиг үүрэгт зөвлөх болон туслах үүрэгтэйгээр ахмад настныг төлөөлсөн нэг хүнийг гэрээгээр ажиллуулж болно.” Санал

гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 60 хувиар дэмжигдлээ.

16.Төслийн 1 дүгээр зүйлийн 10 дахь заалтын 15.4, 15.7 дахь хэсгийг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Бусад гишүүдээ дуудаарай. Санал хураалтыг түр цуцалъя. Бадарчийн Жаргалмаа гишүүн ажлын хэсгийн гишүүн тодруулж асууя. Байнгын хороо гишүүдийн ирцийг бүрдүүлэх тал дээр анхаарч гишүүдийг дуудаарай ирцэд орчхоод гарч яваад байна.

**Б.Жаргалмаа:** 2021 оны Байнгын хорооны 1 дүгээр тогтоолоор түрүүн би хэлсэн Ахмад настны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих ажлын хэсэг байгуулаад, ажлын хэсгийг ахалж ажиллаж байсан юм. Тэгээд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамтайгаа бас тухайлан орон нутаг дахь, дүүрэг хорооддоо бүгдэд нь очиж ажилласан. Тэгээд энэ дээр нэг зүйл орхигдоод байдаг. Одоо энэ шинэчлэгдсэн найруулга дээр 7.1.7 дээр ахмад настны асаргааны хувилбарт үйлчилгээ гээд ороод ирчихсэн байгаа. Тэгээд манайхан Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Тунгалаг дарга, Ундрал энэ тэр бүгдээрээ мэдэж байгаа байх. Зүгээр миний нэг бас анхаарч ажиллаад байсан зүйл юу вэ гэх юм бол энэ асаргааны хувилбарт үйлчилгээ дээр бид нар анхааръя. Хэсгийн ахлагч нартай гэдэг юм уу, хороотойгоо бас нэг ойрхон хэдэн ахмадууд маань ийм үйлчилгээнд хамрагдаж чадаад байна. Бид нар бол хуулиар үйлчилгээ үзүүлж байгаа. Тийм ээ. Гэхдээ дүүргийн үйл ажиллагаанд юм уу, хорооны үйл ажиллагаанд идэвхтэй оролцож чаддаггүй, гэртээ ганцаараа байдаг асран хамгаалах асран хамгаалах хүн бас хөдөлмөр эрхлээд гэртээ ганцаараа үлдчихдэг ийм ахмадуудыг бид нар хамруулж чадахгүй байна. Тэгэхлээр энэ төлбөрт үйлчилгээгээ ахмадын чиглэлээр ажилладаг сайн дурын төрийн бус байгууллагуудтайгаа гэрээлэн гүйцэтгэх энэ ажлаа онцгойлон анхаарч нарийн зааж өгье. Гэртээ байгаа асрах хүнгүй

байгаа, зарим ахмадууд нь бүүр гудамжинд гарчихсан хэвтэж байдаг. Тийм ээ. Ийм ахмадууддаа бид нар асрах ёстой, төр анхаарах ёстой гэдэг үүднээсээ энэ рүү чиглэсэн асаргааны үйл ажиллагаагаа хэдүүлээ идэвхжүүлж гэдэг зүйлийг ярьж байсан. Тэгэхээр энэ заалт маань яг орсон болов уу. Өөрөөр хэлэх юм бол нийгмийн үйлчилгээ дээр бид нар бас очоод сардаа нэг хяналт тавьчихдаг, хоол ундыг нь хангаачихдаг, ус цасандаа орсон байна уу, үгүй юу, түлш түлээг нь бид нар нэг бэлдэж өгдөг нэг ийм үйлчилгээ байдаг шүү дээ. Зүйл заалтаараа энэ үйлчилгээ маань яг энэ хуульдаа аль зүйл заалт дээрээ орсон байгаа билээ. Энэ дээр бас олон нийтэд мэдээллийг өгөөдхөөч гэж хүсэж байна.

**П.Анужсин:** Чухал асуулт асууж байна. 3 номерын микрофонд Ундрал дарга хариулт өгье.

**Б.Ундрал:** Жаргалмаа гишүүний асуултад хариулъя. Асаргаа болон ахмад руу чиглэсэн өдөр тутмын үйлчилгээ дээр энэ ахмадын хууль дээр бол нэлээдгүй өөрчлөлт оруулсан байгаа. Халамжийн тухай хууль дээр олон нийтийн оролцоонд түшиглэсэн гээд төрийн бус байгууллагуудтай төрийн үйлчилгээг гэрээлэн гүйцэтгэдэг 10 төрлийн үйлчилгээ байдаг. Энэ дээр бид нар ажлын хэсэг бол маш сайн ярилцаж байгаад жишээлбэл өдрөөр эмчлэх, асран сувилах үйлчилгээ гэж оруулсан байгаа. Өдрийн үйлчилгээ, явуулын үйлчилгээ, зөвлөгөө өгөх үйлчилгээ гэсэн төрлүүдийг дээрээс нь үнэ тарифыг нь энэ хуулийг гарсны дараа бид нар зохицуулалтын сангийн яамтай ярьж байгаад үнэ тарифыг нь бас боломжит хувилбараар нь төсөвт суулгая гэсэн ийм саналын дагуу өөрчлөлт орсон байгаа.

**П.Анужсин:** Жаргалмаа гишүүн тодруулъя.

**Б.Жаргалмаа:** Өөрөө ажлын хэсэгт ажиллачхаад юу асуугаад байгаа юм гэж зарим гишүүд маань тодруулж магадгүй.

Тэгэхдээ бас иргэд олон нийтдээ бас мэдээлэл өгөх үүднээс тодруулж байгаа шүү гэдгийг хэлье. Нэр томъёоллоор бас орчихсон байгаа. Би яагаад бас дахиад асуугаад байна вэ гэвэл төрийн үйлчилгээг гэрээлэн гүйцэтгэж байгаа ахмад настны асаргаа сувилгааны байгууллагууд одоо яг өнөөдөр хэд ажиллаж байгаа билээ. Өнөөдөр хувьсах зардлаа нэг иргэнээр тооцон хэд өгч байгаа билээ. Эргээд тэр төрийн бус байгууллагуудаа бид нар чадавхжуулах тал дээр ер нь яаж анхаарах билээ гэдэг дээрээ мэдээлэл өгөөч. Би олон нийтэд мэдээлэл өгөх гээд байгаа юм шүү.

**П.Анужсин:** Ундрал дарга аа, хариулт өгөхдөө нэлээдгүй өөрчлөлт оруулсан гээд яриад байх юм. Тэгэхээр цөөхөн өөрчлөлт оруулсан гэсэн үг юм уу. Нэлээд хэмжээний их өөрчлөлт гэсэн үг юм уу. Зөв ярихгүй бол энэ хууль хэлэлцүүлж байхад цөөхөн өөрчлөлт гэсэн үг юм уу. Та энэ үг дээрээ анхаар. Эсвэл та энэ юмаа тайлбарлаж ярь. Ундрал даргын микрофоныг нээж өгье. Цөөн хэмжээний өөрчлөлт оруулсан гэсэн үг юм уу, их хэмжээний гэсэн үг юм уу.

**Б.Ундрал:** Сайдын тушаалаар олон нийтийн оролцоонд түшиглэсэн журмын өөрчлөлт сая өнгөрсөн сар буюу 4 сард өөрчлөлт орсон байгаа. Энэ дээр бид нар үнэ тарифыг нь бас өөрчлөлт оруулчихсан. Төрлүүдийг нь одоо яг энэ дагаж мөрдөж байгаа 10 төрлийг бид нар бас сайдын тушаалаар өөрчлөлт оруулаад Хууль зүйн яам руу бид нар батлуулахаар ингээд орчихсон. Энэ хууль дээр зохицуулалтаа бид нар тодорхой болгочихно. Зохицуулалт тодорхой болгохоор дахиад сайдын тушаалаар үнэ төрөл бол хэвээрээ сая батлагдсан журмаараа явчихна. Төсвийг нь бид нар нэмэх асуудал байгаад байгаа юм. Төрөөс төрийн бус байгууллага руу гэрээлэн гүйцэтгэж байгаа зохицуулалт нь хэвээрээ.../минут дуусав/



**П.Анужин:** Тодорхой хариулт өгөөд, гүйцээгээд дорвитойхон шиг хариулаарай. 2 номерын микрофонд гүйцээгээд хариулъя. Хариултаа дорвитойхон шиг хуульдаа яг ямар өөрчлөлт оруулсан юм бэ. Мэдээлэл өгөх зорилгоор асуугаад байна гээд асууж байна.

**П.Отгонбилэг:** Энэ Ахмад настны тухай хуулийн өөрчлөлт дээр хамгийн томоохон өөрчлөлтүүд нь яг сая Жаргалмаа гишүүний асуусан энэ ахмад настанд үзүүлэх үйлчилгээг сайжруулах, хувилбарт үйлчилгээг сайжруулах, дээрээс нь энэ үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх, асаргааны хувилбарт үйлчилгээг нөгөө Япон болон бусад улсын жишээн дээр бол нэлээн олон төрөл болгоод, тэгээд энэ хуулийн төслийн 7 дугаар зүйл бүхэлдээ үйлчилгээний төрлүүд дээр бүх заалтуудыг нэмсэн. Энэ журмыг нь хэн гаргах юм. 13 дугаар зүйл дээр бол санхүүжилтийн хувьд нэлээн шууд юу гэдэг юм, Нийгмийн халамжийн сангийн ахмад настанд зориулсан хөрөнгийн 10-аас доошгүй хувь гэж хэлж байгаа нь одоо бол 500, 600 сая төгрөг зарцуулж байгааг цаашид бол 15-20 тэрбум болгож нэмэгдүүлэхээр байгаа юм. Ингэснээрээ бол яг нөгөө төрийн бус байгууллага энэ ахмад настны чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагуудын санхүүжилт, нэр төрөл маш сайн нэмэгдэхээр байгаа. Түүнчлэн сая бас нөгөө Сарангэрэл гишүүний хэлж байгаагаар яг нөгөө ахмад настны асрамжийн үйлчилгээ дээр бас жишээ нь байнгын асаргаатай хүн, ахмад настан асрамжид явж байгаа бол нөгөө жишиг нормативыг нь 3 дахин нэмэгдүүлэх ч гэдэг юм уу тухайн байгууллагын бусад урсгал зардалд нь дэмжлэг үзүүлэх гээд маш том өргөн хэмжээнд нэлээн бүх зүйл заалтууд дээр бол нэмэлт, өөрчлөлт оруулж яг энэ үйлчилгээг сайжруулах дээр анхаарч хэрэгжилтийг нэмэгдүүлэх талаар заалтууд тусгасан юм.

**П.Анужин:** Сунжирсан, тодорхой байдлаар бас хариулахгүй байна. Манай ажлын хэсгийнхэн бас хууль дээрээ ажилласан юм чинь их тодорхой, ялангуяа иргэд маань тулж байгаа асуудлаа энэ хуулиар яаж шийдэгдэх юм бэ гэдгийг хүлээж байгаа учраас илүү товч тодорхой хариулт цаашидаа өгч явахыг хүсэж байна. Санал хураалт гишүүд ээ, 16 дээр санал хураалт. 80 хувиар санал дэмжигдлээ.

17.Төслийн 1 дүгээр зүйлийн 11 дэх заалтын 16.3 дахь хэсгийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг.

Чинбүрэн гишүүн санал хэлье.

**Ж.Чинбүрэн:** Уучлаарай сая дэмжиж санал өгөх гэж байсан чинь амжиж дарж чадсангүй. Дахин санал хураалгаж өгөхийг хүсье. Хүчингүй болгоод.

**П.Анужин:** Чинбүрэн гишүүн саяын санал хураалтыг хүчингүй болгож өгнө үү гэсэн санал гаргаж байна. Уг томъёоллоор санал хураалт явуулъя. 70 хувиар санал хураалтыг хүчингүй болгох санал дэмжигдлээ. Санал хураалт.

17.Төслийн 1 дүгээр зүйлийн 11 дэх заалтын 16.3 дахь хэсгийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Ахин уншиж танилцууллаа. Санал хураалт. 80 хувиар уг санал дэмжигдлээ.

Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх гишүүн байна уу. Байхгүй бол ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй 1 санал байгаа. Уншиж танилцуулъя.

18.Төслийн 2 дугаар зүйлийн “болон ахмад настны өмчлөлийн байр, орон сууц, газар, бусад эд хөрөнгө, тэтгэвэр, мөнгөн хөрөнгийг нь түүний зөвшөөрөлгүйгээр болон айлган сүрдүүлэх, дарамт, шахалт үзүүлэн хүч хэрэглэн авч ашиглах зэргээр” гэснийг “ахмад настны тэтгэвэр, тэтгэмж,

Иргэний хуулийн 84 дүгээр зүйлд заасан хөрөнгийн эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд халдсан,” гэж өөрчилж, “7 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 7.2.5 заалтын “үйл ажиллагааг” гэсний өмнө “болон ахмад настны сайн дурын” гэж” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Уг санал 60 хувиар дэмжигдлээ.

Төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асууж, уг хэлэх гишүүн байна уу. Байхгүй бол ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй 4 саналаар санал хураалт явуулна. Унишиж танилцуулъя.

Төслийн 3 дугаар зүйлийн 2 дахь заалтын 7.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“7.3.Энэ хуулийн 4.1.7-4.1.9, 4.1.11, 7.1-д заасан үйл ажиллагааны журмыг дараах байдлаар баталж, иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлнэ:

7.3.1.энэ хуулийн 4.1.7-4.1.9, 4.1.11-д заасан үнэлгээ хийх, үйлчилгээ үзүүлэх, мэргэжлийн удирдлагаар хангах, энэ хуулийн 7.1-д заасан үйлчилгээ үзүүлэх, иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагыг сонгон шалгаруулах журмыг нийгмийн хамгааллын болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран баталж, хэрэгжүүлэх;

7.3.2.энэ хуулийн 7.1.6, 7.1.12-т заасан үйлчилгээг тусгай зөвшөөрөлтэй, магадлан итгэмжлэгдсэн, эрүүл мэндийн даатгалын байгууллагатай гэрээ байгуулсан эрүүл мэндийн байгууллагаар гүйцэтгүүлэх;

7.3.3.энэ хуулийн 7.1.1-7.1.5, 7.1.7-7.1.11-д заасан үйлчилгээг аймаг, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага 7.3.1-д заасан сонгон шалгаруулах журмын дагуу гэрээний үндсэн дээр иргэн, аж ахуйн

нэгж, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх.” Санал хураалт. Хаана байна. Санал хураалтыг түр цуцалъя. Засаж уншина. 7.3.1-ийг дахиж унишъя.

7.3.1.энэ хуулийн 4.1.7-4.1.9, 4.1.11-д заасан үнэлгээ хийх, үйлчилгээ үзүүлэх, мэргэжлийн удирдлагаар хангах, энэ хуулийн 7.1-д заасан үйлчилгээ үзүүлэх, иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагыг сонгон шалгаруулах журмыг нийгмийн хамгааллын болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран баталж, хэрэгжүүлэх. Санал хураалт. Санал 80 хувиар дэмжигдлээ.

Төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Тийм байна. Уучлаарай.

Төслийн 3 дугаар зүйлийн 2 дахь заалтын 7.6 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“7.6.Энэ хуулийн 7.1-д заасан үйлчилгээг үзүүлэх зорилгоор нутгийн захиргааны байгууллага, иргэн, аж ахуйн нэгж, байгууллага аймаг, дүүрэг, сум, тосгон, хороонд “Ахмадын өргөө”, сэргээн засах, идэвхтэй насжилтыг дэмжих чиглэлээр үйл ажиллагаа явуулах төвийг байгуулан ажиллуулж болно.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 70 хувиар санал дэмжигдлээ. Санал хураалт. 80 хувиар дэмжигдлээ.

Төслийн 3 дугаар зүйлийн 3 дахь заалтын 8.1.1 дэх заалтын “эрүүл мэндийн даатгалын сангаас олгох” гэснийг “нийгмийн халамжийн сангаас олгох” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал 60 хувиар дэмжигдлээ.

Төслийн 3 дугаар зүйлийн 4 дэх заалтын 15.1, 15.2 дахь хэсгийг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 70 хувиар уг санал дэмжигдлээ.

Төслийн 4 дүгээр зүйлийн “үйлчилгээ, дэмжлэг хүндэтгэлийн хэмжээ” гэснийг “Хоёрдугаар бүлэгт заасан ахмад настанд үзүүлэх үйлчилгээ, дэмжлэг, хүндэтгэлийн хэмжээ” гэж, “дэмжлэгийн хэмжээ” гэснийг “8, 10-12 дугаар зүйлд заасан ахмад настанд үзүүлэх дэмжлэгийн хэмжээ” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 80 хувиар уг санал дэмжигдлээ.

Төслийн 5 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу. Байхгүй 5 дугаар зүйлийн ажлын хэсгээс ирсэн саналыг уншиж танилцуулъя.

Төслийн 5 дугаар зүйлээс “13 дугаар зүйлийн 13.3 дахь хэсгийн “7.1-д заасан үйлчилгээ” гэснийг хасаж, төслийн 4 дүгээр зүйлийн “тус тус” гэсний өмнө “, 13 дугаар зүйлийн 13.3 дахь хэсгийн “7.1-д заасан үйлчилгээ” гэснийг “7.1.1-7.1.5, 7.1.7-7.1.11-д заасан үйлчилгээг нийгмийн халамжийн сан болон орон нутгийн төсвөөс” гэж” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 70 хувиар уг санал дэмжигдлээ.

Төслийн 6 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу. Ажлын хэсгээс санал гараагүй. Санал хураалт явуулъя гишүүд ээ. Санал хураалт. 80 хувиар уг санал дэмжигдлээ.

Төслийн 7 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу. Байхгүй бол ажлын хэсгээс санал ирээгүй болно.

Найруулгын 1 санал байгаа. Уншиж танилцуулъя.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 4.1.9 дэх заалтын “иргэн” гэсний өмнө “төрийн байгууллага” гэж нэмэх. Санал хураалт. Түр хүлээж байгаарай. Санал хураалтыг цуцалъя.

Найруулгын 4 санал гарсан байна. Уншиж танилцуулъя.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 4.1.9 дэх заалтын “иргэн” гэсний өмнө “төрийн байгууллага” гэж нэмэх.

2.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 4.1.8 дахь заалтын “цогцоор” гэснийг “цогц үйлчилгээ” гэж, 4.1.9 дэх заалтын “өдрөөр, түр, урт хугацаанд байрлуулан асрах, байнга асрах төрөлжсөн асрамжийн, асралт гэр бүлээр асруулах, гэрээр асрах зэрэг бусад шаардлагатай үйлчилгээг” гэснийг “ахмад настныг төрөлжсөн асрамжийн, гэрээр, асралт гэр бүлээр, өдрөөр, түр, урт хугацаагаар, байнга асрах үйлчилгээг” гэж, 4.1.11.дэх заалтын “онол, арга зүй, мэргэшлийн хувьд удирдан чиглүүлэх, дэмжих, зөвлөн туслах, хөгжүүлэх” гэснийг “мэргэшүүлэх, үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, удирдлагаар хангах” гэж, 1 дүгээр зүйлийн 3 дахь заалтын 7.2.14 дэх заалтын “зарим” гэснийг “шаардлагатай” гэж, 1 дүгээр зүйлийн 8 дахь заалтын 13.8 дахь хэсгийн “зээлийн зардлыг оруулахгүйгээр” гэснийг “зээлийн хэмжээг тооцохгүйгээр” гэж, 1 дүгээр зүйлийн 10 дахь заалтын 15.3 дахь хэсгийн “хэсэгчлэн болон бүрэн” гэснийг “хэсэгчлэн, эсхүл бүрэн” гэж, 2 дугаар зүйлийн “төсвийн байгууллага, тухайн жилийн төсвийн зардалдаа тусган” гэснийг “төсвийн байгууллага, тухайн жилийн төсөвт тусган” гэж, 3 дугаар зүйлийн 3 дахь заалтын 8.1.6 дахь заалтын “үнэ төлбөргүй зорчих” гэснийг “ахмад настны нийтийн тээврээр зорчсон” гэж тус тус өөрчлөх.

3.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 4.1.9 дэх заалтын “төрийн бус” гэсний өмнөх “төрийн болон” гэснийг, 1 дүгээр зүйлийн 3 дахь заалтын “орох бөгөөд үнэлгээг хийхдээ ахмад настанд чирэгдэлгүй байхыг анхааран” гэснийг, 2 дугаар зүйлийн “хөнгөлөлтийн” гэснийг тус тус хасах.

4.Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн бүтэц, нэр томъёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл, заалтын дугаар, эшлэлийг нийцүүлж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 70 хувиар дэмжигдлээ.

Одоо хамт өргөн мэдүүлсэн болон бусад төслийн анхны хэлэлцүүлгийг хийнэ.

**Нэг.Хөдөлмөрийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хийнэ.**

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбоотой асуулт асуух гишүүн байна уу. Байхгүй бол санал ирээгүй байна. Ажлын хэсгээс.

Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу. Ажлын хэсгээс мөн санал ирээгүй.

Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн Хөдөлмөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хийж дууслаа.

**2.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хийнэ.**

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбоотой асуулт асуух гишүүн байна уу. Ажлын хэсгээс санал ирээгүй.

Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу. Байхгүй байна. Ажлын хэсгээс мөн санал ирээгүй.

Төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу. Санал ирээгүй. Ахмад настны тухай

хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хийж дууслаа.

**Нийгмийн халамжийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хийнэ.**

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх гишүүн байна уу. Ажлын хэсгээс зарчмын зөрүүтэй 2 санал ирсэн байна. Ажлын хэсгээс ирсэн 2 саналтай холбоотой асуулт асууж, үг хэлэх гишүүн байна уу. Байхгүй байна. Унишиж танилцуулъя.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 19.12 дахь хэсгийн “хэмжээ,” гэсний өмнө “хэлбэр,” гэж нэмж, 19.14 дэх хэсгийн “19.11-д заасны дагуу ахмад настныг төрөлжсөн асрамжийн үйлчилгээнд хамруулж байгаа” гэснийг “9.1.1-д заасан үйлчилгээг ахмад настанд үзүүлж байгаа” гэж, “хувийн хэвшил, төрийн бус байгууллагад” гэснийг “аж ахуйн нэгж, байгууллагад” гэж, “заасан нормативын дагуу” гэснийг “заасны дагуу” гэж, “тооцох бөгөөд” гэснийг “тооцох” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалт 60 хувиар дэмжигдлээ.

Төслийн 1 дүгээр зүйлийн 19.10 дахь хэсгийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 19.15 дахь хэсгийг хасах. 70 хувиар санал дэмжигдлээ.

### **Найруулгын санал**

Төслийн 1 дүгээр зүйлийн 19.11. дэх хэсгийг “хувийн хэвшил, төрийн бус байгууллагад” гэснийг “аж ахуйн нэгж, байгууллагад” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Жаргалмаа гишүүн байхгүй байна. Би санал гаргая. Сая төхөөрөмж

ажиллаагүй учраас саяын саналыг цуцалж өгөх саналыг гаргаж байна. Санал хураалт явуулъя гишүүд ээ. Саяын явуулсан саналыг хүчингүй болгох санал хураалт. Санал хураалтыг хүчингүй болгох томъёоллоор санал хураалт явуулж байна. 70 хувиар уг санал дэмжигдлээ.

Санал хураалт явуулъя. найруулгын санал дээр төслийн 1 дүгээр зүйлийн 19.15 дахь хэсгийг хасах. Санал хураалт явуулъя. Санал хураалт гишүүд ээ. Санал хураалт 60 хувиар уг санал дэмжигдлээ.

Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Хуулийн төслийн 2 дугаар зүйл. Ажлын хэсгээс санал ирээгүй.

Төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу. Мөн санал ирээгүй. Ажлын хэсгээс.

Төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу. Ажлын хэсгээс санал ирээгүй.

Төслийн 5 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Байхгүй байна. Ажлын хэсгээс мөн зарчмын зөрүүтэй санал ирээгүй.

Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн Нийгмийн халамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хийж дууслаа.

**Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хийнэ.**

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу. Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй 1 саналаар санал хураалт явуулна.

Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 15.1.16 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“15.1.16.нийгмийн халамжийн байгууллагатай байгуулсан гэрээний дагуу гүйцэтгэсэн нийгмийн халамж, асрамжийн үйлчилгээний үйл ажиллагааны зардал;” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 70 хувиар санал дэмжигдлээ.

Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу. Байхгүй ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй 1 саналаар санал хураалт явуулна.

Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтын 15.1.17 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“15.1.17.асрамж, халамжийн байгууллага үйл ажиллагаагаа явуулах байрыг шинээр барих, тохижуулах, хүчин чадлыг нэмэгдүүлэх, өргөтгөх зорилгоор үзүүлсэн санхүүгийн дэмжлэг, хандив.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал 60 хувиар дэмжигдлээ.

Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хамт хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хийж дууслаа.

**Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хийнэ.**

Ажлын хэсгээс төслийг хууль санаачлагчид нь буцаах зарчмын зөрүүтэй санал гаргасан байна. Саналыг уншиж танилцуулъя.

Төслийн хууль санаачлагчид нь буцаах гэсэн саналын томъёоллоор санал

хураалт явуулъя. Санал 80 хувиар дэмжигдлээ.

**Компанийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хийнэ.**

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Ажлын хэсгээс бэлтгэсэн зарчмын зөрүүтэй 1 саналаар санал хураалт явуулна.

Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 16.2.8 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“16.2.8."Ахмадын сан" байгуулах, мөнгөн хөрөнгийн хэмжээг тогтоох;” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт 70 хувиар дэмжигдлээ.

Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу. Байхгүй бол ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй 1 саналаар санал хураалт явуулна.

Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтын 76.1.19 дэх заалтыг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 80 хувиар санал дэмжигдлээ.

Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн Компанийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хийж дууслаа.

**Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хийнэ.**

Ажлын хэсгийн хэсгээс төслийг хууль санаачлагчид нь буцаах санал ирүүлсэн байна. Уг томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 70 хувиар санал дэмжигдлээ.

**Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хийнэ.**

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбоотойгоор асуулт асуух гишүүд байна уу. Алга байна. Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй 2 саналаар санал хураалт явуулна.

Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 16.1<sup>1</sup> дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 16.21 дэх хэсэг болгох:

“16.21.Энэ хуулийн 15.1.7, 15.1.11, 15.1.13-д заасан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлдэг байгууллагын дэргэд ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд байнгын асаргаа шаардлагатай эсэхийг тодорхойлох, дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий Эмнэлэг хяналтын комисс ажиллуулна.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 60 хувиар уг санал дэмжигдлээ.

Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтын 16.1<sup>2</sup> хэсгийн “дүрэм” гэснийг, “ажиллах журам” гэж, “16.1<sup>2</sup>” дугаарыг, “16.22.” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал 80 хувиар дэмжигдлээ.

Төслийн 2 дугаар зүйлтэй холбоотойгоор санал хэлэх гишүүн байна уу. Ажлын хэсгээс санал ирээгүй болно.

Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хийж дууслаа.

**Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хийнэ.**

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбоотой асуулт асуух гишүүн байна уу.

Алга байна. Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулна.

Төслийн 1 дүгээр зүйлийн 11.7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “1.2<sup>1</sup>” дахь заалтыг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Сая зөрүүлж бичсэн байна шүү. 2 дугаар зүйлийн гэдгийг 1 дүгээр зүйлийн гэсэн байна. Протоколд зөвөөр нь авч тэмдэглэж үлдээхийг хүсье.

Төслийн 1 дугаар зүйлийн 11.7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.3. дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1.3.тэтгэвэр, тэтгэмж, хуваарьт болон дундын эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд халдсан бол зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 80 хувиар дэмжигдлээ.

Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу. Санал ирээгүй. Ажлын хэсгээс.

Төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу. Мөн ажлын хэсгээс санал ирээгүй.

Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хийж дууслаа.

**Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хийнэ.**

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу. Ажлын хэсгээс зарчмын зөрүүтэй 1 санал ирсэн. Унишж танилцуулъя.

Төслийн 1 дүгээр зүйлийн 5.4 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн 4.3<sup>1</sup>. дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 4.5 дахь заалт болгох:

“4.4.Ахмад настны тэтгэвэр, тэтгэмжээ ашиглах, захиран зарцуулах эрхэд халдсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол албадан сургалтад хамруулж долоогоос гуч хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл оногдуулна;” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 70 хувиар дэмжигдлээ.

Төслийн 2 дугаар зүйлтэй холбоотой асуулт асуух гишүүн байна уу. Байхгүй байна. Ажлын хэсгээс санал ирээгүй болно.

Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хийж дууслаа.

**Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хийнэ.**

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу. Байхгүй бол ажлын хэсгээс санал ирээгүй байна.

Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу. Байхгүй бол ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй 2 саналаар санал хураалт явуулна.

Төслийн 2 дугаар зүйлийн 35.2.6 дахь заалтын “түр байрлуулах, түр хоноглох зэрэг газар байрлаж байсан” гэснийг, “түр байрлуулах газарт байсан,” гэж, “бөгөөд” гэснийг “тохиолдолд” гэж, “садан” гэснийг,

“садангийн хүн” гэж тус тус өөрчилж, тус заалтын “тэнэмэл амьдралтай” гэснийг, “иргэн нас барсан” гэсний өмнөх “ганиц бие” гэснийг, “түүний” гэснийг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал 80 хувиар дэмжигдлээ.

Төслийн 2 дугаар зүйлийн 35.2.7 дахь заалтыг хасах төслийн 2 дугаар зүйлийн 35.2.7 дахь заалтыг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 80 хувиар санал дэмжигдлээ.

Хуулийн төсөлтэй холбоотой зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулж дууслаа.

Найруулгын шинж чанартай 1 санал ирсэн байгаа.

Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн бүтэц, нэр томъёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл, заалтын дугаар, эшлэлийг нийцүүлж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Санал хураахын өмнө хуулийн төслийн санаачлагч Нямаа Энхболд дарга үг хэлнэ.

**Н.Энхболд:** Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт тухай хуулийн хууль болон түүнийг дагалдаж орсон хуулиудын төслийн анхны хэлэлцүүлгийг Байнгын хороогоор хэлэлцэж дууслаа. Идэвхтэй оролцож дэмжсэн гишүүддээ баярлалаа.

Би зүгээр Байнгын хорооны танилцуулга дээрээ санаачилсан гишүүдийг бүгдийг нь нэрээр нь биччихээрэй гэж хүсэх байна. Манай 14 гишүүн санаачилсан.

2 дугаарт бас ажлын хэсэг маш шуурхай хуралдаад, бид нарын оруулсан төсөл дээр бас хэрэгтэй өөрчлөлтүүдийг нэмж тусгасан. Идэвхтэй ажилласан

Сарангэрэл гишүүн, Жаргалмаа гишүүн, Сандаг-Очир гишүүн 3-даа бас тусгайлан ахмадуудынхаа нэрийн өмнөөс талархал илэрхийлж байна. Энэ дүгнэлтэд орохгүй байх. Тэгэхдээ би хууль санаачлагчийн хувьд хэлж байгаа юм. Баярлалаа та бүхэндээ.

**П.Ануужин:** Маш их баярлалаа. Уучлаарай 1 зүйлийг орхигдуулсан байна.

Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байхгүй. Зарчмын зөрүүтэй санал ажлын хэсгээс санал ирээгүй.

Төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан мөн одоо асуулт асуух гишүүн байгаагүй. Санал мөн ирээгүй.

Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын засаг засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг байнгын хороогоор хийж дууслаа.

Монгол Улсын Их Хурлын гишүүн Нямаагийн Энхболд нарын 14 гишүүнээс өргөн мэдүүлсэн Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг Нийгмийн бодлогын байнгын хороогоор хийж дууслаа.

Чуулганы нэгдсэн хуралдаанд анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх Байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Даваажанцаны Сарангэрэл танилцуулна. Гишүүд ээ, түр хүлээж байгаарай. Санал хураалт.

Дахин уншиж танилцуулъя. Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн бүтэц, нэр томъёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл, заалтын дугаар, эшлэлийг нийцүүлж өөрчлөх.



Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 90 хувиар дэмжигдлээ.

12.15 цаг.

Дараагийн асуудалдаа оръё.

**Засгийн газраас 2024 оны 5 дугаар сарын 1-ний өдөр өргөн мэдүүлсэн Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн анхны хэлэлцүүлгийг хийнэ.**

Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танхимд урьж байна. Ажлын хэсгийн бүрэлдэхүүн танхимд орж ирсэн байна. Пүрэвийн Оюунцэцэг Эрүүл мэндийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Намдагийн Гэрэлт-Од Эрүүл мэндийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын ахлах шинжээч, Дүгэрсүрэнгийн Баясгалан Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүй бодлогын газрын ахлах мэргэжилтэн, Ганхуягийн Түвшинбаяр Эрүүл мэндийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын Салбарын хууль, эрх зүйн шинэчлэлийн судалгаа, төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн. Байна уу. Байна. Цэдэнбалын Батзул Төрийн худалдан авах ажиллагааны газрын дарга, Шаравнямбуугийн Энхтуяа Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Ламжавын Зэндмаа Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газрын Лиценз, зөвшөөрлийн зохицуулалтын газрын дарга, Даваасүрэнгийн Оюун-Эрдэнэ Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын Эм хангамжийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Тогтохын Мөнхтуул Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналтын зохицуулалтын газрын Эмийн бүртгэлийн хэлтсийн дарга, Рэнцэнгийн Энхсүрэн Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газрын Эмнэлгийн тоног төхөөрөмжийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Максимын Пүрэвсүрэн Гаалийн ерөнхий газрын Хорио цээрийн хэлтсийн Эм,

биобэлдмэлийн хяналт хариуцсан гаалийн улсын байцаагч, Машбаатарын Халиунаа “Эрүүл мэнд реформ” ТББ-ын гишүүн, Иваны Балжинням Монгол эм зүйн байгууллагын нэгдсэн “Эм” холбооны гүйцэтгэх захирал, Мятавын Бат-Эрдэнэ Монголын эмнэлгийн инженерчлэлийн нийгэмлэгийн тэргүүн гэсэн бүрэлдэхүүнтэйгээр ажлын хэсэг хуралцан ирсэн байна.

Хуулийн төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн танилцуулгыг та бүхэндээ танилцуулъя.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 5 дугаар сарын 1-ний өдөр нэн яаралтай хэлэлцүүлэхээр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурал 2024 оны 5 дугаар сарын 3-ны өдөр нэгдсэн хуралдаанаараа хэлэлцээд, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Нийгмийн бодлогын байнгын хорооны 2024 оны 5 дугаар сарын 2-ны өдрийн 5 дугаар тогтоолоор Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Байнгын хороо болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулж, ажлын хэсгийн ахлагчаар Улсын Их Хурлын гишүүн П.Анужин, бүрэлдэхүүнд Улсын Их Хурлын гишүүн Жаргалмаа, Оюунчимэг, Сарангэрэл, Чинбүрэн нар ажиллалаа.

Ажлын дэд хэсэг 3 удаа, ажлын хэсэг 2 удаа хуралдаж, ажлын хэсгийн

хуралдаанаар хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй 35 санал, найруулгын 1, хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаарх 9 саналын томъёоллыг хэлэлцэн, санал хураалт явуулж хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Түүнчлэн, ажлын хэсэг уламжлалт анагаах ухааны салбарын эрдэмтэн, судлаач нартай уулзаж, хуулийн төсөлд уламжлалт эмийн зохицуулалтын талаар ирүүлсэн холбогдох саналыг хэлэлцэн шийдвэрлэж, хуулийн төсөлд тусгалаа.

Ажлын хэсэг хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдэд дараах зохицуулалтыг нэмж тусгалаа. Үүнд:

1.Төслийн нэр томъёоны тодорхойлолт болон эм, эмнэлгийн хэрэгслийн зөвшөөрөлтэй холбогдсон зарим зохицуулалтыг Зөвшөөрлийн тухай хуультай нийцүүлэн өөрчилж, тусгай зөвшөөрлийн хугацааг сунгах тохиолдолд хуульд заасан зохистой дадлын стандартыг үндэслэн сунгах зохицуулалтыг нэмж орууллаа.

2.Эм, эмнэлгийн хэрэгслийн үйлдвэрлэл, эм хадгалалт, түгээлт, эмийн сан, лаборатори, эмийн жорын зохистой дадлын стандартыг стандартчил техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага батлахаар төсөлд нэмж тусгалаа.

3.Эмийн зах, эмийг зах зээлд гаргах зөвшөөрөл олгох зохицуулалтыг бүртгэл болгон өөрчилж, худалдах тусгай зөвшөөрөл эзэмшигч мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх эмээс бусад эмийг цахим жор болгон захиалгын дагуу хүргүүлэхээр. Эм эмнэлгийн хэрэгслийг зөвхөн мэргэжлийн хэвлэл, албан ёсны цахим хуудсаар иргэд олон нийтэд сурталчлан таниулахаар, эмнэлгийн тоног төхөөрөмжийн хэрэглэгчийн

гарын авлагын мэдээллийн агуулгыг тодорхой болгох, “эмнэлгийн жижиг хэрэгсэл” гэснийг “эмнэлгийн хэрэглэгдэхүүн” гэж өөрчилж, хуулийн нэр томъёог жигдлэх зэрэг өөрчлөлтийг хуулийн төсөлд оруулж ажиллалаа.

4.Уламжлалт эмийн үйлдвэрүүдийн төсөв, санхүү, хөрөнгө оруулалт, хүний нөөцийн өнөөгийн нөхцөл байдалд уялдуулан уг эмийн үйлдвэрүүдэд дагаж мөрдөх үйлдвэрийн зохистой дадлын стандартын хугацааг хойшлуулж, 2029 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс уламжлалт эмд гений өөрчлөлтийн шалгуурыг тавихгүй байх, уламжлалт эм, тэдгээрийн түүхий эдийн чанар, аюулгүй байдлыг шинэчлэхэд формакапен өгүүллийг ашиглахгүй байх.

5.Үйлдвэрлэх-экспортлох тусгай зөвшөөрөл эзэмшигч, дотоодын үйлдвэрлэгч, био эквивалент судалгаа, өнчин эмийн бүртгэл, бүртгэлгүй эм, өндөр, дунд эрсдэлтэй эмнэлгийн хэрэгслийг улсын хилээр нэвтрүүлэх заалтыг 2027 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөх, шилжилтийн үеийн зохицуулалтыг төсөлд нэмж тусгасан болно.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаарх ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээсээ хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Ажлын хэсгийн танилцуулгатай холбоотойгоор асуулт асууж үг хэлэх гишүүн байна уу. Байхгүй байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39.10-д заасны дагуу Байнгын хороо хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэнэ. Гишүүд хуулийн төслийн тухайн зүйлтэй

холбогдуулан хууль санаачлагчаас зарчмын зөрүүтэй саналын талаар мөн ажлын хэсгээс асуулт тавьж болно.

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу. Төслийн 1 дүгээр зүйл дээр байхгүй байна.

Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу. Байхгүй. Мөн ажлын хэсгээс санал ирээгүй.

Төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Байхгүй байна. Мөн ажлын хэсгээс зарчмын зөрүүтэй санал ирээгүй.

Төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу. Байхгүй байна. Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй 1 санал байгаа. Унишж танилцуулъя.

Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.10.г дэд заалтыг, мөн зүйлийн 4.1.18 дахь заалтын “, эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүн” гэснийг хасаж, 4.1.27 дахь заалтын “иргэн,” гэсний дараа “гадаад, дотоодын” гэж нэмж, мөн зүйлийн 4.1.14 дэх заалтын “зах зээлд гаргах зөвшөөрөл” гэснийг “эм, эмнэлгийн хэрэгсэл, эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүний бүртгэл” гэж, 4.1.17 дахь заалтын “зах зээлд гаргах зөвшөөрөлтэй” гэснийг “эм, эмнэлгийн хэрэгсэл, эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүний бүртгэлтэй” гэж, 4.1.32 дахь заалтын “, бэлтгэх арга, зааврыг тодорхойлон” гэснийг “хэрэглэх аргыг заан” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Анужин, Жаргалмаа, Оюунчимэг, Сарангэрэл, Чинбүрэн /цаашид “ажлын хэсэг” гэх/ Санал хураалт. 66,7 хувиар санал дэмжигдлээ.

Төслийн 5 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу. Ажлын хэсгээс санал ирээгүй.

Төслийн 6 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу. Ажлын хэсгээс зарчмын зөрүүтэй 1 санал ирсэн байгаа.

Төслийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.1.2 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 6.2 дахь хэсгийг хасах:

“6.1.1.эм, уламжлалт эм, биобэлдмэл, тэдгээрийн түүхий эд, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт эм, эмнэлгийн тоног төхөөрөмж, лабораторийн оношилгооны хэрэгсэл, эмнэлгийн хэрэглэгдэхүүн үйлдвэрлэх-экспортлох тусгай зөвшөөрөл;

6.1.2.эм, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт эм, эмнэлгийн тоног төхөөрөмж, лабораторийн оношилгооны хэрэгсэл, эмнэлгийн хэрэглэгдэхүүн импортлох-ханган нийлүүлэх тусгай зөвшөөрөл;” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 77,8 хувиар уг санал дэмжигдлээ.

Төслийн 7 дугаар зүйлтэй холбоотой санал байна уу. Сжлын хэсгээс 1 зарчмын зөрүүтэй санал ирсэн. Унишж танилцуулъя.

Төслийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсгийн “хамт тухайн” гэснийг “хуулийн этгээд” гэж, мөн хэсгийн “нийлүүлэх тусгай зөвшөөрөл олгоно” гэснийг “нийлүүлж болно” гэж, 7.2.1, 7.2.2 дахь заалтын “сан бүхий энэ хуулийн 6.1.3-т заасан худалдах” гэснийг “сангийн” гэж, мөн заалтын “дүүргийн эмийн сангүй” гэснийг “сангийн хүрэлцээгүй” гэж, 7.5.1, 7.5.2, 7.5.3, 7.5.4 дэх заалтын “олгох, сунгахад” гэснийг “олгоход” гэж тус тус өөрчилж, мөн зүйлийн 7.5 дахь хэсгийн “Зөвшөөрлийн тухай хуулийн 5.1 дүгээр зүйлийн 3.1-д,” гэснийг, 7.13 дахь хэсгийн “хууль эрх зүйн хүрээнд” гэснийг тус тус хасаж, 7.1 дэх хэсгийн “бүтээгдэхүүнээ” гэсний дараа “түүхий эдээ” гэж, 7.11 дэх хэсгийн “саналаар” гэсний дараа “хуралдааны шийдвэр”

гэж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 7.16 дахь хэсэг нэмэх:

“7.16.Энэ хуулийн 7.5.1, 7.5.3, 7.5.4, 19.1, 29.2.4-т заасан зохистой дадлын стандартыг стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага батална.”Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал 77,8 хувиар дэмжигдлээ.

Төслийн 8 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу. Байхгүй бол ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй 1 саналаар санал хураалт явуулна.

Төслийн 8 дугаар зүйлийн 8.1.5 дахь заалтын “зах зээлд гаргах зөвшөөрөл авсан” гэснийг “бүртгүүлсэн” гэж, 8.2.4 дэх заалтын “үнээр” гэснийг “хувь хэмжээгээр нэмэгдүүлж” гэж, мөн заалтын “худалдах” гэснийг “ханган нийлүүлэх” гэж тус тус өөрчилж, 8.1.6 дахь заалтын “улсын бүртгэл” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалт 77,8 хувиар дэмжигдлээ.

Төслийн 9 дүгээр зүйлтэй холбоотой санал асуух, үг хэлэх гишүүн байна уу. Байхгүй бол ажлын хэсгээс зарчмын зөрүүтэй 1 санал ирүүлсэн. Унишж танилцуулъя.

Төслийн 9 дүгээр зүйлийн 9.4.1 дэх заалтын “зах зээлд гаргах зөвшөөрөлгүй” гэснийг “бүртгэлгүй” гэж, 9.4.6 дахь заалтын “үнээр” гэснийг “хувь хэмжээгээр нэмэгдүүлж” гэж, мөн заалтын “худалдах” гэснийг “ханган нийлүүлэх” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 66,7 хувиар дэмжигдлээ.

Төслийн 10 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу. Байхгүй бол ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй 1 санал байна.

Төслийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсгийн “эмнэлгийн” гэснийг “эрүүл мэндийн байгууллагын” гэж, 10.4 дэх хэсгийн “жоргүй олгох эмийг цахимаар болон утсаар авсан” гэснийг “мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт эмээс бусад эмийг цахим жор болон” гэж, 10.8.1 дэх заалтын “зах зээлд гаргах зөвшөөрөлгүй” гэснийг “бүртгэлгүй” гэж, 10.8.10 дахь заалтын “үнээр” гэснийг “хувь хэмжээгээр нэмэгдүүлж” гэж тус тус өөрчилж, мөн зүйлийн 10.2 дахь хэсгийн “болон сумын эрүүл мэндийн төв” гэснийг, 10.8.1 дэх заалтын “улсын бүртгэлд бүртгэгдээгүй” гэснийг, 10.8.4 дэх заалтын “, үйлчлэх” гэснийг, 10.8.9 дэх заалтын “хаяг,” гэснийг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал 77,8 хувиар дэмжигдлээ.

Төслийн 11 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу. Байхгүй бол ажлын хэсэг зарчмын зөрүүтэй 1 санал оруулж ирсэн.

Төслийн 11 дүгээр зүйлийн 11.1.3 дахь заалтын “байгуулах,” гэсний дараа “эм, эмнэлгийн хэрэгслийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад” гэж нэмж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 11.1.7 дахь заалт нэмэх:

“11.1.7.эм, эмнэлгийн хэрэгслийн цувралын дугаар, стандарт код, тоо хэмжээг тухай бүр цахим санд оруулсан байна.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалт 77,8 хувиар дэмжигдлээ.

Төслийн 12 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу. Ажлын хэсгээс зарчмын зөрүүтэй 1 санал бэлтгэн ирүүлсэн. Унишж танилцуулъя.

Төслийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсгийг хасаж, мөн зүйлийн 12.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“12.1.Тусгай зөвшөөрлийн хугацааг сунгахад энэ хуулийн 8-11 дүгээр зүйлд заасан үүрэг, шаардлага, Эрүүл мэндийн тухай хуулийн 19.17-д заасан нөхцөлийг хангасан эсэх талаарх дүгнэлтийг үндэслэнэ.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 77,8 хувиар дэмжигдлээ.

Төслийн 13 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу. Байхгүй. Ажлын хэсгээс санал ирээгүй.

Төслийн 14 дүгээр зүйлтэй холбоотой асуулт асуух гишүүн байна уу. Байхгүй бол ажлын хэсгээс мөн зарчмын зөрүүтэй санал ирээгүй болно.

Төслийн 15 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу. Асуулт асуух гишүүн байхгүй бол ажлын хэсгээс зарчмын зөрүүтэй 1 саналыг хүргүүлсэн. Танилцуулья.

Төслийн 15 дугаар зүйлийн гарчгийн “Зах зээлд гаргах зөвшөөрөл” гэснийг “Эм, эмийн үйлчлэгч бодисыг бүртгэх” гэж, 15.1 дэх хэсгийн “зах зээлд гаргах зөвшөөрөлтэй” гэснийг “бүртгэлтэй” гэж, 15.2 дахь хэсгийн “зах зээлд гаргах зөвшөөрлийг” гэснийг “бүртгэлийг” гэж, мөн зүйлийн 15.2.2 дахь заалтын “зөвшөөрөл олгох” гэснийг “бүртгэл” гэж, 15.3 дахь хэсгийн “Зах зээлд гаргах зөвшөөрөл олгоход” гэснийг “Эм, эмийн үйлчлэгч бодисыг бүртгэхэд” гэж, 15.3.2 дахь заалтын “шаардлага” гэснийг “стандарт” гэж, 15.5 дахь хэсгийн, 15.5.4 дэх заалтын “зах зээлд гаргах зөвшөөрлийг” гэснийг “эм, эмийн үйлчлэгч бодисын бүртгэлийг” гэж тус тус өөрчилж, 15.4 дэх хэсгийн “зах зээлд гаргах зөвшөөрөл олгох, сунгах, өөрчлөх, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 77,8 хувиар энэ санал дэмжигдлээ.

Төслийн 16 дугаар зүйлтэй холбоотой асуулт асууж, үг хэлэх

гишүүн байна уу. Байхгүй. 16 дугаар зүйл дээр ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй 1 санал ирсэн. Унишиж танилцуулья.

Төслийн 16 дугаар зүйлийн 16.4 дэх хэсгийн “эрүүл мэндийн асуудал эрхэлсэн” гэснийг “эм, эмнэлгийн хэрэгслийн асуудал хариуцсан” гэж, 16.9 дэх хэсгийн “үйлдвэрлэсэн” гэснийг “үйлдвэрлэж бүртгэсэн” гэж, 16.10 дахь хэсгийн “энэ хуулийн 16.9-д зааснаар” гэснийг “түргэвчилсэн байдлаар” гэж, 16.11, 16.12 дахь хэсгийн “зах—зээлд гаргах зөвшөөрөлтэй” гэснийг “бүртгэлтэй” гэж тус тус өөрчилж, 16.11 дэх хэсгийн “импортын” гэснийг өмнө “Энэ хуулийн 16.10-д зааснаас бусад” гэж нэмж, мөн зүйлийн 16.15 дахь хэсгийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 77,8 хувиар санал дэмжигдлээ.

Төслийн 17 дугаар зүйлтэй холбоотой саналтай гишүүн байна уу. Байхгүй бол ажлын хэсгээс 1 зарчмын зөрүүтэй санал ирүүлсэн. Унишиж танилцуулья.

Төслийн 17 дугаар зүйлийн 17.1.2 дахь заалтын “зах зээлд гаргах зөвшөөрөл авахад шаардагдах бүтээгдэхүүний” гэснийг “бүртгэлийн” гэж, 17.1.6 дахь заалтын “онцгой” гэснийг “нийгмийн эрүүл мэндийн ноцтой” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 77,8 хувиар дэмжигдлээ.

Төслийн 18 дугаар зүйлтэй холбоотойгоор санал хэлэх гишүүн байна уу. Байхгүй бол ажлын хэсгээс зарчмын зөрүүтэй 1 санал хүрэл ирүүлсэн байгаа.

Төслийн 18 дугаар зүйлийн гарчгийн, 18.1, 18.2 дахь хэсгийн “зөвшөөрөл” гэснийг “бүртгэл” гэж, 18.1 дэх хэсгийн “Шинэ эм” гэснийг “Эм” гэж, 18.3 дахь хэсгийн “зөвшөөрлийг” гэснийг “бүртгэлийг” гэж, мөн хэсгийн “эрүүл мэндийн асуудал эрхэлсэн” гэснийг “эм,

эмнэлгийн хэрэгслийн асуудал хариуцсан” гэж, 18.4 дэх хэсгийн “зөвшөөрөлд” гэснийг “бүртгэлд” гэж тус тус өөрчилж, мөн зүйлийн 18.1 дэх хэсгийн “эрүүл мэндийн” гэсний дараа “байгууллага, эсхүл гадаад улсын эрх бүхий” гэж, 18.3 дахь хэсгийн “баримт бичиг,” гэсний дараа “Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, эсхүл гадаад улсын эрх бүхий байгууллагаас олгосон зөвшөөрөл,” гэж тус тус нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 77,8 хувиар санал дэмжигдлээ.

Төслийн 19 дүгээр зүйлтэй холбоотой санал хэлэх гишүүн байна уу. Жигжидсүрэнгийн Чинбүрэн гишүүн асуулт асууна.

**Ж.Чинбүрэн:** Би асуулт асуухгүй ээ, зүгээр энэ дээр нөгөө Эмийн хянан шалгах түр хорооноос явуулсан эмийн үнийн өсөлтийн шалтгаан нөхцөлд хяналт шалгалт хийсэнтэй холбогдуулаад бид тогтоол Их Хурлаар баталсан. Уг тогтоолд бол эмийн үндэсний лавлагаа, лаборатори нэгдсэн удирдлагатай, өртөг зардал багатай, эдийн засгийн хувьд өгөөжтэй ийм лаборатори ажиллуулах асуудлыг бид тогтоолд оруулсан. Энэ төслийн 19 дүгээр зүйл бол ерөөсөө л энэ лабораторитой холбоотой чанарыг шалгах асуудал байгаа. Тэгэхээр энэ энэ дээр би зориуд протоколд бичүүлэх гэж байгаа зүйл бол ер нь бид хүнсний аюулгүй байдал, эмийн аюулгүй байдал бол нэг дээвэр доор, нэг удирдлага доор өртөг зардал нь оновчтой зарцуулж байгаа зүйл нь тус тусдаа баахан тендер реактив зардал зарлаад байдаг биш, ийм тогтолцоо бол бидэнд хэрэгтэй байгаа. Тийм учраас яах вэ, зүгээр энэ хууль дээр ажлын хэсгээс бид энэ дээр бол нэгдсэн лаборатори байгуулах энэ тэр асуудлыг оруулаагүй ч гэсэн энийг Засгийн газрын гишүүн, Эрүүл мэндийн сайд та бас анхаарч, Засгийн газрын тогтоолуудаар энэ үр дүнтэй лабораторийн үйл ажиллагааг удирдах тогтолцоог заавал энэ Засгийн газрын асуудалд оруулж

анхаарал хандуулаарай гэж би энд зориуд цохон тэмдэглэж байна.

**П.Анужин:** Чинбүрэн гишүүн санал хэллээ.

Төслийн 19 дүгээр зүйлийг уншиж танилцуулъя. Төслийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсгийн “байгууллага” гэсний дараа “лабораторийн зохистой дадлын стандарт хангасан” гэж, 19.2 дахь хэсгийн “лаборатори” гэсний дараа “итгэмжлэгдсэн байх бөгөөд” гэж, 19.4 дэх хэсгийн “Ерөнхий” гэсний өмнө “Дотоод болон гадаадын” гэж тус тус нэмж, 19.5 дахь хэсгийн “шинэ эм, уламжлалт” гэснийг “анхдагч” гэж өөрчилж, мөн зүйлийн 19.10 дахь хэсгийн “ эсхүл иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн гомдлын дагуу яаралтай шинжлэх дээж,” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 66,7 хувиар уг санал дэмжигдлээ.

Төслийн 20 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу. Байна. Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн үг, санал хэлнэ.

**М.Оюунчимэг:** Бид нар энэ ДЭМБ, Дэлхийн банк, сүүлд нь аудитаас хийлгэсэн дүгнэлтүүд гээд бид нарын бас ажлын хэсэг гараад ингээд дүгнэлтүүд харж байхад манайд нөгөө гаднаас импортлож оруулж ирж байгаа эмүүдээс харахад нөгөө манайхны баримталж байгаа зүйл нь 5 улс орон тухайн компани бүтээгдэхүүнээ гаргадаг бол Монголд орж ирэх нь нээлттэй юм байна лээ шүү дээ. Тийм ээ. Тэгэхээр энэ дээр одоо харж ирэхэд ер нь эмийн чанар, гарал үүсэл нь тодорхойгүй ийм зүйлүүд бол нэлээд их гарлаа шүү дээ. Энийг та бүхэн маань ч өөрсдөө хүлээн зөвшөөрч байгаа. Тийм учраас бусад улс орны нэгэн адилаар энэ зах зээлд гаргахдаа одоо тэр СНГ-ийн орнуудад ихэвчлэн гаргадгийг тоогоо нэмээд л Монголын зах зээл рүү оруулж ирдэг болохоор, энэ эмийн хатуу өндөр зохицуулалттай орноос 5-ын 2 нь эндээс

байна. Энэ улс зах зээлд гаргадаг байх ийм шаардлагыг тавивал зүгээр байна. Тэгж байж энэ эмийн чанар энэ тэр өөр болно. Тэгэхээр яг энэ дээр одоо бол тийм эмийн өндөр зохицуулалттай улс орон гэдэг заалт байхгүй учраас тухайн оруулж ирж байгаа компани нь 4, 5 оронд зах зээлд гаргадаг гээд л. Тэр нь СНГ-ийн орон юм уу Зүүн өмнөд Азийнх юм уу хаана нь тодорхойгүй зүгээр л энэ нэг тоо хийгээд байна шүү дээ. Тэгэхээр энэ дээр зайлиггүй, Чинзориг сайдыг би энэ дээр бүүр онцгой анхаараасай гэж хэлж байна. Сая түр хороо сонсголын үед ч тэр тодорхой байсан шүү дээ. Энэ салбарын хүмүүс ч гэсэн хэлж байсан. Энэ эмийн өндөр зохицуулалттай орноос ядахдаа энэ 5-ын 2 нь эмийн өндөр зохицуулалттай орны зах зээлд тухайн компани бүтээгдэхүүнээ гаргадаг байх шалгуурыг энд оруулж өгөх хэрэгтэй. Тэгээд энэ дээр би салбарын хүмүүсээс нь хариулт авахыг хүсэж байна. Тэгээд энийг оруулаагүй бол яг тэгж оруулах хэрэгтэй байна.

**П.Анужсин:** 4 номерын микрофонд Оюунцэцэг дарга хариулт өгье.

**П.Оюунцэцэг:** Улсын Их Хурлын гишүүн Оюунчимэг гишүүний асуултад хариулъя. Эрүүл мэндийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Оюунцэцэг. Энэ заалтыг бид нар хуулийнхаа 16.12-т заагаад импортын эм нь 5-аас доошгүй улсад эсхүл эмийн зохицуулалтын үнэлгээгээр ДЭМБ-д хүлээн зөвшөөрөгдсөн эмийн зохицуулалтын эрх бүхий байгууллагатай улсад үйлдвэрлэсэн байна гэдгээрээ бас боломжийг нь нээгээд хоёуланг нь оруулсан байгаа.

**П.Анужсин:** Оюунчимэг гишүүн тодруулж асууя.

**М.Оюунчимэг:** 5-аас доошгүй орны зах зээлд бүртгэгдсэн гэдэг нь энд яг хуучин заалтаар орж ирээд байна. ДЭМБ-ын одоо зөвшөөрөгдсөн гэж байна. ДЭМБ-ын тэр одоогийн энэ орж ирж байгаа ч гэсэн бүгд л зөвшөөрөгдсөн

шүү дээ. Зөвшөөрөгдөөгүй эм манай зах зээлд орж ирэхгүй байгаа шүү дээ. Харин энэ 5 орны зах зээлд бүртгэгдсэн 1 нь эмийн өндөр зохицуулалттай улс оронд бүртгэгдсэн байна гэдэг заалтыг заавал оруулах ёстой хатуу зохицуулалт. Тэгвэл одоо энэ чинь ерөнхий байна шүү дээ. Яг л хуучнаа нэг жоохон ДЭМБ-ын зөвшөөрөгдсөн гэдгээр орж ирж байна. Одоо ч зөвшөөрөгдсөн л орж ирдэг шүү дээ. Зөвшөөрөгдөөгүй нь орж ирдэггүй юм уу. Тэгэхээр тэрийг оруулж ирэх санал би гаргаж байна. Заавал нэг нь тийм байх ёстой. Танай үйлдвэрчний эвлэлийнхэн ч яг тэгж хэлж байсан. Том том эмнэлгийн эмч, мэс заслын эмч нар хүртэл тэгж байгаа байхгүй юу. Энэ ингээж орж ирвэл бидэнд бас итгэл найдвар төрнө энэ компанид гээд. Тэгэхээр ийм заалт оруулах хэрэгтэй байна. Энэ бол сая бүх судалгаагаар бол тодорхой харагдсан шүү дээ.

**П.Анужсин:** Эрүүл мэндийн сайд Чинзориг хариулъя.

**С.Чинзориг:** Тийм Оюунчимэг гишүүний санааг ойлгож байна л даа. Гэхдээ одоо бол манайхан чинь ер нь энэ импортоор орж ирж байгаа эмийн чинь 67 хувь нь байх аа, 67 хувь, бараг л 70 хувь нь тэр хатуу зохицуулалттай гэж нэрлэгдэж байгаа орнуудаас л орж ирж байгаа эм байгаа юм шүү дээ. Манай импортоор борлуулагдаж байгаа эм нь. Тийм байгаа юм аа. Та бол өөр юм яриад байна. Нөгөө талдаа нийт импорт дээр орж ирж байгаа эмийн чинь 67 орчим хувь нь хатуу зохицуулалттай орноос орж ирж байгаа атлаа, гэхдээ нөгөө талдаа импортоор орж ирж байгаа эмийн маань 93 хувь нь ерөнхий мэргэжлийн эм болчихоод байгаа юм. Ийм 2 өөр тоо байгаа юм. Хатуу зохицуулалттай орноос орж ирж байгаа эм ч гэсэн жгенерик буюу нөгөө ерөнхий мэргэжлийн эм чинь орж ирээд байгаа юм Оюунчимэг гишүүн ээ. Тэгэхээр энэ чинь 2 о өөр ойлголт байгаа шүү. 67 хувь нь хатуу зохицуулалттай орноос орж ирж байгаа эм.../минут дуусаа/

**П.Анужин:** Чинзориг сайдын микрофоныг нээж өгье. Асуултад гүйцээж хариулъя.

**С.Чинзориг:** Харин одоо манай энэ хуульд чинь орж байгаа нэг зохицуулалт чинь юу шүү дээ Оюунчимэг гишүүн ээ. Тэр чанартай эм, оригинал эмийг оруулж ирье гэдэг шаардлагыг бол бид нар бол тавьж байгаа. Харин одоо бол бид нар ерөнхий I нэршлийн эмийг шууд бүртгэхээд байгаа юм. Одоо энэ хуулийн зохицуулалтаар гол тэр чанартай холбож байгаа юм чинь тэр ерөнхий нэршлийн эм орж ирж байгаа бол тэр оригинал эмтэйгээ зайлиггүй харьцуулсан судалгаа, дүгнэлтийг нь хамтад нь одоо авч байж бид нар тэр ерөнхий нэршлийн эмийг чинь бүртгэнэ гэдэг ийм зохицуулалт оруулж байгаа шүү дээ. Энэ бас нэлээн тийм чанартай холбож байгаа яг өөрийн чинь яриад байгаа тэр хатуу зохицуулалттай орнуудаас эмээ авдаг байх гэсэн тэр л шаардлага явж байгаа юм. Тэрнээс би бол заавал I орон энд байх ёстой гэх нь нэг их тийм чухал биш л гэж л бол бодож байна.

**П.Анужин:** Оюунчимэг гишүүн тодруулъя.

**М.Оюунчимэг:** Чинзориг сайд аа, би цээжний пангаар яриагүй ээ. Сая сонсголын үеэр шинжээчид, хянан шалгагч нарын хувьд өмнө Дэлхийн банк, дараа нь бас энэ АХБ-ны судалгаануудыг ингээд харахад, бас энэ салбарын хүмүүсийг ярихад таны саяын ярьж байгаа 67 хувь нь хатуу эмийн зохицуулалттай орноос орж ирж байгаа гэдэг шиг худлаа юм байхгүй. Бид зөв юм ярих ёстой. Орж ирж байгаа эмүүдийн чанар, гарал үүсэл тодорхойгүй байна гэдгийг өнөөдөр бүгд л ярьж байна шүү дээ. Яагаад гэвэл хил, гааль дээрээ ч тодорхойгүй байна гээд Слевакийн орж ирж байгаа тэр компаниудыг ч бид 2, 3 компанийг харахад тэгээд СНГ-ийн орнууд дээр гэгчихсэн хэр нь тэр нь өөрөө яг эмийн хатуу зохицуулалттай орноос

гэдэг ямар ч баталгаа зохицуулалт байхгүй байна лээ шүү дээ. Тэгэхээр энийг зайлиггүй оруулж өгөх хэрэгтэй. Тэгвэл манай эмийн чанарын асуудлыг бид яриад байна шүү дээ. Бид үнэ яриагүй. Чанар ярьж байна. Хүний амаар ордог хоёрхон зүйл хүнс, эм. Эмийн чанар дээр энийг хатуу тусгаж өгөх хэрэгтэй. Эм, эмнэлгийн хэрэгслийн хууль гаргаж л байгаа бол яг тэрийг нь зааж өг. Яг энэ эмийн хатуу зохицуулалттай орноос.../минут дуусав/

**П.Анужин:** Санал хэлж, асуултад хариуллаа. Оюунчимэг гишүүний гаргаад байгаа санал нь төслийн 16 дугаар зүйл дээр бид нар хэлэлцээд өнгөрчихсөн байгаа юм. 16 дугаар зүйл дээр түрүүн хэлэлцээд өнгөрсөн. Хэрвээ энэ 16 дугаар зүйлийг хөндөнө гэж үзвэл бид нар энэ 16 дугаар зүйл дээр эргэж санал хураалгах асуудал гарч байгаа. Манай хуулийн ажлын хэсгийнхэн энэ дээр нэг зохицуулалт бодоодхооч. Энийг зохицуулалт хийж байх хооронд хурлын төгсгөлд хэлэлцье гэсэн санал гаргаж ирж байна. Би тэр саналыг бас дэмжиж байна.

20 дугаар зүйл рүүгээ оръё. 20 дугаар зүй зүйл дээр ажлын хэсгээс нэг санал, мөн Чинбүрэн гишүүний I санал зарчмын зөрүүтэй гарсан байгаа. Тус тусад нь санал хураалгана. 2 санал бол хоорондоо зөрчилдөх, давхцах зүйл байхгүй учраас тус тусад нь хураалгах нь зүйтэй гэж үзсэн.

Төслийн 20 дугаар зүйлийн 20.6 дахь хэсгийн “зах зээлд гаргах зөвшөөрлийг” гэснийг “бүртгэлийг” гэж, 20.12 дахь хэсгийн “зөвшөөрөл” гэснийг “бүртгэл” гэж тус тус өөрчилж, мөн зүйлийн 20.9 дэх хэсгийн “вакцин,” гэсний дараа “биобэлдмэл” гэж, 20.12 дахь хэсгийн “тандалт” гэсний дараа “судалгаа” гэж тус тус нэмж, 20.11 дэх хэсгийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 77,8 хувиар санал дэмжигдлээ.



Мөн зарчмын зөрүүтэй санал. Ажлын хэсгийн гишүүн Жигжидсүрэнгийн Чинбүрэнгээс ирсэн байгаа. Чинбүрэн гишүүн уг зарчмын зөрүүтэй саналаа тайлбарлана. Чинбүрэн гишүүн тайлбар өгье.

**Ж.Чинбүрэн:** Баярлалаа. Энэ шинэчилсэн найруулгын хуульд бас эмийн чанарын асуудал тэр дотроо зах зээл дээр байгаа худалдаанд гарчихсан, бүртгэгдсэн эмүүдийг санамсаргүй түүвэрлэлтийн аргаар авч шалгаж, тэгээд сери дугаараараа үйлдвэрлэснээрээ хэр зэрэг чанартай байна гэдгийг шалгах гэж байгаа юм. Энэ заалт орсон бол их сайн байна. Бид бас түр хорооноосоо тогтоол гарахдаа энийгээ хийгээрэй гэсэн даалгавар өгсөн. Тэгэхдээ энэ дээр нөгөө санхүүжилтийг хэн гарах вэ гэдэг асуудал яригдаж байгаа юм. Энэ 20.3 дээр. Тэгэхээр энэ дээр нөгөө чанарыг нь шалгах гэж байгаа оруулж ирсэн компаниудаас та нар мөнгөө өгөөдөх, би одоо чиний наад эмийг чинь зах зээл дээр хэр чанартай байна гэдгийг нь шалгая гээд явах нь өөрөө утгагүй. Энэ санамсаргүй түүвэрлэлтээр зах зээл дээр байгаа эмийг хянан шалгах гэж байгаа үйл ажиллагааг аль болохоор санхүүгийн хувьд хэн нэгнээс хамаарахгүйгээр төрөөс, төсвөөс дааж хийх нь өөрөө чухал юм. Тийм учраас би зарчмын зөрүүтэй санал оруулахдаа санхүүжилт нь Эрүүл мэндийн тухай хуулийн 15.1.7, 1.11, 15.1.13-д заасан байгууллагатай хамтран зохион байгуулна. Тандалт судалгааны зардлыг үйлдвэрлэгч энэ тэр гэдгийг бүгдийг нь аваад зардлыг ерөөсөө л улсын төсвөөр санхүүжүүлж хийнэ л гэдэг ийм заалтыг оруулж байгаа юм. Энэ их чухал шүү. Яагаад гэхээр эмээ оруулж ирсэн компаниас ч мөнгө өгөөч. Би танай эмийн чинь чанарыг шалгая гэдэг нь ямар ч логик байхгүй байна шүү дээ.

**П.Анужин:** Чинбүрэн гишүүн оруулж ирж байгаа зарчмын зөрүүтэй саналаа тайлбарлалаа. Уг санал дээр

эрүүл мэндийн сайд Содномын Чинзориг хариулт өгье. Эрүүл мэндийн яамны байр суурь ямар байгаа юм энэ дээр.

**С.Чинзориг:** Би Чинбүрэн гишүүний гаргаж байгаа саналыг бол дэмжиж байгаа юм. Энэ зарчмаар нь авчихъя. Тэгээд тэр хяналтынхаа зардлыг төсвөөс гаргаад хийдэг байх нь зүйтэй. Одоо бол манай нөгөө тэр үйлдвэрлэгчээр нь өөрсдөөр нь зардал гаргадаг. Тийм учраас зардал гаргуулна гэж байгаа юм. Тийм учраас энэ Чинбүрэн гишүүний саналаар аваад явчихъя. Энэ саналыг дэмжээд авчихъя гэсэн саналтай байгаа юм.

**П.Анужин:** Чинбүрэн гишүүний хэлж байгаа саналыг яам бас дэмжсэн байр сууриа илэрхийлж байна. Тийм учраас ажлын хэсгийн гишүүн, эмийн түр хорооны дарга Чинбүрэн гишүүний оруулж ирсэн саналын томъёоллын танилцуулъя. Энэ бас чухал өөрчлөлт байсан юм шүү. Та нар анхааралтай сонссон байх. Унишж танилцуулъя.

Төслийн 20.3 дахь хэсгийг Эм, эмнэлгийн хэрэгслийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, эмийн эмчилгээний идэвх тодорхойлох судалгааг Эрүүл мэндийн тухай хуулийн 15.1.7, 15.1.11, 15.1.13-д заасан байгууллагатай хамтран зохион байгуулна. Тандалт судалгааны зардлыг улсын төсвөөс гаргах бөгөөд гэж өөрчлөн нэмэх. Эрүүл мэндийн яам зарчмын зөрүүтэй саналыг нь харсан уу. Санал хураалт. 77,8 хувиар уг санал дэмжигдлээ.

Төслийн 21 дүгээр зүйлтэй холбоотой асуулт асуух гишүүн байна уу. Байхгүй бол ажлын хэсгээс зарчмын зөрүүтэй 1 санал ирсэн.

Төслийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсгийн “дархлаажуулалтын дараах” гэснийг хасаж, 21.3 дахь хэсгийн “Энэ хуулийн 30.1-д заасан” гэснийг “Эрүүл мэндийн байгууллага, эмнэлгийн

мэргэжилтэн,” гэж, 21.4 дэх хэсгийн “нөлөөг нягтлан дүгнэлт гаргаж, эмийн гаж нөлөөний талаар” гэснийг “нөлөөний үнэлгээг холбогдох зөвлөлийн шийдвэрээр баталгаажуулан,” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 66,7 хувиар дэмжигдлээ.

Төслийн 22 дугаар зүйлтэй холбогдуулж асуулт асуух гишүүд байна уу. Байхгүй ажлын хэсгээс 22 дугаар зүйлтэй холбоотой зарчмын зөрүүтэй санал ирсэн. Унишиж танилцуулъя.

Төслийн 22 дугаар зүйлийн гарчгийн, 22.2, 22.8 дахь хэсгийн “Шинэ” гэснийг “Анхдагч” гэж, мөн зүйлийн 22.4.5 дахь заалтын “биошингэц” гэснийг “биохүрэхүй” гэж, 22.6 дахь хэсгийн “биошингэцийг” гэснийг “биохүрэхүйг” гэж, 22.7.4 дэх заалтын “үйлчлэлийг” гэснийг “үйлдлийн” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 55,6 хувиар санал дэмжигдлээ.

Төслийн 23 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу. Мөн ажлын хэсгээс зарчмын зөрүүтэй санал ирээгүй.

24 дүгээр зүйлтэй холбоотой үг хэлэх, санал хэлэх гишүүн байна уу. Байхгүй бол мөн ажлын хэсгээс зарчмын зөрүүтэй санал ирээгүй.

25 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу. Ажлын хэсгээс зарчмын зөрүүтэй 1 санал бэлтгэж ирүүлсэн унишиж танилцуулъя.

Төслийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсгийн “зах зээлд гаргах зөвшөөрөлд” гэснийг “бүртгэлд” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 77,8 хувиар уг санал дэмжигдлээ.

Төслийн 26 дугаар зүйлтэй холбогдуулж асуулт асуух гишүүн байна

уу. Байхгүй ажлын хэсгээс 1 зарчмын зөрүүтэй санал бэлдэж ирсэн бэлдэж оруулж ирж байна. Зарчмын зөрүүтэй саналыг танилцуулъя.

Төслийн 26 дугаар зүйлийн 26.3 дахь хэсгийн “хэвлэлээр” гэснийг “хэвлэл, албаны ёсны цахим хуудсаар” гэж өөрчилж, 26.5.5 дахь заалтын “чухал, цорын ганц, маш өндөр идэвхтэй,” гэснийг, мөн заалтын “хамгийн сайн,” гэснийг тус тус хасаж, 26.5.10 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“26.5.10.эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүнийг өвчнийг оношлох, эмчлэх үйлдэлтэй гэж олон нийтийг төөрөгдөлд оруулсан байдлаар сурталчлах;” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал 77,8 хувиар дэмжигдлээ.

Төслийн 27 дугаар зүйлтэй холбоотой асуулт асууж, үг хэлэх гишүүн байна уу. Байхгүй бол ажлын хэсгийн бүрэлдэхүүнээс зарчмын зөрүүтэй 1 санал оруулж ирсэн. Саналыг танилцуулъя.

Төслийн 27 дугаар зүйлийн 27.4.1 дэх заалтын “зах зээлд гаргах зөвшөөрөлгүй” гэснийг “бүртгэлгүй” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал 66,7 хувиар дэмжигдлээ.

Төслийн 28 дугаар зүйлтэй холбоотой асуулт асууж, үг хэлэх гишүүн байна уу. Байхгүй бол ажлын хэсгээс зарчмын зөрүүтэй санал ирээгүй.

Төслийн 29 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу. Ажлын хэсгээс зарчмын зөрүүтэй 1 саналыг ирүүлсэн байна. Ажлын хэсгийн хэсгээс ирүүлсэн зарчмын зөрүүтэй саналыг унишиж танилцуулъя.

Төслийн 29 дүгээр зүйлийн 29.4.4 дэх заалтыг хасаж, мөн зүйлд доор

дурдсан агуулгатай 29.4.6 дахь заалт нэмэх:

“29.4.6.эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид бага насны хүүхдийн эмийг олгоходоо онцгойлон анхаарч эмийн зохистой хэрэглээний талаарх мэдээлэл өгөх.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт гишүүд ээ. Санал хураалтыг түр хойшлуулъя.

Ажлын хэсэг дээр бол энэ ийм томъёоллоор оруулж ирээгүй. Энэ ажлын хэсэг оруулж ирэхдээ алдаж оруулж ирсэн байх. Ийм томъёоллоор дэмжигдээгүй шүү дээ. Сайн ярьсан шүү дээ. Энийгээ энэ манай техникийнхэн. Санал хураалт явуулъя гишүүд ээ. Санал хураалт. 66,7 хувиар санал дэмжигдлээ.

Төслийн 33 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу. Байхгүй бол ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй 1 саналыг уншиж танилцуулъя.

Төслийн 33 дугаар зүйлийн гарчгийн “хэрэгсэл зах зээлд гаргах зөвшөөрөл” гэснийг “хэрэгслийн бүртгэл” гэж, 33.1 дэх хэсгийн “зах зээлд гаргах зөвшөөрөлтэй” гэснийг “бүртгэлтэй” гэж, 33.2 дахь хэсгийн “зах зээлд гаргах зөвшөөрлийг” гэснийг “бүртгэлийг энэ хуулийн 15.3.1, 15.3.7 дахь заалт болон үйлдвэрлэгч улсдаа зах зээлд гаргасныг харгалзан үзэж,” гэж, 33.6 дахь хэсгийн “лабораторийн” гэснийг “лаборатори, эсхүл төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төвийн үндэсний итгэмжлэгдсэн лавлагаа лабораторийн” гэж, 33.7 дахь хэсгийн “зах зээлд гаргах зөвшөөрлийн” гэснийг “улсын бүртгэлийн” гэж, 33.9 дэх хэсгийн “зах зээлд гаргах зөвшөөрөл” гэснийг “бүртгэл” гэж, 33.9.4 дэх заалтын “маш бага” гэснийг “Эрүүл мэндийн тухай хуулийн 15.1.12, 15.1.13-д заасан байгууллагад хэрэглэгдэх” гэж, 33.9.6 дахь заалтын “зах зээлд гаргах зөвшөөрөл авахад шаардагдах

бүтээгдэхүүний” гэснийг “бүртгэлийн” гэж, 33.9.9 дэх заалтын “хэрэглэгдэхүүн, лабораторийн оношилгооны хэрэгсэл, эмнэлгийн тоног төхөөрөмж” гэснийг “хэрэгсэл” гэж тус тус өөрчилж, 33.4 дэх хэсгийг, 33.9.5 дахь заалтын “эмнэлзүйн” гэснийг тус тус хасаж, 33.5 дахь хэсгийн “байгууллага” гэсний дараа “өндөр, дунд эрсдэлтэй” гэж, 33.9.4 дэх заалтын “оношилгооны” гэсний дараа “өвөрмөц” гэж тус тус нэмж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 33.9 дэх хэсэг нэмэх:

“33.9.Өндөр, дунд эрсдэлтэй эмнэлгийн тоног төхөөрөмж, эмнэлгийн хэрэглэгдэхүүнийг үйлдвэрлэсэн улс, үйлдвэрлэгч, загвар, эсхүл бүтээгдэхүүний дугаар тус бүрээр нь жагсаалтад оруулна.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 77,8 хувиар санал дэмжигдлээ.

Төслийн 34 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу. Байхгүй бол ажлын хэсгээс зарчмын зөрүүтэй санал мөн ирээгүй байгаа.

Төслийн 35 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу. Байхгүй бол ажлын хэсгээс зарчмын зөрүүтэй 1 санал хүргүүлсэн. Зарчмын зөрүүтэй саналыг танилцуулъя.

Төслийн 35 дугаар зүйлийн 35.4 дэх хэсгийн “сөрөг нөлөө,” гэсний дараа “аюулгүй байдал,” гэж нэмж, 35.5 дахь хэсгийн “зах зээлд гаргах зөвшөөрлийг” гэснийг “бүртгэлийг” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 77,8 хувиар дэмжигдлээ.

Төслийн 36 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу. Байхгүй бол ажлын хэсгээс зарчмын зөрүүтэй 1 саналыг ирүүлсэн. Уншиж танилцуулъя.

Төслийн 36 дугаар зүйлийн 36.2 дахь хэсгийн “байгууллага” гэсний дараа “, эсхүл Эрүүл мэндийн тухай хуулийн

15.1.12, 15.1.13-д заасан байгууллага” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 77,8 хувиар уг санал дэмжигдлээ.

Төслийн 37 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу. Ажлын хэсгийн хэсгээс зарчмын зөрүүтэй санал ирээгүй.

Төслийн 38 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу. Байхгүй бол ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй 1 саналаар санал хураалт явуулна. Унишиж танилцуулъя.

Төслийн 38 дугаар зүйлийн 38.2.4 дэх заалтын “серийн” гэснийг “цуврал, эсхүл бүтээгдэхүүний” гэж, 38.4 дэх хэсгийн “сав, баглаа боодол дээрх” гэснийг “гадна талд байрлах” гэж, 38.5.3 дахь заалтын “техникийн үзүүлэлт” гэснийг “загварын нэр” гэж, 38.8 дахь хэсгийн “зах зээлд гаргах зөвшөөрөлд” гэснийг “бүртгэлд” гэж тус тус өөрчилж, мөн зүйлийн 38.4.5 дахь заалтын “, сар, өдөр” гэснийг, 38.5.4, 38.5.7, 38.5.8, 38.5.9, 38.5.10 дахь заалтыг тус тус хасаж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 38.6 дахь хэсэг нэмэх:

“38.6.Эмнэлгийн тоног төхөөрөмжийн хэрэглэгчийн гарын авлага монгол, эсхүл англи хэлээр байх бөгөөд дараах мэдээллийг агуулна:

- 38.5.1.бүтээгдэхүүний нэр;
- 38.5.2.үйлдвэрлэгчийн нэр;
- 38.5.3.загварын нэр;
- 38.5.4.техникийн үзүүлэлт;
- 38.5.5.ашиглалтын заавар;
- 38.5.6.хадгалах болон тээвэрлэх нөхцөл;
- 38.5.7.ашиглалтын нөхцөл;
- 38.5.8.аюулгүй ажиллагаа;
- 38.5.9.суурилуулалт хийх зааварчилгаа;
- 38.5.10.завсар үйлчилгээ хийх зааварчилгаа;

38.5.11.холбоо барих үйлдвэр, ханган нийлүүлэх байгууллага;  
38.5.12.ариутгал, халдваргүйжүүлэлтийн нөхцөл;”

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 77,8 хувиар уг санал дэмжигдлээ.

Төслийн 39 дүгээр зүйлтэй холбоотой асуулт асуух гишүүд байна уу. Байхгүй байна. Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй 1 саналаар санал хураалт явуулна.

Төслийн 39 дүгээр зүйлийн 39.2 дахь хэсгийн “хэвлэлээр” гэснийг “хэвлэл, албан ёсны цахим хуудсаар” гэж, 39.5.4 дэх заалтын “чухал, цорын ганц, маш өндөр үйлчилгээтэй,” мөн заалтын “хамгийн” гэснийг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 77,8 хувиар санал дэмжигдлээ.

Төслийн 40 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу. Байхгүй бол ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй 1 саналаар санал хураалт явуулна. Танилцуулъя.

Төслийн 40 дүгээр зүйлийн 40.1 дэх хэсгийн “бусад байгууллага” гэсний дараа “үндсэн, эсхүл гэрээт” гэж, 40.1.4 дэх заалтын “төхөөрөмжийн” гэсний дараа “хэрэглэгчийн гарын авлагад үндэслэн” гэж тус тус нэмж, 40.7 дахь хэсгийн “хэсгээс”-гэснийг “хэсэгт заасан баталгаат хугацаанаас” гэж өөрчилж, 40.1.4 дэх заалтын “эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер” гэснийг, 40.2 дахь хэсгийн “болон лабораторийн” гэснийг тус тус хасах. Санал гаргасан. Ажлын хэсэг санал хураалт. 77,8 хувиар санал дэмжигдлээ.

Төслийн 41 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу. Байхгүй байна. 41 дүгээр зүйлтэй холбоотой Булгантуяа сайд асуулт асууна.

**Х.Булгантуяа:** 41.1 дэх хэсгийн холбогдох баримт бичиг түүнд хийсэн шинжээчдийн дүгнэлт гэдгийг хасах саналтай байна. Энэ нөгөө Зөвшөөрлийн тухай хуультай, зөвшөөрөлтэй дүйцэхүйц бичиг баримт болохоор, шаардлага болохоор хуульд орж ирсэн байна. Тэгээд тийм учраас үүнийг нь хасах саналтай байна.

**П.Анужин:** 41 дүгээр зүйлтэй холбоотой ажлын хэсгээс 1 санал ирсэн байгаа. Мөн Хассуурийн Ганхуяг гишүүн, сая Булгантуяа танилцуулсан сайдын танилцуулсан зарчмын зөрүүтэй 1 санал ирсэн байгаа. Санал хураалт явуулна.

Эхлээд ажлын хэсгээс ирсэн зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулъя.

Төслийн 41 дүгээр зүйлийн 41.1 дэх хэсгийн “, бүртгэлд өөрчлөлт оруулах, хугацааг сунгах, түдгэлзүүлэх, бүртгэлээс хасах” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 77,8 хувиар уг санал дэмжигдлээ.

Одоо 41 дүгээр зүйлтэй холбоотой Хассуурийн Ганхуяг гишүүнээс зарчмын зөрүүтэй санал ирүүлсэн байна. Зарчмын зөрүүтэй саналыг уншиж танилцуулъя.

Төслийн 41.1 дэх хэсгийн “Эм эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн төслийн 41 дүгээр зүйлийн 41.1 дэх хэсгийн холбогдох баримт бичиг түүнд хийсэн шинжээчийн дүгнэлт” гэснийг хасах. Санал гаргасан Хассуурийн Ганхуяг гишүүн. Санал хураалт. Санал хураалтыг цуцалъя. Хассуурийн Ганхуяг гишүүний оруулсан энэ нөгөө Зөвшөөрлийн хуультай нийцүүлж оруулж ирж байгаа зарчмын зөрүүтэй санал гэж ойлгож байгаа. Энэ зарчмын зөрүүтэй саналтай холбогдуулж хууль санаачлагчийн зүгээс тайлбар хийнэ. 4 номерын микрофонд Оюунцэцэг дарга хариулъя.

**П.Оюунцэцэг:** Булгантуяа гишүүний асуултад хариулъя. 41.1 дээр бид нар энэ шинжээчийн дүгнэлтийг оруулахдаа холбогдох баримт бичиг ер нь энэ баримт бичгийн бүрдэл дээр нь ер нь шинжээчийн дүгнэлтээ авах шаардлагатай гэж үзсэн. Тухайн эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүн дээр байгаа орц найрлага ялангуяа тэр дээр хүнд металлын давсын орц найрлагууд, сэтгэц нөлөөт бодис, мансууруулах бодис эд нарын байгаа орц найрлагыг бас шинжээчийн дүгнэлтээр бас мэргэжлийн хүмүүсийн дүгнэлтийг авч байж бас бүртгэлдээ харгалзаж үзнэ гэсэн байдлаар оруулсан байгаа. Авчихаар харин.../минут дуусае/

**П.Анужин:** Хассуурийн Ганхуяг гишүүний мөн Булгантуяа гишүүний танилцуулсан зарчмын зөрүүтэй санал дээр санал хураалт явуулъя гишүүд ээ. Асуулт асууж, хариулт авч дууссан. Санал хураалт. Оруулж ирсэн зарчмын санал 44,4 хувиар дэмжигдсэнгүй ээ.

42 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу. Байхгүй ажлын хэсгээс санал гараагүй.

Төслийн 43 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу. Асуулт асуух гишүүн байхгүй байна. Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулна.т

Төслийн 43 дугаар зүйлийн 43.3.1 дэх заалтын “зах зээлд гаргах зөвшөөрөлгүй эм,” гэснийг “бүртгэлгүй эм, өндөр, дунд эрсдэлтэй” гэж өөрчилж, мөн зүйлийн 43.3.5 дахь заалтын “зах зээлд гаргах зөвшөөрөл,” гэснийг хасаж, 43.8 дахь хэсгийн “байгууллагын” гэсний дараа “эмийн асуудал хариуцсан улсын байцаагч” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал 66,7 хувиар дэмжигдлээ.

Төслийн 44 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна

уу. Байхгүй бол ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй 1 саналаар санал хураалт явуулна.

Төслийн 44 дүгээр зүйлийн 44.1.1, 44.1.2, 44.1.3 дахь заалтын “зах зээлд гаргах зөвшөөрөлтэй” гэснийг “бүртгэлтэй” гэж, 44.4.2 дахь заалтын “зах зээлд гаргах зөвшөөрлийн гэрчилгээ” гэснийг “бүртгэлийн дугаар” гэж тус тус өөрчилж, мөн зүйлийн 44.7 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“44.7.Дараах нөхцөл байдал үүссэн тохиолдолд бүртгэлгүй эм, эмнэлгийн хэрэгслийг импортлоход Эмийн зөвлөл, Эмнэлгийн хэрэгслийн зөвлөлийн шийдвэрийг үндэслэн эм, эмнэлгийн хэрэгслийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага импортын мэдүүлэг олгоно:

44.7.1.гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал үүссэн;

44.7.2.эм, эмнэлгийн хэрэгслийн тасалдал үүсэж орлуулан хэрэглэх эм, эмнэлгийн хэрэгсэл байхгүйгээс эмнэлгийн тусламж, үйлчилгээнд доголдол үүссэн.”

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 77,8 хувиар санал дэмжигдлээ.

Төслийн 45 дугаар зүйлтэй холбогдуулж асуулт асуух гишүүн байна уу. Байхгүй бол ажлын хэсгээс зарчмын зөрүүтэй санал ирээгүй байна.

Төслийн 46 дугаар зүйлтэй холбоотой асуулт асуух гишүүн байна уу. Ажлын хэсгийн 46 дээр явж байна. Ажлын хэсгийн хэсгээс зарчмын зөрүүтэй 1 санал ирүүлсэн. Санал хураалт явуулна. Унишиж танилцуулъя.

Төслийн 46 дугаар зүйлийн 46.2, 46.2.3, 46.9, 46.10 дахь хэсгийн “тусламж, төсөл, хөтөлбөрөөр” гэснийг “тусламжаар” гэж, 46.10.1 дэх заалтын

“шаардлага” гэснийг “стандарт” гэж, 46.10.6 дахь заалтын “эм, эмнэлгийн хэрэглэгдэхүүнийг” гэснийг “эмийг” гэж, 46.14.2 дахь заалтын “зах зээлд гаргах зөвшөөрөлгүй” гэснийг “бүртгэлгүй” гэж тус тус өөрчилж, 46.11 дэх хэсгийн “Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага” гэснийг хасаж, мөн хэсгийн “40.10.6” гэсний дараа “46.10.7” гэж нэмж, 46.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“46.1.Гадаад улсын Засгийн газар, олон улсын байгууллагаас хүн амын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд зориулан эм, эмнэлгийн хэрэгслийг хандив, тусламж хүлээн авахдаа эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад, төрийн болон төрийн бус байгууллага, иргэн, гадаад, дотоодын хуулийн этгээдээс хандив, тусламж хүлээн авахдаа эм, эмнэлгийн хэрэгслийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад урьдчилан мэдэгдэж, зөвшөөрөл авна.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 77,8 хувиар санал дэмжигдлээ.

Төслийн 47 дугаар зүйлтэй холбоотой асуулт асуух гишүүн байна уу. Байна. Даваажанцангийн Сарангэрэл гишүүн асуулт асууна. Зарчмын зөрүүтэй 1 санал.

**Д.Сарангэрэл:** Хэдүүлээ энэ 47 дугаар зүйл дээр нэлээн анхааралтай баймаар байгаа юм. Ер нь бол зүгээр хувь хүний байр суурийн хувьд бол бид нар чинь зах зээлийн эдийн засагт шилжээд эм ханган нийлүүлэх энэ үйл ажиллагаагаа бүхэлд нь хувийн хэвшилдээ шилжүүлчихсэн. Одоо ингээд 30 гаруй жил энэ хувийн салбарынхан маань шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслийг бүрдүүлэх чиглэлд бол ажиллаад амжилттай ажиллаж байгаа гэж бодож байгаа. Тэр үед бол ер нь эмийн хангамжийн хүртээмжийн тухай асуудал яригддаг байсан бол хувийн хэвшилд шилжсэнээр бол эмийн

хангамж, хүртээмжийн асуудал яригдахаа болиод, одоо чанар аюулгүй байдал, үнийн асуудал яригдаж байгаа л даа. Тэгээд одоогийн 47.1 дүгээр заалтыг ингээд харахаар зэрэг ерөнхийдөө бол эм худалдан авах үйл ажиллагаанд төр бүхэлдээ оролцох, хувийн хэвшилтэй өрсөлдөх ийм заалтууд бол орсон байна. Би энийг ухралт гэж үзэж байгаа. Төрийн функц бол юу вэ гэвэл аль болох зах зээлийн эрүүл өрсөлдөөнийг дэмждэг, иргэддээ бол чанартай эмийг өргөн сонголттойгоор авч хэрэглэх боломжийг нь олгодог, чанар, аюулгүй байдлын хувьд бол ингээд бас хяналтаа тавьдаг, бодлогоо тодорхойлоод явдаг ийм л байх ёстой. Үүнээс биш хувийн хэвшилтэйгээ зэрэгцээд эм худалдан авах, ханган нийлүүлэх ийм үйл ажиллагаанд би бол оролцож болохгүй ээ гэж ингэж бодож байгаа. Үүнийг бол би ухралт гэж үзнэ.

Тийм учраас бол тодорхой санал хэлэх гээд байна. 47.1.1 дээр бол төрийн болон орон нутгийн өмчит эрүүл мэндийн байгууллагын иргэнд үзүүлэх тусламж үйлчилгээнд шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл гэдгийг бол хасна. Харин вакцины хувьд бол ерөөсөө төрийн хяналттай яваад ирсэн байгаа. Тэр нь бол үлдэх ёстой.

47.1.2 бол би үлдэх ёстой гэж бодож байгаа юм. Чинбүрэн гишүүн бас ийм саналтай байгаа юм билээ. Төрөөс төлбөрийг нь хариуцах удаан хугацааны нөхөх эмчилгээ шаардах эмгэгийн болон хөнгөвчлөх эмчилгээний эм. Дээр нь өнчин эмийн тухайд бол бас мөн төрийн оролцоо байх нь зүйтэй гэж ингэж бодож байгаа.

47.1.3-д бол иргэдэд Эрүүл мэндийн даатгалын сангаас хөнгөлөлттэй үнээр олгодог бүх эмийг төр хариуцахаар болчихсон байгаа байхгүй юу. Энэ чинь гол эмүүд чинь энд байж байгаа.

47.1.4-д бол Өрхийн эрүүл мэндийн төвийн өдөр тутмын эмчилгээнд хэрэглэх эм, эмнэлгийн хэрэгслийг мөн

төр хариуцна гээд. Тэгээд энэ бол ухралт. Тийм учраас би 47.1.3 47.1.4, 47.1.1-ийг бол 2 заалтыг нь хасаад, 47.1.1-ээс бол тэр эм, эмнэлгийн хэрэгсэл гэдгийг хасаад ингээд бол 47 дугаар зүйл дээр бол томоохон өөрчлөлт хийхгүй бол төр, хувийн хэвшил зэрэгцэн орших, хувийн хэвшилтэйгээ төр энэ эмтэй холбоотой асуудлыг худалдан авалт дээр давхцаад явах ийм нөхцөл байдал үүсээд, одоо тогтчихсон байгаа энэ тогтолцоондоо бол гажуудал үүсгэх ийм эрсдэл бий болох нөхцөл бүрдэж болзошгүй байгаа учраас эдгээр зүйлийг хасах нь зүйтэй гэсэн ийм саналтай байна.

**П.Анужсин:** Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн. Санал хэлэх гишүүдийн дугаарт Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн, Жигжсүрэнгийн Чинбүрэн гишүүн, Чинзориг сайд нарыг нэмье. Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн. Уучлаарай, дараалал зөрчиж уншсан байна. Жигжсүрэнгийн Чинбүрэн гишүүн үг хэлнэ.

**Ж.Чинбүрэн:** Би бас Сарангэрэл гишүүний хэлж байгаа зүйлтэй бас санал нэг. 47 дээр хэдүүлээ бүгдээрээ их анхааръя. Энэ гоомой байж болохгүй, хамгийн чухал зүйл заалтууд. Ялангуяа бид төрөөс эмийн хангамжийг яаж хийх вэ гэдгийн одоо гол сэдэв энд явж байгаа юм. Тэгэхээр бас түр хороо нэлээдгүй хугацаанд ажиллаад бид бол нэг зүйлийг хэлсэн. Бид бол ер нь хувийн хэвшлийг түлхэх, шахах биш, харин эсрэгээр тэдгээрийн оруулж ирж байгаа эмийн чанарт хяналт тавина. Үнийн зохицуулалтыг хийнэ гэж оруулсан юм. Тэр ч утгаараа бид энэ тогтоол дотроо бол одоо энэ санаагаа оруулж өгсөн. 47.1.1-ээс 47.1.4 хүртэлх энэ зүйлийг харах юм бол ер нь нийт одоо Монгол Улсын зах зээл дээр байгаа эмийнхээ борлуулалтын бараг 50-аас их хувийг буцаагаад төр өөртөө татаж авах ийм эрсдэл бий болох гээд байгаа юм.

Тийм учраас миний хэлэх гэж байгаа санаа бол бид илүү хувийн

хэвшилээрээ хийлгэнэ. Харин хяналтаа чанараа шалгаж байя. Мэдээж төрөөс төлбөрийг нь дааж байгаа тусламж үйлчилгээгээ бол төр өөрөө мэдэх нь зүйтэй. Тэгээд саяхан Засгийн газрын тогтоол байгаа. Засгийн газрын тогтоол Чинзориг сайд батлуулсан тогтоол. Энд бол нэг эх үүсвэрээс олон улсын чанарын шаардлага хангасан хүний эм, эмнэлгийн хэрэгсэл, биобэлдмэл, вакциныг гадаад улсын үйлдвэрлэгчээс эсхүл Олон Улсын байгууллагаас шууд болон дамжуулан худалдаж авах журам саяхан батлагдсан энэ журам. Энэ журам дээр ерөөсөө 2 чухал заалт байгаа юм. Би бүр зориуд энийг унигья гэж бодож байна.

2.2.1-д эрүүл мэндийн байгууллагуудын тусламж үйлчилгээнд түгээмэл хэрэглэгддэг гэж байгаа юм. Түгээмэл хэрэглэгдэх эсхүл эмийн зардалд өндөр хувь эзэлж байгаа эм, эмнэлгийн хэрэгслийг нэг эх үүсвэрээр худалдаж авъя гэж байгаа юм. Нэг ёсондоо төр худалдаж авах нь байна шүү дээ.

2.2.2-т тусламж үйлчилгээ нь нэн шаардлагатай тасалдал үүсэх өндөр эрсдэлтэй эм, эмнэлгийн хэрэгсэл гээд. Тэгээд би зарчмын зөрүүтэй санал дээрээ 3 дахь нь нэмээд сая төрөөс төлбөрийг нь хариуцах удаан хугацааны нөхөх эмчилгээ шаардлагатай эмгэгийн болон хөнгөвчлөх эмчилгээний эм гээд ийм 3 заалт оруулах зарчмын зөрүүтэй санал дэвшүүлсэн. Тэгээд энэ дээр бас нэг зүйлийг та бүхэнд зориуд хэлье.

Би бол Чинзориг сайд энэ дээр их чухал зүйл оруулж байгааг би ойлгож байгаа. Жишээлэх юм бол өрхийн эрүүл мэндийн төвийн өдрийн эмчилгээнд хэрэглэгдэх эм, эмнэлгийн жижиг хэрэгсэл гэж байгаа юм. Уг нь бол ерөөсөө бид анхан шатны тусламж үйлчилгээ дээр иргэд асар их шинж тэмдгээ дарангуйлах эмчилгээндээ санхүүгийн дарамтад ороод байна гэдгийг түр хороо бол тодруулсан. Тухайлах юм бол ханиад томууны эмүүд хамгийн их авдаг. Ялангуяа энэ сезоны

ханиадны томууны сезоны үед бол хамгийн их санхүүгийн дарамт үзүүлж байгаа зүйл нь энэ юм байна лээ. Тэгэхээр энэ дээр бол бид төрөөс худалдаж авахын оронд нөгөө хөнгөлөлттэй эмийнхээ юундаа оруулаад заалтдаа оруулчих х юм бол тэр хөнгөлөлтүүдийг нь ард иргэддээ өгөөд, нөгөө ханиад томууны эмийг заавал хүндрүүлэхгүйгээр шинж тэмдгийг нь дараад, хөнгөлөөд яваад байх боломж байгаа. Тэрийг яаж хийх вэ гэхээр нөгөө хөнгөлөлттэй эмд хэнийг оруулах вэ гэдэг. Тэр дээр чинь бол зөвхөн зайлигүй шаардлагатай эм гээд байгаа шүү дээ. Тэгвэл тэр заалт дээрээ бид өөрчлөлт оруулчихад л энэ ингээд ороод явчих юм. Засагдаад явчих юм. Тийм учраас миний зарчмын зөрүүтэй санал бол 3 зүйлийг оруулж байна. Тэгээд энийг дэмжиж өгөхийг хүсэж байна.

**П.Анужин:** Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн үг хэлнэ. Санал хэлнэ.

**М.Оюунчимэг:** Манай эрүүл мэндийн салбарынхан бол хамгийн чухал салбар. Улс орны хувьд хүний эрүүл мэндийг сахин хамгаалж байгаа гэдэг утгаараа. Тэгээд эмч ажилтнууд маань яаж ажилладаг билээ. Тэгээд бас тэдний маань цалин хөлс ч хүртэл энэ өнөөдөр ажилласнаараа хангалттай биш байгаа шүү дээ. Тэгэхээр бид нар энд санхүүжилтээр дамжсан шинэчлэл хийж байгаа. Энэ үед бодлого барьж байгаа Эрүүл мэндийн яам маань өөрөө саяын сонсголоос ч харахад компанийн ашиг нэг сонирхлын төвлөрөл болчихоод байна гээд та бүхний энд бараг удирдлагууд сууж байна. Та бүхэн рүү нийгэм хардлагаар хараад байна шүү дээ. Сая тэгээд зарим нь бас хамаарал гээд л гараад ирээд байна. Тийм байгаа энэ үед та нар дахиад эмийн худалдан авах үйл ажиллагааг Эрүүл мэндийн яам удирдаж байгаа, бодлого барьж байгаа яам нь өөрөө зохион байгуулах юм шиг төр зохион байгуулах юм шиг ингэж орж ирж байгаа нь өөрөө энэ бол бас буруу. Бид бас нөгөө ухарч болохгүй гэж яриад байгаатай би санал нэг байна.



Харин төр буюу Эрүүл мэндийн яам маань бодлогоо маш тодорхой болгоод, тэгээд зохицуулалт, зохицуулалтын юмнуудаа тодорхой болгоод, тэгээд хувийн хэвшилдээ тавих хяналтаа хатуу тавиад, стандартаа мөрдүүлээд ингэж явах нь бол төрийн гол үүрэг. Харин худалдан авах үйл ажиллагаа дотор яг төрийн байгуулсан гэрээ хэлэлцээр, төр тухайн улс оронтой хийсэн тэр бодлогын түвшинд худалдаа наймааг нь хувийн хэвшлийнхэн хийгээд, харин тэр орж ирж байгаа юм нь яг бид нарын тавиад байгаа шаардлагыг хангаж байна уу, үгүй юу гэдгийг нь харин хил, гаалиас нь өгсүүлээд нөгөө цахим болгоод хяналтаа тавиад явчих нь бол зөв гэж бодож байна. Тийм учраас яг түрүүн гишүүдийн хэлсэнтэй би бол санал нэг байна. Энэ дээр бол ингэж бүр бүх зүйлүүд байна шүү дээ. Одоо 47.4 бол арай дэндүү заалтууд ороод ирчихсэн байна л даа. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45.1, 45.2, 45.4, 45.7-д заасны дагуу зохион байгуулна гэдэг чинь бүр нөгөө худалдан авах үйл ажиллагаа, нөгөө тендер шиг л юм бүр болоод явчихлаа шүү дээ. Эм дээр. Тэгэхээр энэ бол би бас буруу гэсэн гэсэн байр суурьтай байна. Харин түрүүний энд орж ирж байгаа чухал заалт бол 47.1.4-ийн тэр өрхийн эрүүл мэндийн төвийн өдрийн эмчилгээнд хэрэглэх эм, эмнэлгийн жижиг хэрэгсэл зэргийг бас чухалчилж оруулж ирж байгааг бол дэмжиж байна. Энэ үнэхээр сайн. Яагаад гэвэл өрхийн эмнэлгийн удирдлагууд энэ тэр одоо ярьж байхдаа яагаад гэвэл өдөр тутам хэрэглэдэг энэ асуудлууд дээр бид нар бас анхаарал хандуулаач гэж байгаа. Гэхдээ нөгөө эмийн зохистой хэрэглээ гэдэг бол өөрөө маш чухал шүү дээ. Тэгэхээр энэ энэ тэрээ бас бодолцох нь зүйтэй. Тэгээд энэ дээр бол саяын гишүүдийн гаргасан саналтай би бас санал нэг байна.

**П.Анужин:** Содномын Чинзориг эрүүл мэндийн сайд санал хэлнэ.

**С.Чинзориг:** Би энэ 47 дугаар зүйлтэй холбогдуулаад нэг байр сууриа илэрхийлье. Ер нь бол гишүүд ээ, эм гэдэг чинь өөрөө үндэсний аюулгүй байдалтай шууд холбоотой стратегийн бүтээгдэхүүн. Энэ стратегийн бүтээгдэхүүний 30 жил төр засаг энэ хувийн хэвшилдээ даатгаад, төрийн оролцоогүй, хяналтгүй, зохицуулалтгүй, дээр нь энэ стратегийн бүтээгдэхүүн ханган нийлүүлдэг хувийн хэвшилдээ төрийн зүгээс үзүүлдэг дэмжлэг туслалцаагүй явж ирсэн нь би бол бодлогын алдаа байсан байна гэж салбарын сайдын хувьд үзээд байгаа юм. Бид нар бензин тос, улаан буудай, эд нар дээр стратегийн бүтээгдэхүүн гээд асар их хэмжээний хүүгүй зээл олгодог, татвараас нь чөлөөлдөг, асар их дэмжлэг үзүүлдэг шүү дээ. Тэгсэн атлаа энэ хувийн хэвшил дээр стратегийн бүтээгдэхүүн болох эмийг ханган нийлүүлдэг аж ахуйн нэгжүүд дээрээ бол ийм дэмжлэг ч байдаггүй. Ингэж явж ирсэн нь бол төрийн алдаа гэж бодоод байгаа юм. Тэр утгаараа би бол өнгөрсөн жил та бүхэн санаж байгаа бол Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах хуульд өөрчлөлт оруулаад стратеги олон улсын стандарт шаардлага хангасан эмийг, эм, эмнэлгийн хэрэгслийг олон улсын үйлдвэрээс нь болон олон улсын худалдан авалтын системийг ашиглан шууд худалдан авалт хийдэг болгоно гээд хуульд өөрчлөлт орчихсон шүү дээ. Тэгсэн атлаа одоо манай Байнгын хорооны гишүүд төр өөрөө худалдан авалт хийх гэж байна. Яам өөрөө бараг л бизнес хийх гэж байгаа юм шиг ярьж байгаад нь би харамсаж байна. Яагаад ингээд жилийн дараа тэнгэр, газар шиг ингээд байр суурь нь эргэчихдэг юм. Би бол одоо энэ хуультай болсноор гол санаа нь төрийн эрүүл мэндийн байгууллагуудын ашиглаж байгаа эм, эмнэлгийн хэрэгсэл, даатгалын сангаас хөнгөлөлттэй үнээр олгож байгаа эмийг төр өөрөө тэр НҮБ-ын хүүхдийн сангийн худалдан авалтын системийг ашиглаж худалдан авалт хийдэг болъё л гэж

байгаа шүү дээ. Энэ эмийн импортын 30 хувь л байгаа юм. 30 хувиа өөрөө төр өөрөө хяналтдаа аваад, тэгээд тэр НҮБ-ын хүүхдийн сангийн худалдан авалтын системээр хийх гэж байгаа юм. Оюунчимэг гишүүн ээ. Би өөрөө тендерээ зарлаж авахгүй. Намайг тэгж хардаад байх юм байхгүй. Олон улсын худалдан авалтын системээс авах гэж байгаа юм. Бас юманд нэг жаахан учиртай хэлж байхгүй бол тэгээд ингээд хаашаа бол хаашаа ингээд савчаад байж болохгүй шүү дээ гишүүд минь ээ. Тийм учраас энэ хуучин энэ одоо бодлогоор явах нь зүйтэй. Өнгөрсөн жил нь бид нар энэ чанартай эм авъя, эмийнхээ үнийг буулгая гэхээд, одоо болохоор ингээд эргээд ханган нийлүүлэгч байгууллагуудын төлөөлөл шиг ийм юм яриад байж болохгүй. Энэ хуулийн гол өөрчлөлт амин сүнс нь энэ шүү дээ. Тийм учраас энийг гишүүд маань одоо ойлгоод, дэмжээд, хуучин саналаар нь явуулбал болмоор юм.

Чинбүрэн гишүүний хэлээд байгаа саналаар явчих юм бол энэ чинь дэндүү их хумигдчих гээд байгаа юм. Тийм учраас би тэр эм, эмнэлгийн хэрэгсэл гэдгээр явж байг. Тэгээд бид нар тэр НҮБ-ын хүүхдийн сангийн худалдан авалтын системээрээ дэлхий нийтээр үйлчилдэг асар том систем байна шүү дээ. Тэр одоо систем рүү авъя гэж байгаа юм. Зөвхөн даатгалын сангаас хөнгөлөлттэй үнээр авч байгаа эмийг НҮБ-ын хүүхдийн сангийн худалдан авалтын системээр авахад 30 хувийн үнийн хэмнэлт гарна гэсэн ийм бас тооцоо манайхан хийгээд байгаа юм. Ийм бас үр дүнтэй, эмийн үнэ буурах, чанар дээр нь ахиц гарах ийм том ажил 1 жилийн өмнө худалдан авалтын хуульд оруулж өөрчилчхөөд, одоо тэгээд энэ эмийнхээ хууль дээр болохлоороо энийгээ хумиад багалзуурдчихаж болохгүй ээ. Би гишүүдийг яагаад ийм зүйл яриад байгааг ойлгохгүй байна. Буруу ойлголт байгаа байх. Тэрнээс бол яам тендер зарлаж авахгүй. Төрийн эрүүл мэндийн байгууллагууд даатгалын

сангаас хөнгөлөлттэй үнээр олгож байгаа эмийг л авъя гэж байгаа юм.

Бид нар хэрэгцээг нь аваад, агентлаг судалгааг нь гаргаад хүүхдийн санд захиалга өгөөд. Тэгээд тэр чинь манай ганцхан хүүхдийн сан чинь манай Монголын эмийн худалдан авалтын тендер зарлахгүй юм байна лээ. Бүх дэлхий нийтийн тендерийн тогоон дотор ороод явчихаар энэ үнэ нь асар их хөнгөлөлт эдлэх юм. Тэгэхээр би бол энийг хумихгүй энүүгээр нь.../минут дуусав/

**П.Анужин:** 47 дугаар зүйл дээр зарчмын зөрүүтэй саналыг Жигжидсүрэнгийн Чинбүрэн гишүүн ирүүлсэн.

Чинбүрэн гишүүн зарчмын зөрүүтэй 2 санал гаргасан.

47 дугаар зүйл 47.1 дэх хэсгийг өөрчлөн найруулах:

47.1.нэг эх үүсвэрээс худалдан авах эм, эмнэлгийн хэрэгслийн нэр төрлийг сонгохдоо дараах зарчмыг баримтална.

47.1.1.эрүүл мэндийн байгууллагуудын тусламж үйлчилгээнд түгээмэл хэрэглэгддэг эсхүл эмийн зардалд өндөр хувь эзэлж байгаа эм, эмнэлгийн хэрэгсэл;

47.1.2.тусламж, үйлчилгээнд нэн шаардлагатай тасалдал үүсэх өндөр эрсдэлтэй эм. эмнэлгийн хэрэгсэл;

47.1.3.төрөөс төлбөрийг нь хариуцах удаан хугацааны нөхөх эмчилгээ шаардагдах эмгэгийн болон хөнгөвчлөх эмчилгээний эм.” гэсэн санал оруулж ирж байна. Санал хураалт. 44,4 хувиар уг санал дэмжигдсэнгүй.

Дараагийн зарчмын зөрүүтэй саналыг танилцуулъя. Сая чинь Байнгын хорооны гишүүдийн олонх Засгийн газрын

оруулж ирсэн хуулийн төслийг дэмжлээ шүү Чинзориг сайд аа. Сууж байна шүү.

47.5 дахь хэсгийн “сонгон шалгаруулж” гэснийг хасаж, “байгууллагыг” гэснийг “байгууллагатай” гэж өөрчлөх. Санал хураалт. Зарчмын зөрүүтэй 2 санал гаргасан юм. Чинбүрэн гишүүн энийгээ тайлбарлах. Санал хураалтыг түр цуцалъя. Чинбүрэн гишүүн өөрөө тайлбарлая.

**Ж.Чинбүрэн:** 47.5 дээр бид нөгөө дам худалдан авалтыг хийхдээ олон улсын стандарт хангасан түгээх, хадгалах, тээвэрлэх энэ зөвшөөрөлтэй байгууллагуудыг сонгон шалгаруулна гэхчхэн байгаа байхгүй юу. Тэгэхээр аливаа сонгон шалгаруулалтын ард дандаа л эрх мэдэл, ашиг сонирхол байдаг. Тийм учраас хүсэлтээ гаргаад, энэ гаалийн бүрдүүлэлтийг хийх, тээвэрлэж чаддаг, хадгалж чаддаг, түгээлтийн үйл ажиллагаа хийж чаддаг байгууллагуудад нь нэг ёсондоо эм ханган нийлүүлэх байгууллагууд нь сонгон шалгаруулахгүйгээр бүгдэд нь гэрээг оролцох эрхийг нь нээж өгөөд, тэгээд түгээх асуудлыг ярьж байгаа юм. Тийм учраас энэ сонгон шалгаруулалт гэдэг үгийг аваад хаячих. Аливаа сонгон шалгаруулалтын ард дандаа эрх ашиг явж байдаг юм. Тийм учраас ердөө л энийг сонгон шалгаруулалт гэдэг үгийг авах зарчмын зөрүүтэй санал гаргасан юм. Хүсэлт өгсөн 10 компани, 20 компани, хэд ч орсон гэсэн үнэхээр түгээгээд, хангаад, тээвэрлэж чадах л юм бол энэ Засгийн газраас гэрээг нь хийж өгөөд дам худалдан авалтыг нь хийх гэж байгаа бол тэр байгууллагууд нь аваад л, тэгээд л түгээг л дээ. Энэ шалгуурыг сонгон шалгаруулж гэдэг үгийг авах ийм зарчмын зөрүүтэй санал оруулсан юм шүү.

**П.Анужин:** Чинбүрэн гишүүн зарчмын зөрүүтэй санал оруулаа. Чинбүрэн гишүүний оруулж байгаа зарчмын зөрүүтэй санал дээр хууль

санаачлагч Засгийн газрын гишүүн Содномын Чинзориг хариулт өгье.

**С.Чинзориг:** Энэ бол Чинбүрэн гишүүний сонгон шалгаруулалт гэдэг нь байж байг ээ. Одоо тэр нөгөө гол юм чинь ерөөсөө эмийн чанар чинь гол юм чинь ерөөсөө л хадгалалт, тээвэрлэлт дээрээ ч гэсэн бас эмийн чанарт бас маш их өөрчлөлт ордог асуудлууд байдаг юм байна шүү дээ. Тэгэхээр энэ эмийн тээвэрлэлт, түгээлт, хадгалалттай холбоотой тэр ажлыг хийхдээ тэр сонгон шалгаруулах журмаар хийхгүй бол санал өгсөн байгууллага болгонд өгвөл тэгээд тэр чинь янз янзын чанарын шаардлага хангахгүй ийм газар явбал яах юм бэ. Зүгээр материал өгсөн газрууд бүгдээрэнд нь 10 газар саналаа өгвөл тэгээд л тэр чигээр нь 10-ууланд нь өг гэж байж болохгүй. Ядаж нэг сонгон шалгаруулдаг, ядаж л нэг зориулалтын автомашинтай эд нар байх тухай асуудал зөндөө яригдана шүү дээ наадах чинь. Ер нь эмийн чинь чанарын гол асуудал нь тэр хадгалалт, тээвэрлэлт, түгээлт дээрээ байдаг юм байна лээ шүү. Тэгээд л энэ дээрээ бол бид нар л анхаарах, тэр сонгон шалгаруулалт гэдэг нь уг нь байх нь зүйтэй дээ.

**П.Анужин:** Санал хураалт гишүүд ээ. Чинбүрэн гишүүний оруулсан зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулъя. Санал хураалт. 44,4 хувиар уг санал дэмжигдсэнгүй. Засгийн газрын санал дэмжигдлээ гэсэн үг Чинзориг сайд аа.

Төслийн 48 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Байхгүй байна. Санал ажлын хэсгээс ирээгүй.

Төслийн 49 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Байхгүй байна. Ажлын хэсгийн гишүүдээс санал ирээгүй.

Төслийн 50 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна

уу. Байхгүй байна. Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй 1 саналаар санал хураалт явуулна. Ажлын хэсгээс ирсэн зарчмын зөрүүтэй саналыг танилцуулъя.

Төслийн 50 дугаар зүйлийн 50.1.5 дахь заалтын “зах зээлд гаргах зөвшөөрөл олгох,” гэснийг “бүртгэх” гэж, 50.1.7 дахь заалтын “өөрчлөх” гэснийг “нэмэлт оруулах” гэж, 50.1.10 дахь заалтын “зах зээлд гаргах зөвшөөрөл” гэснийг “бүртгэл, үйлдвэрлэлийн зохистой дадал” гэж, 50.1.12 дахь заалтын “эм, зах зээлд гаргах зөвшөөрөлгүй” гэснийг “бүртгэлгүй” гэж, 50.1.17 дахь заалтын “жижиг хэрэгслийн” гэснийг “хэрэглэгдэхүүний” гэж, 50.2 дахь хэсгийн “Зах зээлд гарах зөвшөөрөлгүй” гэснийг “Бүртгэлгүй” гэж тус тус өөрчилж, 50.1.4, 50.1.6 дахь заалтын “өөрчлөх” гэснийг хасаж, 50.1.22 дахь заалтын “үйлдвэрлэхээс” гэсний дараа “хэрэглэх” гэж, 50.1.24 дэх заалтын “байгууллагаар” гэсний дараа “гэрээний үндсэн дээр” гэж тус тус нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 77,8 хувиар санал дэмжигдлээ.

Төслийн 51 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу. Ажлын хэсгийн ирүүлсэн зарчмын зөрүүтэй 1 санал бий. Саналыг уншиж танилцуулъя.

Төслийн 51 дүгээр зүйлийн 51.3 дахь хэсгийн “дүрэм, гишүүдийн ашиг сонирхлын зөрчлийн мэдүүлэг гаргах” гэснийг, 51.4 дэх хэсгийн “иргэний төлөөлөл, эрүүл мэндийн салбарын тэргүүлэх мэргэжилтнээс” гэснийг, 51.5 дахь хэсгийн “, магистраас дээш зэрэгтэй” гэснийг, 51.13 дахь хэсгийн “үндэсний” гэснийг, 51.14.4 дэх заалтын “үйлдвэрлэх” гэснийг, мөн зүйлийн 51.14.5 дахь заалтыг, 51.15.3 дахь заалтын “, эмнэлгийн хэрэгслийн нөхцөлт зөвшөөрөл олгох” гэснийг, 51.15.4 дэх заалтын “эмнэлзүйн” гэснийг, 51.16.3 дахь заалтыг, 51.18.1 дэх

заалтын “, үүргээ гүйцэтгэх чадваргүй болсон” гэснийг, 51.18.3 дахь заалтын “бүрэн эрхийн хугацаа нь дуусахаас өмнө” гэснийг тус тус хасаж, 51.4 дэх хэсгийн “захиргааны байгууллага,” гэсний дараа “эрүүл мэндийн байгууллага,” гэж, мөн хэсгийн “сургуулийн” гэсний дараа “төлөөллөөс” гэж, 51.9 дэх хэсгийн “дарга,” гэсний дараа “нарийн бичгийн даргыг шууд,” гэж, 51.18 дахь хэсгийн “хэрэгслийн зөвлөл,” гэсний дараа “түүний салбар зөвлөлийн” гэж тус тус нэмж, мөн зүйлийн 51.14.3 дахь заалтын “зах зээлд гаргах зөвшөөрөл олгох” гэснийг “бүртгэх” гэж, 51.15.5 дахь заалтын “хөрөнгө оруулалтын асуудлаар шийдвэр” гэснийг “асуудлаар төлөвлөлтийн санал” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Уг санал 77,8 хувиар дэмжигдлээ.

Төслийн 52 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Байхгүй ажлын хэсгээс зарчмын зөрүүтэй санал ирээгүй.

Төслийн 53 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу. Байхгүй бол ажлын хэсгээс зарчмын зөрүүтэй санал мөн гараагүй.

Төслийн 54 дүгээр зүйлтэй холбоотой асуулт асууж үг хэлэх гишүүн байна уу. Саналгүй бол ажлын хэсгээс зарчмын зөрүүтэй санал мөн гараагүй ээ.

Төслийн 55 дугаар зүйлтэй холбоотой асуулт асуух гишүүн байна уу. Байхгүй бол 57 дугаар зүйлтэй холбоотой зарчмын зөрүүтэй санал мөн гараагүй.

Төслийн 56 дугаар зүйлтэй холбоотой асуулт асууж, үг хэлэх гишүүн байна уу. Байхгүй бол ажлын хэсгээс мөн санал ирээгүй.

Төслийн 57 дугаар зүйлтэй холбоотой асуулт асуух гишүүн байна уу.

Байхгүй бол ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй 1 санал бий. Уншиж танилцуулъя. Санал хураалт явуулна.

Төслийн 57 дугаар зүйлийн 57.1.3 дахь заалтын “зах зээлд гарах зөвшөөрөлгүй” гэснийг “бүртгэлгүй,” гэж, 57.1.5 дахь заалтын “итгэмжлэгдсэн лабораторийн дүгнэлтэд” гэснийг “үр дүнд” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт 66,7 хувиар уг санал дэмжигдлээ.

Төслийн 58 дугаар зүйлтэй холбоотой асуулт асууж үг хэлэх гишүүн байна уу. Өөр саналтай гишүүн байна уу. Ажлын 58 дээр байхгүй байна шүү. Энд алдаатай бичсэн байна. 58 дээр санал ирээгүй ажлын хэсгээс.

59 дээр холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу. Энэ дээр бас алдаатай бичигдсэн байна. Гар дээр ажлын хэсгээс зарчмын зөрүүтэй санал ирээгүй байна шүү. Ирээгүй байна шүү. Ажлын хэсгийнхэн цохилоо.

Төслийн 60 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу. Байхгүй бол ажлын хэсгээс зарчмын зөрүүтэй 2 санал ирсэн байгаа. Уншиж танилцуулъя.

Төсөлд доор дурдсан агуулгатай 60 дугаар зүйл нэмэх:

**“60 дугаар зүйл. Шилжилтийн үеийн зохицуулалт**

60.1. Энэ хуулийн 8.1.2, 15.3.2-т заасан стандартыг дотоодын уламжлалт эмийн үйлдвэр 2029 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

60.2. Энэ хуулийн 16.14 дэх хэсэгт заасныг үйлдвэрлэх-экспортлох тусгай зөвшөөрөл эзэмшигч дотоодын үйлдвэрлэгч 2027 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжүүлнэ.

60.3. Энэ хуулийн 16.10 дахь хэсэгт заасан өнчин эмийн бүртгэлийг 2027 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хийнэ.

60.4. Энэ хуулийн 43 дугаар зүйлийн 43.3.1 дэх заалтыг 2027 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөнө.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт гишүүд ээ.

Санал хураалт 66,7 хувиар дэмжигдлээ.

Төслийн 60 дугаар зүйлийн 60.2 дахь хэсгийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 55,6 хувиар санал дэмжигдлээ.

Хуулийн төсөлтэй холбогдуулж зарчмын зөрүүтэй ирсэн санал хураалтыг явуулж, хэлэлцэж дууслаа. Одоо найруулгын чанартай санал хураалтыг хийнэ.

Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.40 дэх заалтын “бусад” гэсний дараа “хэлбэрийн” гэж, 54 дүгээр зүйлийн 54.1.2 дахь заалтын “хүний нөөц,” гэсний дараа “иргэдийн” гэж, 55 дугаар зүйлийн 55.4 дэх хэсгийн “байгууллагад” гэсний дараа “улирал” гэж тус тус нэмэх.

2.Төслийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсгийн “гурван” гэснийг “хоёр” гэж, 33 дугаар зүйлийн 33.2.1 дэх заалтын “бүртгэлд бүртгэх” гэснийг “бүртгэл” гэж, 33.2.2 дахь заалтын “жагсаалтад оруулах” гэснийг “жагсаалт” гэж, 43 дугаар зүйлийн 43.3.8 дахь заалтын, 46 дугаар зүйлийн 46.14.4 дэх заалтын “хадгалсан, ашигласан,” гэснийг “жилийн хугацаа өнгөрсөн” гэж, 45 дугаар зүйлийн 45.1.1 дэх заалтын “зах зээлд гаргах зөвшөөрөлтэй” гэснийг “бүртгэлтэй” гэж, 46 дугаар зүйлийн 46.10.11 дэх заалтын “өндөргүй, бодит” гэснийг “доогуур” гэж, 47 дугаар зүйлийн 47.1.1, 47.1.4 дэх заалтын, 47.4, 47.5, 47.6 дахь хэсгийн “жижиг хэрэгсэл” гэснийг “хэрэглэгдэхүүн” гэж, 51 дүгээр зүйлийн 51.6 дахь хэсгийн

“эрхэлсэн” гэснийг “хариуцсан” гэж тус тус өөрчлөх.

3.Төслийн 34 дүгээр зүйлийн 34.6 дахь хэсгийн “, 34.4-т” гэснийг, 40 дүгээр зүйлийн 40.1.4 дэх заалтын “байгууллагын” гэснийг, 40.1.6 дахь заалтын “байгууллагад” гэснийг, 54 дүгээр зүйлийн гарчгийн “нийгэмлэг,” гэснийг тус тус хасах. Санал хураалт. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Найруулгын санал 77,8 хувиар дэмжигдлээ.

Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай шинэчилсэн найруулгын төслийг зүйл бүрээр хэлэлцэж, зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулж дууслаа.

Одоо хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хийж эхэлнэ.

түрүүн 16 дугаар зүйл дээр Оюунчимэг гишүүн зарчмын зөрүүтэй санал гаргаж хууль хэлэлцэж дууссаны дараа энэхүү асуудлыг хэлэлцье гэсний дагуу зарчмын зөрүүтэй саналыг уншиж танилцуулъя.

Төслийн 16.12 дахь хэсэгт “5-аас доошгүй улсад” гэснийг “ нэг нь эмийн хатуу зохицуулалттай орны зах зээлд гаргадаг компанийг” гэж тодотгож оруулж өгөх гэсэн зарчмын зөрүүтэй санал оруулсан байна.

Байнгын хорооны хуулийн зөвлөхүүд манай эмийн хуульд хатуу зохицуулалттай гэсэн тийм ээ тийм нэр томъёо байхгүй учраас энийг яаж нийцүүлж оруулах вэ, нийцэж чадахгүй байна гэдэг ийм дүгнэлтийг бол өгч байна. Оюунчимэг гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй санал дээр салбарын сайд Засгийн газрын гишүүн, хууль санаачлагч Содномын Чинзориг тайлбар өгнө.

**С.Чинзориг:** Чинзориг сайд Оюунчимэг гишүүний санааг нь нэлээн

сайн ойлгож байна. Ер нь бол чанартай эм оруулж байх ёстой тэр санааг нь бол ойлгож байна. Тэгэхээр энэ асуудал чинь тэр 16.11, 16.12 эд нар дээр нэлээн сайн томъёологдоод орчихсон гэж бол бид нар бол үзээд байгаа. 1 дэх асуудал.

2 дахь асуудал чинь одоо ДЭМБ ингэдэг болчихсон юм байна Оюунчимэг гишүүн ээ. Хатуу зохицуулалт орон гэж одоо ер нь бол хэлж ярихаа больчихсон юм байна лээ. Харин тэр гүйцэтгэлийн үнэлгээгээр нь жагсаалтад оруулдаг ийм журамтай болчихсон юм байна лээ дэ. Одоо бол Солонгос, Сингапур гээд гуравхан орон тэр гүйцэтгэлийнхээ үнэлгээгээр тэр ДЭМБ-ын жагсаалтад бол орчихсон. Одоо цаана нь 80-аад орон тэр гүйцэтгэлийнхээ үнэлгээгээрээ ДЭМБ-ын жагсаалтад орох гээд ингээд саналаа өгчхөөд одоо байж байгаа юм байна лээ. Тэгэхээр манай тэр нөгөө 16.11, 16.12 дээр чинь тухайн эм тухайн үйлдвэрлэгч оронд 3-аас доош жил борлуулагдсан байх эд нар гээд юм орчихсон.

2 дугаарт тэр ДЭМБ-ын зохицуулалттай орон гээд ингээд орчихсон учраас яг таны яриад бол орчхоод байгаа юм. Яг тэр хатуу зохицуулалттай орон гэж томъёоллыг орохоор хуульд бол орохоор боломжгүй болчхоод, одоо тэр ДЭМБ бол тэр хатуу зохицуулалттай орон гэж ярихаа больчихсон. Тэр гүйцэтгэлийн үнэлгээгээр нь чанарын жагсаалт гаргадаг болчихсон юм байна лээ. Тэрэнд нь одоогийн байдлаар гуравхан орон орсон байгаа гэж байгаа юм. Тэгээд 80 орон орох гээд байгаа гэж байгаа. Тэгэхээр энийг бол яг энэ томъёоллоор оруулах, одоогийн тэр 16.11, 16.12-оор байхад би бол Оюунчимэг гишүүний яриад байгаа шаардлага бүрэн хангагдах юм байна л гэж л бид нар бодоод байгаа шүү дээ.

**П.Анужин:** Зарчмын зөрүүтэй санал гаргасан Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн санал хэлнэ.

**М.Оюунчимэг:** Чинзориг сайд аа, энэ дээр бид нар чинь эмийн чанарын тухай л яриад байгаа шүү дээ. Та ч бас хэлж байгаа. Яах вэ хууль дээр эмийн өндөр, хатуу зохицуулалттай орон гэж байхгүй. Ди эмийн зохицуулалтаар явдаг болсон гэвэл бид нар Монгол Улс шүү дээ. Хил, гаалиар орж ирж байгаа, манайд импортлож байгаа 2, 3-хан том компани гаднын тэр нөгөө үйлдвэрлэгч нь 2, 3-хан л том компани юм байна лээ шүү дээ. Тэгэхдээ борлуулж байгаа зах зээл нь ихэвчлэн СНГ-ийн орнууд юм уу, Зүүн өмнөд Азиас үйлдвэрлэсэн орнууд гаргадаг юм байна лээ шүү дээ. Бид нар бүр хэд хэдэн судалгаанаас хараад байгаа. Тэгэхээр яаж энийг оруулж өгөх вэ гэдгийг бид нар өөрсдөө оруулж тогтоож өгөх ёстой. Яг эмийн өндөр зохицуулалттай орнууд хэдийгээр хууль дээр тийм нэр томъёо одоогоор байхгүй гэж байгаа бол одоо жишээ нь Швейцараас, Японоос юм уу, Солонгосоос юм уу тэгж байх ёстой байхад оруулж ирж байгаа манай тэр импортлогчдын авч байгаа үйлдвэрлэгч нь өөрөө 4, 5 зах зээл дээр борлуулж байгаа хэр нь манай тэр нь өөрөө тэр нөгөө өндөр хөгжилтэй, үнэхээр эмийн хатуу хяналттай тийм газраас оруулж ирэх нь ховор байгаад байна шүү дээ. Бодит үнэн. Та нар ч өөрсдөө мэдэж байгаа шүү дээ дотроо. Тэгэхээр яаж энийг оруулах вэ гэдэг л байна.

**П.Анужин:** Чинзориг сайд хариулъя.

**С.Чинзориг:** Тэгэхээр энэ чанартай холбоотой эмийг бид нар 2 зохицуулалт хийж өгч байгаа шүү дээ Оюунчимэг гишүүн ээ. 16.12 дээр чинь тэр эмийн зохицуулалтын үнэлгээгээр ДЭМБ-д хүлээн зөвшөөрөгдсөн эмийн зохицуулалтын эрх бүхий байгууллагатай улсад үйлдвэрлэсэн гэдэг чинь тэр түрүүний яриад байгаа тэр чанарын гүйцэтгэлийн үнэлгээгээр чанарын тэр шалгуур хангасан байх гэдгийг тэрийг нь хэлээд байгаа юм.

2 дахь асуудал нь таны хэлээд байгаа бас үнэн л дээ. Ер нь манайд ч гэсэн би түрүүн хэлээд байсан манайд эмийн зах зээл дээр орж ирж байгаа эмийн чинь 93 хувь нь тэр женерик буюу нөгөө ерөнхий нэршлийн эм орж ирээд байгаа юм. Одоо бол бид нар тэрийг шууд бүртгэхээд байгаа. Бусад энэ өндөр хөгжилтэй орнууд, Европын орнууд тэр женерик буюу тэр ерөнхий нэршлийн эмийг бүртгэж бол хэрэглэдэг юм байна. Хэрэглэхдээ яг тэр нөгөө оригинал эмтэй нь харьцуулсан судалгаа, дүгнэлтийг нь үндэслэж тэр ерөнхий нэршлийн эмийг бол бүртгэдэг юм байна. Тэгэхээр одоо бид нар энэ хуульд чинь би яг заалтыг нь санахгүй байна. Яг тэр ерөнхий мэргэжлийн эм оруулж ирж байгаа бол тэр оригинал эмтэй нь харьцуулсан судалгаа, дүгнэлтийг нь үзэж байж бүртгэнэ гэдэг ийм зохицуулалт оруулж байгаа юм. Тэр бас яг нөгөө оригинал эмтэйгээ дүйцэхүйц хэмжээний эмийг л авна. Тэрнээс бол Женерик эм гээд ерөнхий нэршлийн эмийг бүгдийг нь бол бүртгээд байхгүй л гэсэн ийм зохицуулалт. Тэр яг заалт нь хэд байгаа билээ. Тэр заалтыг нь хэлээд өг дөө. 16.14 дээр байгаа. Яг тэр зэрэгцүүлсэн судалгаа хийнэ гэсэн юм байгаа юм.

Тухайн үйлдвэрлэсэн улсдаа 3-аас доошгүй жил бас хэрэглэсэн байна эд нар гэж юмнууд оруулчихсан байхгүй юу. Зохицуулалтууд.

**П.Анужин:** Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн.

**М.Оюунчимэг:** Саяынхыг л би хэлээд байгаа юм. Одоо орж ирж байгаа эм маань оригинал байна уу, оригинал биш байна уу, үйлчилж байгаа чанар нь тухайн үйлчлэх тэр хэмжээндээ хүрч байна уу, үгүй юу гэдэг манайд маш том асуултын тэмдэг байгаад байна шүү дээ. Энийг бүр шалгах лаборатори нь ч өнөөдөр байхгүй болчихоод байгаа учраас миний энэ аль нэг өндөр зохицуулалттай

орон гэж хэлээд байгаа юм. Тэгэхээр сая Чинзориг сайдын хэлдгээр тэр үнэхээр тэр женерик эм үү, ерөнхий нэршлийн эмүүдийг оруулж ирэхдээ оригинал эмтэй нь зэрэгцүүлсэн судалгаа байна гэх юм уу. Тэрийг нь тэгээд хаана яг бичих юм. Тэгээд энийг хэн ийм судалгааг нь хаана хийх юм. Харьцуулж харахдаа лабораторидоо л хийхгүй бол харьцуулж хараад Германд үйлдвэрлэсэн гээд орж ирсэн маань тэр яг Германы өөрийнх нь зах зээлээс авсан эмээс тэс өөр байгаад байна шүү дээ. Энэ бодит үнэн. Солонгосоос авсан эм Монголд зарж байгаа солонгос эм 2-ын харьцуулалт үйлчилгээ тэс өөр байна гэдгийг хүн өөрийнхөө эрүүл мэндээр нотолчихоод яриад байна шүү дээ. Энийг л хэлээд байгаа юм.

**П.Анужин:** 4 номерын микрофонд Оюунцэцэг дарга хариулт өгье. Одоо яг хуульд оруулж ирсэн өөрчлөлт, хуулийн зүйл заалт дээр тодорхой уншаад явъя.

**П.Оюунцэцэг:** Оюунчимэг гишүүний асуултад хариулъя. Эрүүл мэндийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Оюунцэцэг. Яг ерөнхий нэршлийн эмийн хувьд бол энэ хуулийн төслийн 16.14 дээр биоэквивалентын чанар шаарддаг ерөнхий нэршлийн эмийн тухайд биоэквивалент судалгаа хийгдсэн байна гэдэг заалтыг бид нар шаардлага дээр оруулж ирсэн байгаа.

**П.Анужин:** Оюунчимэг гишүүн үг хэлье.

**М.Оюунчимэг:** Яг саяын хэлж байгаа нөгөө нэг биоэквивалент гэдгээр нь энэ дээр тусгаж 16.14 дээр тодорхой ингэж зааж оруулж өгч байгаа бол энэ зөв. Тэгэхгүй бол одоо байхгүй байгаад байгаа нь л өөрөө нөгөө хаанаас ч юм мэдэхгүй эм оруулж ирээд байгаа учраас бид нэгэнт хууль гаргаж байгаа бол энийгээ тодотгож өгье л гэж хэлж байгаа юм.

Тэгэхдээ 16.14 дээр яах вэ найруулга дээр нь бас жаахан анхаарчихъя. Тэгээд энэ саяын гаргасан саналаа татаж байна.

**П.Анужин:** Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн төсөлтэй холбоотой ирүүлсэн зарчмын зөрүүтэй санал болон найруулгын шинж чанартай зүйлүүдийг зүйл заалт бүрээр нь хэлэлцэж дууслаа.

**Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хийнэ.**

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу. Байхгүй бол ажлын хэсгээс санал ирээгүй.

Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу. Санал мөн гараагүй.

Эм эмнэлгийн хэрэгслийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хийлээ.

**Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хийнэ.**

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбоотой асуулт асуух гишүүн байна уу. Байхгүй бол ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй 1 саналаар санал хураалт явуулна.

Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай.

1.Төслийн 2 дугаар зүйлийн 2 дахь заалтын 19.3.5 дахь заалтыг хасаж, мөн зүйлийн 2 дахь заалтын 19.3.2-19.3.4 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:



“19.3.2.эм, уламжлалт эм, биобэлдмэл, тэдгээрийн түүхий эд, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт эм, эмнэлгийн тоног төхөөрөмж, лабораторийн оношилгооны хэрэгсэл, эмнэлгийн хэрэглэгдэхүүн үйлдвэрлэх-экспортлох;

19.3.3.эм, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт эм, эмнэлгийн тоног төхөөрөмж, лабораторийн оношилгооны хэрэгсэл, эмнэлгийн хэрэглэгдэхүүн-импортлох-ханган нийлүүлэх;

19.3.4.эм болон эмнэлгийн хэрэгсэл, мансууруулах эм худалдах;” санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Анужин, Жаргалмаа, Оюунчимэг, Сарангэрэл, Чинбүрэн /цаашид “ажлын хэсэг” гэнэ./ Санал хураалт явуулъя. 66,7 хувиар уг санал дэмжигдлээ.

Төслийн 3 дугаар зүйлтэй холбоотой асуулт асуух гишүүн байна 2-ыг уншсан.

Төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Байхгүй бол ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй 1 саналаар санал хураалт явуулна.

Төслийн 3 дугаар зүйлийн “19 дүгээр зүйлийн” гэсний дараа “19.3.5,” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 77,8 хувиар санал дэмжигдлээ.

Төслийн 4 дүгээр зүйлтэй холбоотой асуулт асуух гишүүн байна уу. Ажлын хэсгээс зарчмын зөрүүтэй санал ирээгүй.

Төслийн 5 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу. Ажлын хэсгээс зарчмын зөрүүтэй санал ирээгүй.

Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн

төслийн анхны хэлэлцүүлгийг хийж дууслаа.

**Дараа нь. Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хийнэ.**

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу. Ажлын хэсгээс санал ирээгүй. Гишүүдээс санал алга.

Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу. Байхгүй. Мөн ажлын хэсгээс зарчмын зөрүүтэй санал ирээгүй.

Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хийж дууслаа.

**Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хийнэ.**

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу. Байхгүй байна. Ажлын хэсгээс санал гараагүй байна.

Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу. Байхгүй. Ажлын хэсгээс зарчмын зөрүүтэй санал ирээгүй.

Төслийн 3 дугаар зүйлтэй холбоотой санал хэлж, үг хэлэх гишүүн байна уу. Байхгүй байна. Зарчмын зөрүүтэй санал ажлын хэсгээс ирээгүй.

Төслийн 4 дүгээр зүйлтэй холбоотой үг хэлж, санал хэлэх гишүүн байна уу. Байхгүй бол ажлын хэсгээс зарчмын зөрүүтэй санал мөн ирүүлээгүй.

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай

хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хийж дууслаа.

**Байгалийн ургамлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хийнэ.**

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбоотой үг хэлэх гишүүн байна уу. Саналтай гишүүн байна уу. Байхгүй бол ажлын хэсгээс зарчмын зөрүүтэй санал ирээгүй.

Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан санал хэлж, үг хэлэх гишүүн байна уу. Байхгүй. Зарчмын зөрүүтэй санал мөн ирээгүй.

Байгалийн ургамлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хийж дууслаа.

**Зар сурталчилгааны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг.**

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбоотой үг хэлж, санал хэлэх гишүүн байна уу. Байхгүй. Ажлын хэсгээс зарчмын зөрүүтэй 1 санал ирсэн. Уншиж танилцуулъя. Санал хураалттай.

Төслийн 1 дүгээр зүйлийн 13.9 дэх хэсгийн “Эмийн” гэснийг “Эм, эмнэлгийн хэрэгслийн” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал 55,6 хувиар дэмжигдлээ.

Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулж үг хэлж, санал хэлэх гишүүн байна уу. Байхгүй байна. Ажлын хэсгээс зарчмын зөрүүтэй санал гаргаагүй байна.

Зар сурталчилгааны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хийж дууслаа.

**Зөвшөөрлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хийнэ.**

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбоотой санал хэлэх гишүүн байна уу. Асуулт асуух гишүүн байна уу. Байхгүй бол ажлын хэсгээс бэлтгэсэн 2 санал байна. Уншиж танилцуулъя. Санал хураалттай.

Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтыг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 66,7 хувиар санал дэмжигдлээ.

Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтын “Тусгай зөвшөөрөл” гэсэн баганын 13.17, 13.18, 13.19 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“13.17.эм, уламжлалт эм, биобэлдмэл, тэдгээрийн түүхий эд, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт эм, эмнэлгийн тоног төхөөрөмж, лабораторийн оношилгооны хэрэгсэл, эмнэлгийн хэрэглэгдэхүүн үйлдвэрлэх-экспортлох;

13.18. эм, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт эм, эмнэлгийн тоног төхөөрөмж, лабораторийн оношилгооны хэрэгсэл, эмнэлгийн хэрэглэгдэхүүн импортлох-ханган нийлүүлэх;

13.19.эм болон эмнэлгийн хэрэгсэл, мансууруулах эм худалдах;” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт ахиад байгаа. 66,7 хувиар уг санал дэмжигдлээ.

Төслийн 2 дугаар зүйлтэй холбоотой үг хэлж, асуулт асуух гишүүн байна уу. Байхгүй бол ажлын хэсгээс бэлтгэсэн 1 саналтай саналыг уншиж танилцуулъя. Санал хураалттай.

Төслийн 2 дугаар зүйлийн “12.1 дэх заалтын” гэсний дараа ““Эмийн” гэснийг “Эм, эмнэлгийн хэрэгслийн” гэж, мөн заалтын” гэж нэмэх. Санал гаргасан

ажлын хэсэг. Санал хураалт. 66,7 хувиар дэмжигдлээ.

Төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу. Байхгүй бол ажлын хэсгээс зарчмын зөрүүтэй 1 саналыг бэлдэж ирсэн. Танилцуулъя. Санал хураалттай

Төслийн 3 дугаар зүйлийн “13.6” гэсний дараа “, 13.7” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 66,7 хувиар санал дэмжигдлээ.

Төслийн 4 дүгээр зүйлтэй холбоотой асуулт асуух, үг хэлэх гишүүн байна уу, Саналтай гишүүн байна уу. Байхгүй. Ажлын хэсгээс ирүүлсэн санал байхгүй.

Зөвшөөрлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хийж дууслаа.

Дараа нь. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хийнэ.

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулж асуулт асууж, үг хэлэх өөр саналтай гишүүн байна уу. Байхгүй байна. Ажлын хэсгээс 1 санал ирүүлсэн.

Төслийн 1 дүгээр зүйлийн “эмнэлгийн жижиг хэрэгсэл” гэснийг “хэрэглэгдэхүүн” гэж, “эмнэлгийн жижиг хэрэгслийн” гэснийг “хэрэглэгдэхүүн” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 66,7 хувиар санал дэмжигдлээ.

Төслийн 2 дугаар зүйлтэй холбоотой үг хэлж санал хэлэх гишүүн байна уу. Байхгүй бол ажлын хэсгээс зарчмын зөрүүтэй санал ирээгүй.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд өөрчлөлт

орлуулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хийж дууслаа.

Дараа нь. Гаалийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хийнэ.

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбоотой үг хэлж, санал хэлэх гишүүн байна уу. Байхгүй байна. Ажлын хэсгээс зарчмын зөрүүтэй санал ирээгүй.

Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх гишүүн байна уу. Мөн ажлын хэсгээс зарчмын зөрүүтэй санал ирээгүй. Гаалийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг Байнгын хороогоор хийж дууслаа.

Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хийнэ.

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх гишүүн байна уу. Байхгүй байна. Ажлын хэсгээс зарчмын зөрүүтэй санал ирээгүй болно.

Төслийн 2 дугаар зүйлтэй холбоотой асуулт асууж, үг хэлэх өөр саналтай гишүүн байна уу. Байхгүй байна. Ажлын хэсгээс зарчмын зөрүүтэй санал ирээгүй.

Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг Нийгмийн бодлогын байнгын хороо хийж дууслаа.

Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хийнэ.

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбоотой зарчмын зөрүүтэй саналтай гишүүн байна уу. Үг хэлэх гишүүн байна уу. Байхгүй байна. Ажлын хэсгээс

бэлтгэсэн 1 саналыг уншиж танилцуулна. Санал хураалттай.

Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай.

Төслийн 1 дүгээр зүйлийн 6.6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “нөлөөт эм,” гэсний дараа “эмнэлгийн тоног төхөөрөмж, лабораторийн оношилгооны хэрэгсэл, эмнэлгийн хэрэглэгдэхүүн” гэж, 3 дахь хэсгийн “борлуулсан бол” гэсний дараа “зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хэрэгсэл, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж” гэж тус тус нэмж, мөн зүйлийн 2 дахь хэсгийн “биобэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл” гэснийг “эмнэлгийн тоног төхөөрөмж, лабораторийн оношилгооны хэрэгсэл, эмнэлгийн хэрэглэгдэхүүн” гэж, 4 дэх хэсгийн “Зах зээлд гаргах зөвшөөрөлгүй” гэснийг “Бүртгэлгүй” гэж, 17 дахь хэсгийн “тусламжаар төсөл, хөтөлбөрөөр” гэснийг “тусламжаар” гэж, 24 дэх хэсгийн “зах зээлд гаргах зөвшөөрөлгүй эм,” гэснийг “эм, эмийн үйлчлэгч бодис,” гэж тус тус өөрчилж, мөн зүйлийн 1 дэх хэсгийн “эмнэлгийн хэрэгсэл,” гэснийг, 4 дэх хэсгийн тайлбарын “зах зээлд гаргах зөвшөөрөлгүй,” “зах зээлд гаргах зөвшөөрөл,” “мансууруулах эм, уламжлалт эм, биобэлдмэл,” гэснийг, 10 дахь хэсгийн “лабораторийн оношилгооны хэрэгслийг Монгол Улсын эм,” гэснийг, 24 дэх хэсгийн “зохих” гэснийг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 66,7 хувиар уг санал дэмжигдлээ.

Төслийн 2 дугаар зүйлтэй холбоотойгоор санал хэлж, уг хэлэх гишүүн байна уу. Байхгүй. Ажлын хэсгээс уг зүйлтэй холбоотой зарчмын зөрүүтэй санал ирээгүй.

Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг

Нийгмийн бодлогын байнгын хороо хийж дууслаа.

Монгол Улсын Засгийн газраас өргөн мэдүүлсэн Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хийж дууслаа.

Чуулганы нэгдсэн хуралдаанд анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх Байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Ануужин танилцуулна.

14.05 цаг.

Асуудал нэмэгдэж орж ирсэн байгаа. Одоо цаглавар батлах түрүүн бид нар баталчихсан байгаа. Түүний дараа Ерөнхийлөгчөөс өргөн барьсан Алдартай одонтой ээжүүдийн хуулийн төсөл орж ирсэн. Түүний даргын зөвлөлөөр дэмжигдсэн учраас дараагийн асуудал болж орж ирсэн байгаа. Гишүүд ээ, одоо 2 асуудал хэлэлцэнэ.

Гишүүд ээ, дараагийн хэлэлцэх асуудалдаа оръё.

**Байнгын хорооны хуралдаанаар 5 дугаар сард хэлэлцэх асуудлын цаглаврыг батална.**

Та бүхэнд цаглаврын төслийг өгсөн байгаа. Тогтоолын төсөлтэй холбоотойгоор асуулт асууж, уг хэлэх гишүүн байна уу. Байхгүй бол 5 дугаар сарын Байнгын хорооны цаглаврыг баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. 55,6 хувиар дэмжигдлээ.

14.06 цаг.

Өнөөдрийн нэмэгдэж хэлэлцэгдэх асуудалд Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүхээс өргөн барьсан Одонтой ээжүүдийн талаарх хуулийн төсөл өргөн баригдсан байгаа. Энэ асуудал даргын дэргэд нэгдэх зөвлөл дээр

дэмжигдсэн учраас Нийгмийн бодлогын байнгын хороо хэлэлцэнэ.

*Хэлэлцэх асуудалдаа оръё.*

**Монгол Улсын Ерөнхийлөгчөөс 2024 оны 5 дугаар сарын 14-ний өдөр өргөн мэдүүлсэн Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхэд урамшуулал олгох тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэхийг хэлэлцэх юм байгаа юм.**

Хуулийн төслийг Байнгын хорооны гишүүдэд бүгдэд нь тараахыг хүсье. Хэвлээд бэлтгэсэн байна. Ажлын хэсгийн гишүүдийг танхимд урьж байна. Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам Ундрал, Зулхар сайд. Янгугийн Содбаатар Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга, Рагчаагийн Батрагчаа Монгол Улсын Ерөнхийлөгчийн Хууль зүйн бодлогын зөвлөх, Сархадын Зулхар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын дэд сайд, Болдын Ундрал Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн халамжийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга гэсэн бүрэлдэхүүнтэйгээр ажлын хэсэг хүрэлцэн ирсэн байна.

Хууль санаачлагч. Хууль санаачлагчийн илтгэлийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Янгугийн Содбаатар танилцуулна.

**Я.Содбаатар:** Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16.5-д Монгол Улсын иргэн нь хүүхэд төрүүлэх асрах болон хуульд заасан бусад тохиолдолд эд мөнгөний тусламж авах эрхтэй. 19 дүгээр зүйлийн 1 дүгээр хэсэгт төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүй болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна гэж тус тус заажээ.

Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эрхийг урамшуулах тухай хуулийн үйлчлэх хүрээ гэсэн 3 дугаар зүйлд энэ хуулийн үйлчлэлд 4 болон түүнээс дээш хүүхэд төрүүлж өсгөсөн, бага хүүхэд нь нэг нас хүрсэн. Энэ хуулийн 4.1.1, 4.1.2-т заасан нөхцөлийг хангасан эх хамаарна гэж заасан бөгөөд мөн хуулийн 3.2-т энэ хуулийн 3.1.1-д заасан 4 болон түүнээс дээш хүүхэд төрүүлж өсгөсөн гэдэгт бага хүүхэд нь 1 нас хүрэхэд 4 ба түүнээс дээш хүүхэдтэй байсан бөгөөд үүнд тэр үед 3 хүртэлх насанд нь үрчлэн авсан хүүхэд хамаарах ба харин эхийг нь төрүүлж бусдад үрчлүүлсэн хүүхэд хамаарахгүй гэж заасан.

Хуулийн энэхүү зохицуулалтын дагуу 6 ба түүнээс дээш хүүхэд төрүүлсэн эхэд Алдарт эхийн 1 дүгээр зэргийн одон, 4 ба түүнээс дээш хүүхэд төрүүлсэн эхэд алдарт эхийн 2 дугаар зэргийн одонг олгож байгаа бөгөөд ингэхдээ хамгийн бага хүүхэд нь 1 нас хүрэхэд 4 болон 6-аас дээш хүүхэдтэй байсан бөгөөд эдгээр хүүхдийн тоонд 3 хүртэлх насанд үрчлэн авсан хүүхдийг хамруулан олгож байна.

Ерөнхийлөгчийн Тамгын газарт иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдлыг судлан үзэхэд олон хүүхэд төрүүлсэн эхчүүдийн нийгмийн халамжийг сайжруулах, алдарт эхийн одонг авахад дэмжлэг үзүүлэх, олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж нийтдээ 4 буюу 6-аас дээш хүүхэд төрүүлж өсгөсөн бөгөөд байгалийн аюулт үзэгдэл, осол, өвчин, гэмт хэргийн улмаас нас барсан 1 ба түүнээс дээш хүү настай хүүхдийн тоонд оруулан тооцож алдарт эхийн одон олгох асуудлын саналуудыг ирүүлсэн юм. Дээр дурдсан үндэслэл, шаардлагын дагуу Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг боловсрууллаа.

Хуулийн төсөлд хуулийн үйлчлэх хүрээг өргөжүүлж 4 ба түүнээс дээш

хүүхэд төрүүлж өсгөсөн гэдэгт бага хүүхэд нь 1 нас хүрэхэд 4 ба түүнээс дээш хүүхэдтэй байсан бөгөөд үүнд тэр үед 3 хүртэлх насанд нь үрчлэн авсан эсвэл байгалийн аюулт үзэгдэл, осол, өвчин, гэмт хэргийн улмаас нас барсан 1 ба түүнээс дээш настай хүүхдийг хамруулахаар түүнчлэн холбогдох журмыг Монгол Улсын Ерөнхийлөгч батлах тухай эрх зүйн зохицуулалтуудыг тус тус тусгалаа.

Хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

**П.Анужин:** Хуулийн төслийг танилцуулсан Содоо даргад баярлалаа. Хуулийн төслийн үзэл баримтлалтай холбоотойгоор хууль санаачлагчаас асуулт асууж, үг хэлэх гишүүд байна уу. Асуулт үг хамт явна. Мөнхөөгийн Оюунчимэг гишүүнээр, Бадарчийн Жаргалмаа гишүүний нэр орохгүй байна. Ажлын хэсгийн гишүүд нэрсийн дараалалд оруулж өгөхийг хүсье. Даваажсанцангийн Сарангэрэл гишүүн үг хэлж, асуулт асууна.

**Д.Сарангэрэл:** Баярлалаа. Эхийн алдар одон бол олон талын ач холбогдолтой. Ялангуяа Монгол Улсын хүн амын бодлогод бол бас өөрийнхөө эерэг нөлөөг үзүүлж байгаа ийм бас чухал одон гэж бид үздэг. Тэгээд тойрогтоо ажиллаж байхад энэ эгч эхчүүдтэй уулзаж байхад бас энэ асуудлыг их олон жилийн турш ярьсан юм. Ерөнхийлөгчийн Тамгын газарт ч гэсэн энэ хүсэлтүүд ирсэн байх. Тэр нэг одонгийн 4 дэх хүүхдийн асуудал байнга яригдаад байгаа юм. Тэгээд сая Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Содбаатар бас яг танилцуулж байна.

4 хүүхэд төрүүлээд, 4 дэх хүү хүүхэд маань байгалийн гамшигт үзэгдэл, өвчин зовлон, осол гэмтэл гээд янз бүрийн шалтгаанаар бол бас хорвоогийн мөнх бусыг үзүүлэхэд энэ хүүхдийг нь хасаж тооцдог нь бол угаасаа үр хүүхдээ алдаад, зовлон тээж яваа эцэг эхчүүдэд бол давхар бас

одонгоос хасагдах ийм дарамт болсоор ирсэн юм билээ. Ер нь уулзалт болгон дээр энийг зөвхөн эхчүүд гэхгүй аавууд, иргэд, хөгшичүүд ч гэсэн энэ асуудлыг тавиад байдаг юм. Тэгээд яагаад ч юм бэ эхнээсээ нэг ийм журам үйлчилчихсэн юм билээ. Тэгээд олон жилийн турш яригдсан энэ асуудлыг өнөөдөр Монгол Улсын Ерөнхийлөгч, Тамгын газар шийдвэрлэж байгаа нь үнэхээр нүдээ олсон ийм зөв шийдэл болж байна гэж хамгийн түрүүнд талархан дэмжиж хүлээж авч байгаагаа илэрхийлье.

Тэгээд Содбаатар даргаас би гол асуудлуудыг л бас тодруулах гээд байгаа юм. Одоо хэрхэн яаж ойлгож болох вэ. Үрчилсэн хүүхдийн асуудал бас энэ дээр яригдаад байгаа юм. Тэгээд энэ дээр тодорхой яг ямар заалтууд орж байгаа юм. Иргэдийн хүсэн хүлээгээд байсан тэр асуудлууд өнөөдрийн энэ Ерөнхийлөгчөөс өргөн барьж байгаа хуулийн төслүүдэд хэрхэн орсон бэ. Тухайлбал үрчлэн авагдсан хүүхдүүд, дээр нь саяын нөгөө 4 дэх хүүхдийн янз бүрийн шалтгаанаар бас одонд орж чадахгүй байгаа энэ асуудлуудыг хэрхэн яаж шийдвэрлэсэн талаар энгийн үгээр тайлбарлаж өгвөл би бас иргэдэд хэрэгтэй мэдээлэл болох болов уу гэж бодох юм. Содоо дарга аа.

**П.Анужин:** Хуулийн төслийн санаачлагч Янугийн Содбаатар асуултад хариулна.

**Я.Содбаатар:** 2010 онд Монгол Улсын Их Хурал Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай гэж энэ хуулийг баталсан. Тэгээд энэ хуулийн заалтаар бол энэ хуульд ямар эх хамаарах вэ гээд ингээд тодорхой заасан. Энэ дотор бол 4 ба түүнээс дээш хүүхэд төрүүлж өсгөсөн бага хүүхэд нь 1 нас хүрсэн гээд. Тэгээд 4.1.1 гэдэг заалтаар бол энэ дараах эхчүүдийг гээд энэ дотор бол 3.2 дугаар заалтын 3.1-д заасан 4 ба түүнээс дээш хүүхэд төрүүлсэн гэдэгт бага хүүхэд нь 1 нас хүрэхэд 4 ба түүнээс дээш хүүхэдтэй байсан бөгөөд үүнд тэр

үед 3 хүртэлх насанд нь үрчлэн авсан хүүхэд хамаарна гэдгийг зааж өгсөн.

Харин эх нь төрүүлчхээд бусдад үрчлүүлбэл хамаарахгүй. Бусдын хүүхдийг 3 наснаас нь бага байхад нь үрчилж авбал хамаарахаар 1 дүгээр заалт байгаа.

2-т бол сая бид нар ямар заалт нэмэгдүүлж байна вэ гэхээр тэр үрчилж авсан хүүхэд гэдгийн дараа байгалийн аюулт үзэгдэл, осол, өвчин, гэмт хэргийн улмаас нас барсан хүүхдийг нь бол тооцдог байя. Нэгтээ 10 сар тээж төрүүлээд, тэгээд тодорхой насанд хүртэл бас ингэж өсгөж бойжуулж байсан учраас эхчүүдийнхээ энэ юуг бол үнэлэх ёстой юм байна гэж ингэж үзээд ийм заалтыг бол нэмж оруулж байгаа юм. Тэгэхээр үрчилж авсан хүүхэд гэдэг дотор бол 3 хүртэлх насанд нь 3-аас бага нас байхад нь үрчилж авсан нь орно гэсэн үг.

Одоо нэмээд байгалийн аюулт үзэгдэл, осол, өвчин, гэмт хэргийн улмаас нас барсныг нь оруулья гэдэг ийм заалт л орж өгч байгаа юм.

**П.Анужсин:** Сарангэрэл гишүүн тодруулж асууя.

**Д.Сарангэрэл:** Саяын хариулт бол их тодорхой байна. Содбаатар дарга аа, энэ хуулийн төсөл дээр мөнгөн тусламжийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай гэж орж ирэх юм. Энэ дээр ямар өөрчлөлт орох билээ.

**П.Анужсин:** Содбаатар дарга хариулт өгье.

**Я.Содбаатар:** Тэгэхээр энэ хуулийн өөрчлөлт бол өөрөө ер нь олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай энэ хууль бол нөгөө одонтой ээж гээд, тэгээд одонгийн урамшуулал одонтой эх болонгуут, алдарт эхийн одон авангуут жил болгон урамшуулал өгдөг. Мөнгөн урамшуулал. Тэгээд энэ

мөнгөн урамшуулал өгдөг учраас энэ өөрөө цаанаа төсөвтэй холбоотой. Өнөөдөр Монгол Улсын хэмжээнд 300-аад мянган эх энэ одонтой ээж буюу мөнгөн урамшуулал авч байгаа. Жилийн урамшууллаа. Тэгэхээр энэ хүрээнд явж байгаа учраас төсөвтэй холбоотой байсан учраас энэ хууль бас нэлээн ингэж тооцоо судалгаа хийж парламентад орж ирэхгүй жсоохон удсан юм байна гэж.

2-т бол бид нар энэ удаа Монгол Улсын Ерөнхийлөгч санаачлаад Олон хүүхэд төрүүлсэн эхийг урамшуулах тухай хуульд заасны дагуу байгаа энэ одонтой ээжүүдийнхээ жилд авдаг урамшууллийг 2 дахин нэмэгдүүлэх саналыг гаргасан. Энийгээ Засгийн газраас саналыг нь аваад Улсын Их Хуралд өргөн барих гэсэн, тэгээд Улсын Их Хурал бол яах вэ нөгөө төсөвтэй холбоотой юмыг зөвхөн Засгийн газар өргөнө гэдгээр ирэх 7 хоногийн Байнгын хороогоор Засгийн өргөн барьсан нэрээр орж ирж батлагдах байх гэж ингэж найдаж байна.

**П.Анужсин:** Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн асуулт асууна, үг хэлнэ. Хамт.

**М.Оюунчимэг:** Таатай мэдээ байна. Энэ олон хүүхэдтэй ээжид олгодог урамшууллыг 2 дахин нэмэгдүүлнэ гэж байна. Одоо авч байгаа нь бас яах вэ төрийн хишиг гэж яриад авдаг. Тэгээд 2 дахин нэмэгдүүлж байна гэдэг бол бас их чухал заалт байна. Тэгээд олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулахад тухай энэ нь өөрөө хүний эрхийн зөрчил, ялгаварлал, зөрчигдөж байгаа эрхийг бас ингэж залруулж Үндсэн хуулиар олгогдсон эрхээ эдлэх боломжийг оруулж ирж байгаа учраас 100 хувь дэмжиж байна. Саяхан л хоёрхон хоногийн өмнө тойрогтоо ажиглаж байхад яг ийм ээж бас Ерөнхийлөгчийн нөгөө алдарт эхийн одон гардуулах арга хэмжээнүүд болно. Үүнээс өмнө энийг зохицуулах бололцоо байгаа болов уу гэж асууж байсан юм. Тэгээд би

Монгол Улсын Ерөнхийлөгчийн зүгээс бас энэ хуулийн төслийг өргөн барьж байгаа гэж ярьж байсан. Тэгэхээр одоо энийг бид нар энэ удаагийн арга хэмжээнээс өмнө батлаад гаргачихвал энэ ээжүүд хамрагдах уу. Тэр асуултыг нь өөр зүйлгүй ээ.

**П.Анужин:** Оюунчимэг гишүүний асуултад Содбаатар дарга хариулт өгье.

**Я.Содбаатар:** Тэгэхээр энэ жилийн одоо Алдарт эхийн 1, 2 дугаар одон авч байгаа ээжүүдийн өргөдлийг бол аваад дууссан. Хугацаатай байдаг хуулийн дагуу. Тэрэнд бол хамаарагдахгүй гэсэн үг. Гэхдээ ирэх жил тэр хүмүүс өргөдлөө өгөх юм нь нээлттэй байгаа юм. Нээлттэй байгаа. Тэгэхээр одоо Монгол Улсын хэмжээнд энэ хууль гарах юм бол 2 дугаар зэргийн одон нөхөж авах 8463 ээж байна. 1 дүгээр зэргийн одон нөхөж авах 1932 ээж байна. Тэгэхээр эд нарт бол ирэх жил энэ өргөдлөө өгөөд тэгээд хамрагдана гэсэн үг. Нэг ёсны таны ярьж байгаа тэр эх бол ирэх жил хамрагдана гэсэн үг байхгүй юу. Энэ одонтой ээжүүдийн энэ юу нь бол өөрөө өргөдлөөр ингэж би юугаа авъя, одонгийн ийм шаардлагыг хангаж байна гээд тухайн засаг захиргааныхаа байгууллага дүүрэг, нийслэл, сум, аймгуудаараа дамжиж өргөдөл нь гардаг учраас бид нар энийг нөхөн олгох боломжтой гэж ингэж үзэж тооцооллыг нь хийсэн юм.

2-т бол тэр олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийн энэ одонтой ээжүүдийнхийг нь бол 1 дүгээр зэргийн одонтой жилд 200 мянган төгрөг, 2 дугаар зэргийн одонтой бол 100 мянган төгрөг авч байгааг бид нар 2 дахин нэмэгдүүлээд 2 дугаар зэргийн одонтой нь 200 мянга, 1 дүгээр зэргийн одонтой нь 400 мянган төгрөг авдаг болох зүйлийг Засгийн газарт саналаа хүргүүлээд, Ерөнхийлөгч санаачлаад явж байгаа юм гэдгийг тодотгож хэлье.

**П.Анужин:** Бадарчийн Жаргалмаа гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

**Б.Жаргалмаа:** Баярлалаа. Юуны өмнө бас Монгол Улсын Ерөнхийлөгчөөс, Ерөнхийлөгчийн Тамгын газраас олон ээжүүдийн хүсээж хүлээж байгаа, гишүүдээр уламжлуулан өгч байсан санал, олон жилийн туршид ярьж байсан энэ санал бас ийнхүү хууль болоод орж ирж байгаад бас талархлаа илэрхийлье. Ер нь бол бас хүүхдээ алдсан, хүүхэд нь эндсэн гэдэг юм уу энэ байдлаас шалтгаалан одондоо хамрагдаж чаддаггүй, энэ хөтөлбөрт хамрагдаж чаддаггүй ээжүүд маш олон байдаг. Тэгээд сая бас нэг зүйлийг тодрууллаа. Сарангэрэл гишүүн тодруулсан. Би дахиад тодруулаадахъя гэж бодож байна. Яагаад гэвэл ийм кэйсүүд маш их байдаг. Бага насны хүүхэд нь 1 нас хүрээгүй байхад өмнөх 3 хүүхдийнх нь аль нэг нь эндчихсэн бол 3 хүүхэдтэй гээд л тоологдчихоод байгаа шүү дээ. Тийм ээ. Энийг л бид нар 4 болгоё гэж тооцож ингэж ойлгоод байгаа. Өөрөөр хэлэх юм өмнөх 3 хүүхэд нь хэдэн настай ч байсан хамаагүй бага насны хүүхэд нь нэг хүрчих юм бол 4 байна гээд л тооцоод л одон нь олгогдоод явах нь ээ. Нөгөөтээгүүр цалинтай ээж хөтөлбөрийн тухай бас ярьдаг. 50 мянган төгрөг өгдөг. Энийгээ нэмээч ээ, инфляцтай уялдуулаач ээ. Энэ бол зөвхөн дэмжлэг, тэтгэлэг гэхээс илүүтэйгээр улсад орж байгаа хөрөнгө оруулалт, хүн амын хөрөнгө оруулалт, хүн амын хөгжил гээд тооцож үздэггүй юм уу гэдэг ээжүүдийн хүсэлт маш ихээр байдаг. Энэ дээр ер нь ямар бодолтой байдаг юм бол. Нөгөөтээгүүр хүүхдийн тоогоор мөнгө өгөх үү гэдэг зүйлийг бас хүмүүс асуудаг. Өөрөөр хэлэх юм бол 4 хүүхэдтэй сая Содбаатар дарга ярилаа шүү дээ. 1 дүгээр зэргийн одонтой ээж 200 мянга, 2 дугаар зэргийн одонтой ээж 100 мянган төгрөг авч байгаа гээд. Үүнийг нэмэх гэж санал оруулж ирж байгаа юм байна. Ер нь хүүхдийн тоогоор нэмбэл бид бас энэ хүн амын өсөлтөд анхаарах ёстой юм биш үү гэдэг



ийм санал бас яригддаг. Энэ дээр ямар нэгэн санал байгаа юу, үгүй юу гэдгийг бас тодруулъя.

**П.Анужин:** Содбаатар дарга. Хүүхдийн мөнгө хэрэгжиж байгаа шүү дээ. Монгол Улсын хүүхэд нэг бүрд. Үүн дээр нэмэгдээд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам хариулах уу, Содоо дарга хариулах уу, яам хариулах уу. Цалинтай ээж хөтөлбөрийг асууж байна шүү дээ Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам хариулсан нь дээр байх. Дэд сайд Зулпхар.

**С.Зулпхар:** Жаргалмаа гишүүний асуултад хариулъя. Цалинтай ээж хөтөлбөрийг боловсронгуй болгох чиглэлээр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам дээр сайдын тушаалаар ажлын хэсэг байгуулагдсан. Ирэх жилийн төсөвтэй уялдуулаад бид бол саналаа боловсруулсан байгаа. 1 дүгээрт цалинтай ээжийн олгож байгаа мөнгөн хэмжээг нэмэгдүүлэх чиглэлээр, 2 дугаарт бол энийг ер нь олгох зохион байгуулалтын хэлбэрийг боловсронгуй болгох чиглэлээр ийм санал боловсруулсан байгаа. Тэгэхээр зэрэг төсөв хэлэлцэх үеэр энийг тухайлан танилцуулна.

**П.Анужин:** Асуулт авч дууслаа. Асуултад хариулт авлаа.

Одоо Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхэд урамшуулал олгох тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг үзэл баримтлалын хувьд дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 77,8 хувиар уг санал дэмжигдлээ.

Байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд илтгэх гишүүнээр Монгол Улсын Их Хурлын гишүүн Мөнхөөгийн Оюунчимэгийг томилж байна. Өнөөдрийн Байнгын хороогоор хэлэлцэх асуудал дуусах байна.

Дүгнэж хэлэхэд өнөөдөр Цэргийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах

тухай хууль, Ахмадын хууль, Эм, эмийн хэрэгслийн тухай хууль, Одонтой ээжүүдийн хуульд өөрчлөлт оруулах тухай хууль гээд олон хуулийг хэлэлцэж дууслаа. Өнөөдөр бид нар Эм, эмнэлгийн хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хийлээ. Эмийн түр хороонд бас хэлэхэд Чинбүрэн гишүүнээр ахлуулсан эмийн түр хороо ажилласан.

Эмийн түр хороо Монгол Улсын Засгийн газарт дүгнэлт, Түр хороонд санал дүгнэлтээ бол хүргүүлсэн байгаа. Монгол Улсын Засгийн газарт. Энэ түр хороо бол маш сайн ажилласан. Энэ түр хорооны гаргасан 11 хуудас бүхий 16 саналыг энэ Эм, эмнэлгийн хэрэгслийн хуульд бол тодорхой бас тусгасан. Энэ бол бас эмийн түр хорооны ажилласан ажлын бас том үр дүн. Хуульдаа бол тусгуулж чадлаа. Тэгээд энэ түр хороог бас маш сайн удирдан зохион байгуулж сайн ажилласан Жигжидсүрэнгийн Чинбүрэн гишүүн, Монгол Улсын хүний гавьяат эмч. Энэ бүрэлдэхүүнд бас манай Байнгын хорооны гишүүд сайн ажилласан. Бадарчийн Жаргалмаа гишүүн, Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн гээд Нийгмийн бодлогын байнгын хорооны олон гишүүд Эмийн түр хороонд бол сайн ажилласны үр дүнд энэ хуульд бас хэдийгээр яаралтай горимоор өргөн баруулсан ч гэсэн саналыг бол хангалттай тусгуулж ажилласан ийм амжилттай ажилласныг Байнгын хорооны даргын хувьд бас цохон тэмдэглэж байна.

Өнөөдрийн байнгын хорооныхоо хуралд идэвхтэй оролцсон эрхэм гишүүд та бүхэндээ баярлалаа. Байнгын хорооны хуралдаан өндөрлөж байна.

14.22 цаг.

**Дууны бичлэгээс буулгасан:**  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ  
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ